

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт					
Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар					
2024 оны жилийн эцэс					
Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ
МУ-ын хууль					
1	1	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ 2003-05-30 Дугаар 2003_01	15.2.3. Бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах;	Улсын төсвөөс эрх шилжсэн төсөл арга хэмжээнээс 9 ажлын нийт 21,9 тэрбум төгрөгийн гэрээг байгуулснаас 4 төсөл арга хэмжээ 100% дууссан. 5 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжихээр төсөв нь батлагдсан. Гүйцэтгэл 10-51 хувьтай явагдаж байна. Үүнд: 1.Замын-Үүд сумын төвийн 2,15 км авто замын шинэчлэл хийх-100% дууссан 2.Сайншанд сумын 7 дугаар багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажил-30% 3.Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх-100% дууссан 4.Замын-Үүд суманд ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан барих ажил-100% дууссан 5.Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдад ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус худалдан авах ажил-90% 6.Дорноговь аймгийн Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамжийн ажил-БАГЦ-1-100% дууссан, БАГЦ-2 гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. 7.Дэлгэрэх суманд Соёлын төвийн барилга барих ажил-30% 8.Дулааны станцын өргөтгөл барих ажил-10% 9.Шинэ хөдөө төслийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Улсын төсвийн санхүүжилтээр нийт 9 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Сангийн яамны pimis.publicinvestment.gov.mn системд шивж төлбөрийн хүсэлт үүсгэснээр 17,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100%
	2		15.2.4.. бүс нутгийн хөгжлийн талаар хийж байгаа ажлын үр дүнг Зөвлөлд тайлагнах;	Бүрэн хэрэгжсэн.	100%
2	3	ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2011-12-23 Дугаар 2015-10	14.2.11. Төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;	2024 онд төсвийн 46 байгууллагад төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, 14 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит тус тус хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 538,2 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн 191 акт тогтоон, 8 албан шаардлага бичиж, 223,2 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан.	100%
3	4	Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03	39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана.	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны "Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 15/08 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардалд 2.0 тэрбум төгрөг тусгаж, тайлант хугацаанд аймгийн хэмжээнд тохиолдсон зудын эрсдэлийг бууруулах, тэмцэх үйл ажиллагаанд бүрэн зарцуулаад байна. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар захирамжаар "Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ"-г зохион байгуулахад зарцуулах зорилгоор 16.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Монгол Улсын Шадар Сайдтай аймгийн Засаг даргын 2024 онд байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар захирамж, Онцгой байдлын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дэлгэрэх, Улаанбадрах, Замын-Үүд сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулан ажилласан.	100%
	5		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)	Олон улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг Хүүхдийн эрхийг дээдэлбье, гэр бүлийн дундах эерэг харилцааг нэмэгдүүлэх нь, Гэртээ эрт харья уриалгын хүрээнд спортын арга хэмжээ, гар зургийн уралдаан, хүүхдийн чуулган, гэр бүлийн уулзалт ярилцлага, "Гэртээ эрт харья" цахим чөлөөлж зэрэг 43 төрлийн нөлөөллийг ажлыг зохион байгуулан давхардсан тоогоор 1500 иргэнийг хамруулсан. Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосрудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих нь, амьдрах ухааны, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагын албан хаагч болон иргэд рүү чиглэсэн 78 удаагийн сургалтад нийт 2900 иргэн, Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн үнэ цэнэ зэрэг 44 төрлийн гарын авлагыг бэлтгэж 3305 өрхөд хүргэсэн. Нийт 123 төрлийн сургалт, арга хэмжээнд 4500 гаруй иргэнийг хамруулсан. 44 төрлийн гарын авлагыг 3305 иргэнд хүргэсэн. Өмнөх оноос гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 2.1 хувиар өссөн.	100%

6		<p>19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч байгууллага, албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн сургалт, сумдын хамтарсан багийн сургалтыг зохион байгуулж аймгийн 32 байгууллага, 14 сумын нийт 118 албан тушаалтан хамрагдсан. Сум, багийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллах чиг үүрэг бүхий хамтарсан багийн гишүүдийг мэргэжил, арга зүйн хувьд нарийн мэргэшүүлэх, кейс менежментийн зарчим, алхмын дагуу чанартай хамгааллын үйлчилгээг хүүхэд, гэр бүлд үзүүлж сургах зорилгоор "Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө "Галт шувуу холбоо" ТББ-ын гүйцэтгэх захирал, Хүүхэд хамгааллын зөвлөх багш Э.Дуламсүрэнтэй хамтран аймгийн 27 хамтарсан багийн 81 гишүүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд кейс менежментийн үйлчилгээний үе шатын дагуу хохирогчдод хамгааллын үйлчилгээг үзүүлэх талаар нэгдсэн ойлголттой болж, хамтарсан багийн гишүүд нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллахад шаардлагатай маягт дээр ажиллаж сурсан. "Дэлхийн зөн Монгол" Олон улсын байгууллагаас "Зудын яралтай хариу арга хэмжээ 2" төслийг хэрэгжүүлж Айраг, Алтанширээ, Иххэт, Даланжаргалан, Дэлгэрэх сумдын хамтарсан багийн 30 гишүүдэд "Гамшгийн үеийн жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт"-ыг зохион байгуулж гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, орон нутгийн түвшинд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан</p>	100%
7		<p>19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Сайншанд, Замын-Үүд суманд түр хамгаалах байр үйл ажиллагаагаа явуулж байна. Орон нутгийн төсвөөс 2024 онд түр хамгаалах байрны үйл ажиллагаанд 90.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцсийн байдлаар 23 иргэнд хамгааллын үйлчилгээ үлүүлсэн.</p>	100%
8		<p>19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн хүрээнд хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, "Асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг арга, угийн бичиг хөтөлхийн ач тусын талаар Сайншанд сумын 1500 гаруй иргэдэд мэдээлэл өгсөн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Эрдэнэ сумын Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн нийт 90 алба хаагч нарт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг оролцоо, хүүхдийн хөгжил, оролцоо, гэр бүлийн харилцаа, харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс зэрэг сэдвээр сургалт мэдээлэл хүргэж албан хаагчид, хугацаат цэргүүдэд бүлгийн ярилцлага хийн, гэр бүлийн хосуудад хосын карт ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Шүүхийн Тамгын газартай хамтран гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын сэтгэл зүйчийн уулзалтыг зохион байгуулан, 12 гэр бүлийг мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулсан. Гэр бүлийн асуудлаар маргаантай 9 өрхөд шинжээчийн дүгнэлтийг гарган Шүүхэд хургуулан ажилласан. Гэр бүлийн боловсролын 4 удаагийн 10 төрлийн сургалтад 50 гэр бүлийг хамруулан эцэг эх асран хамгаалагч нарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, хосын эерэг харилцаа, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээсэн. Энэ онд гэрлэхийн өмнөх боловсрол олгох зорилгоор шинээр гэр бүлээ батлуулсан 52 хосод гэр бүлийн тухай хууль, жендерийн тэгш байдлын талаар зөвлөгөө өгсөн. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн</p>	70%
4	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01</p>	<p>19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Аймгийн хэмжээнд хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэн ажиллаж буй 7 сум байна. Сайншанд суманд дахь Түр хамгаалах 2 байраар 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 23 иргэн хамгааллын үйлчилгээнд хамрагдсан. Үүнээс насанд хүрээгүй хүн 18 (90%) эзэлж байгаа бөгөөд 55,5 хувь нь үл хайхрах хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдүүд бөгөөд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 3 насанд хүрээгүй хохирогч байна. Сайншанд сумын түр хамгаалах байрны хүний нөөц, үйл ажиллагаанд 90.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн "Түр хамгаалах байр" нь 2018 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ явуулан ажиллаж байна. 2024 онд түр хамгаалах байранд засвар үйлчилгээ хийх, хохирогчийг тав тухтай байх орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр тус аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн 12 дугаар хуралд 1 танилцуулгыг хүргүүлэн 11.3 сая төгрөгийн төсөв шийдвэрлэсэн. Сум тус бүр эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд гэр бүлд үзүүлэх үйл ажиллагааны зардлын төсвийг батлан аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 38,9 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	100%
9				

10		<p>19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн ХГБХХГ болон Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын зүгээс гэр бүлийн зөрчил маргаан, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхээр нийт 110 иргэний гомдол, мэдээллийг хүлээн авч сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгч, гэр бүлийн боловсрол олгох арга хэмжээг зохион байгуулж бага насны хүүхдийг гэр бүл салалтаас үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн. Гэр бүлийн зөвлөгөөг өгөх өрөөгөөр 13 кейсийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Аймгийн хэмжээнд 2 түр хамгаалах байраар нийт 19 насанд хүрээгүй иргэнийг буюу бэлгийн хүчирхийллийн 3, үл хайхрах хүчирхийллийн 11, бие махбодын хүчирхийллийн улмаас хохирсон 1, насанд хүрсэн 2 хохирогчийг хүлээн авч, хууль эрх зүйн зөвлөгөө, өмгөөлөл, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээ, харуул хамгаалалт, хоол хүнс, ахуйн хэрэглээг хангахад 87,0 сая төгрөгийг зарцуулсан. Түр хамгаалах байраар хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсан нийт хүүхдүүдийн 97.8 хувь нь гэр бүлдээ эргэн нэгтгэгдэж хэвийн орчинд амьдрах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ гэр бүлийн орчин дахь эрсдэл буурсан бөгөөд байнгын эргэлт хяналтыг тавьж хэвшсэн. Одоо түр хамгаалах байраар үл хайхрах хэлбэрийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхэд үйлчлүүлж байна.</p>	100%
11		<p>19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Төр болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн харилцаа хандлагын чиглэлээр сургалт мэдээлэл явуулдаг, гэр бүл судлаач лектор Ж.Баясгалангийн "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт соён гэгээрүүлэх сургалтад төвийн 7 багийн эрсдэлт нөхцөлд амьдардаг 21 өрхийн гишүүнийг хамруулсан. Мөн сум, багийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллах чиг үүрэг бүхий хамтарсан багийн гишүүдийг мэргэжил, арга зүйн хувьд нарийн мэргэшүүлэх, кейс менежментийн зарчим, алхмын дагуу чанартай хамгааллын үйлчилгээг хүүхэд, гэр бүлд үзүүлж сургахад дадлагажуулсан сургах, маягт дээр ажиллаж сурах буюу баримтжуулж сургах зорилгоор "Галт шувуу холбоо" ТББ-тай хамтран хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 27 хамтарсан багийн төлөөлөл 80 гаруй гишүүнийг хамруулсан. Сургалтын үр дүнд кейс менежментийн үйлчилгээний үе шатын дагуу хохирогчдод хамгааллын үйлчилгээг үзүүлэх талаар нэгдсэн ойлголттой болж, хамтарсан багийн гишүүд нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллахад шаардлагатай маягт дээр ажиллаж сурсан.</p>	100%
12		<p>19.1.8.. Гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.)</p>	<p>Тус цагдаагийн газраас 2024 оны 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлгүй гэр бүл", "Сурагчдын дотуур байр", "Хамтдаа сэргийлье", "Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдөр", "Дээрлэхэл дэлгэрэх ёсгүй", "Зуслан", "Хайр хязгааргүй ялгаагүй", "Хичээл эхэллээ", "Дотуур байр", "Хүүхэд хамгаалал-2024" зэрэг соён гэгээрүүлэх 10 тусгай арга хэмжээг санаачлан зохион байгуулан ажиллан биелэлт, үр дүнг тооцож ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 сургуулийн 22 "School police" эргүүлийг тус цагдаагийн газрын тухайн өдрийн жижүүрийн бүрэлдэхүүний томилгоот 40 чиглэлд 132 эцэг, эхчүүдийн хамт сургуулийн орчимд хичээл эхлэх, тарах цагаар өдөр бүр замын хөдөлгөөний ачаалал ихэсдэг 10 цэгүүдэд хуваарилан эргүүлийн үүрэг гүйцэтгэн хяналт тавин ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн орчинд хуваарийн дагуу 2 ээлжээр эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн мэргэжил арга зүйгээр ханган хяналт тавин ажилласан. Ерөнхий боловсролын сургуулиудын өсвөрийн сэргийлэгч нарт 60 ширхэг хантаазны 2.0 сая төгрөгийн төсвийг батлуулан шийдвэрлүүлж хантаазыг сургуулийн захиргаанд хүлээлгэн өгч өсвөрийн сэргийлэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Мөн "Өсвөрийн сэргийлэгч-2024" тэмцээнийг зохион байгуулж 1.0 сая төгрөгийг</p>	70%
5	13	<p>Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06</p>	<p>43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>Улс орон даяар өрнөсөн "Шинэ-хоршоо хөдөлгөөн"-ий нээлтийн арга хэмжээ болон сургагч багш балтгах сургалт, бүсийн сургалт гэх мэт 4 удаагийн арга хэмжээнд 14 сумын 450 гаруй малчид, хоршооны төлөөллийг хамруулан мэдээ, мэдээллээр ханган ажилласнаас гадна "Шинэ-хоршоо" хөдөлгөөний аймгийн дэд ажлын хэсэг, Засгийн газраас томилогдсон сургагч багш нар 14 суманд ажиллаж хоршооны талаар дэлгэрэнгүй мэдээлэл, нэг цэгийн үйлчилгээг үзүүлэн ажилласан. "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулснаар аймгийн хэмжээнд 176 хоршоо шинээр байгуулагдаж, 1698 малчин хоршоонд бүртгүүлж, 404 хоршооны гишүүн малчин 14,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шийдвэрлүүлсэн үр дүн гарсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/26 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн загвар хоршооны зээлийн өрөнхий нөхцөл баталсны дагуу орон нутагт түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон хөнгөлөлттэй зээлд Алтанширээ сумын "Олон ширээ", Даланжаргалан сумын "Боржигон туяа" хоршоод хамрагдан нийт 590,0 сая төгрөгийн санхүүжилт авч арьс шир, түүхий эд боловсруулах үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.</p>	100%

6	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	14	10.1. Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Чандмань-Илч ОНӨХХК, "Дорноговь орон сууц" ОНӨААТҮГ, "Хамарын хийд тусгай хамгаалалттай газрын захиргаа" ОНӨААТҮГ, "Говь консалтинг менежмент" ОНӨААТҮГ, Замын-Үүд нийтийн аж ахуй" ОНӨХХК, "Борхойн баян бүрд" ОНӨААТҮГ газар, "Дагшин эрдэнэ" ОНӨААТҮГ гэсэн 7 орон нутгийн өмчит байгууллагын гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдад олгох нийтлэг цалин хөлсний жишгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, хөдөлмөрийн тухай хуулийг мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоосон.	100%
		15	13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах, 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	Хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан цуцлагдсан арга хэмжээ байхгүй болно.	Х.Б
		16	8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. (Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй)	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан байгууллага байхгүй болно.	Х.Б
		17	14.2. Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	Захиалагчаас Худалдан авах ажиллагааны газарт тухайн жилд худалдан авах 10.0 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт ирүүлээгүй.	Х.Б
		18	14.4. Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.	Аймгийн хэмжээнд цахим дэлгүүрээс худалдан авалт хийх ажил зохион байгуулагдаагүй. Улсын хэмжээнд эрүүл мэндийн салбар цахим дэлгүүрийн үйл ажиллагааг зохион байгуулан хэрэгжүүлж байна.	Х.Б
		19	14.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт 18 төсөл арга хэмжээний 49.8 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд Орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах 11 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар 11 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Мөн Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 69.06 тэрбум төгрөгийн 136 төсөл, арга хэмжээ батлагдаж, аймгийн Засаг даргын Тамгын газраас 465.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нэмэгдэж ирсний дагуу 2024 оны аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөөг боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах 64 төсөл арга хэмжээнээс 64 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Сумд болон байгууллагууд руу 77 төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлснээс 67 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж 98.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. /9 төсөл арга хэмжээ нь нууцын байгууллага руу шилжсэн/	100%
		20	15.2.1. Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; (15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана)	Аймгийн 9 сумын ус, дулаан хангамжийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг "Чандмань-Илч" ОНӨХХК жилийн эцсийн байдлаар эрчим хүч хэмнэх ажлын хүрээнд 20 ажилд 157.3 сая төгрөг зарцуулж 95.7 сая төгрөг буюу 469360кВт ц эрчим хүч хэмнэсэн.	100%
		21	15.2.2. Нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Аймгийн хэмжээнд 10 аж ахуйн нэгж байгууллага дулааны тоолуур суурилуулан үйл ажиллагаанд ашиглаж байна.	70%
		22	15.2.4. цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилгагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх;	"Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 19 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор нийт 2400 албан хаагчийг хамруулсан. Аймгийн хэмжээнд тоон гарын үсгийг төрийн 46 байгууллагын 450 албан хаагч албан хэрэгцээндээ ашиглаж байгаа бөгөөд шинээр 41 байгууллага, 300 албан хаагч авсан нь өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна. Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт 15167 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон. Тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг үр чадварыг дээшлүүлэхээр "И-Монгол академи"-ийн УТҮГ, Улсын бүртгэлийн газартай хамтран "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийг сурталчлах ажлыг төрийн 1600 албан хаагч, 52 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 13331 иргэнийг хамруулан зохион байгуулсан.	70%
		23	15.2.7. сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.	"Тайлант онд аймгийн хэмжээнд амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулсан сургалт байхгүй бөгөөд Засгийн газар, яамд болон Удирдлагын академис зохион байгуулдаг богино хугацааны танхимын сургалтуудад албан хаагчдыг унааны болон томилолтын зардлыг шийдэж хамруулдаг. Удирдлагын академийн эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 23, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 28 албан хаагчийг тус тус хамруулан мэдлэг үр чадварыг дээшлүүлсэн. Мөн удирдлагын академийн сургагч багшийн сургалтад 4 албан хаагчийг хамруулсан. Нийт 77 төрийн захиргааны албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна. Тус сургалтууд цахимаар хичээллэдэг тул томилолтын зардалд санхүүжилт зарцуулаагүй.	100%

	24		15.2.5. хуваарь болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;	2023 оны орон нутгийн орлого бүрдээгүйгээс үүссэн хөрөнгө оруулалтын өр төлбөрийг 2024 оны орон нутгийн төсөвт бүрэн тусган нийт 5.3 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.	100%
7	25	Үндэсний их баяр наадмын тухай /шинэчилсэн найруулга/ 2022-06-28 Дугаар 2022.06.28	5.4. Энэ хуулийн 5.3-т заасан нөхцөлд аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх хугацааг 08 дугаар сарын 10-ны өдрөөс хэтрүүлэхгүй байхаар тогтооно. (5.3.Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан энэ зүйлийн 5.2-т зааснаас өөр өдрүүдэд улс, аймаг, сумын баяр наадмыг тэмдэглэх бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтооно.)	Аймгийн Засаг даргын 2024 оны А/498 дугаар захирамжаар сумдын баяр наадмын товгыг 2024 оны 07 дугаар сарын 07-26-ны өдрийн хооронд, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газарт албан бичиг хүргүүлж, 2024 оны 07 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан.	100%
УИХ-ын тогтоол					
8	26	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай 2001-06-14 Дугаар 2001№57	2.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлын эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт тусган шийдвэрлэж байх. (Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасгай.)	Бүрэн хэрэгжсэн.	100%
	27		3. Газар хөдлөлтөөс хамгаалах арга хэмжээг хот төлөвлөлтийн бодлогод тусгаж хэрэгжүүлэх, төвлөрлийг сааруулж, суурьшлын бүс, дагуул хотыг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөж хөгжүүлэх арга хэмжээг авах;	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон бодлого төлөвлөлтөд тусгаж төв суурин газрын төвлөрлийг сааруулж, суурьшлын бүсийг газар хөдлөлтийн эрсдэл багатай бүс рүү төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг дундын хянагч нар хяналт тавин зохион байгуулж, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг төв талбайд жагсааж үзлэг шалгалтыг хийж ажиллав. Үүнд: Бэлтгэл ажлын хүрээнд: Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх "Стратегийн команд штабын дадлага сургууль" зохион байгуулагдахтай холбогдуулан бэлтгэл, бэлэн байдлыг хангаж дадлага, сургуулийг Төрийн болон төрийн бус Аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж ажилласан. Мөн "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг зарим сумдад зохион байгуулж сумын ЕБС, ХЦ-ийн сурагчдад газар хөдлөлтийн талаар анхан шатны мэдлэг олгох дадлага сургуулийг хийж гүйцэтгэсэн. Бага ангийн багш нар өөрсдийн даасан ангийн сурагчдад газар хөдлөлтийн аюул гэж юу вэ, аюул тохиолдсон үед хэнд хандах, асран хамгаалах том хүн байхгүй тохиолдолд хэрхэн юу хийх тухай мэдээлэл өгч анги дотроо богино хугацааны дадлага, үзүүлэх хичээл заасан. Энэ арга хэмжээнд бага ангийн 139 сурагч буюу 98.5% нь хамрагдсан. Мөн 6-9 дүгээр ангийн 4 бүлгийн 85 сурагчид гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургууль гэж юу вэ? Газар хөдөлсөн үед өөрийгөө болон бусдыг хэрхэн авран хамгаалах вэ?, цуглах цэгийн	70%
	28	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34	7. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадаахыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;	Монгол улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын дагуу аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тайлан онд 2 удаа тодотгож ажиллагааны удирдлагын төв, хүн хүч, техник, багаж зэвсэглэмж, түр хөргөх байр, цугларах цэг, шаардлагатай нөөцийн бүртгэл судалгааг тодотгосон. Мөн Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, Монгол улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргын тус тус баталсан 2024 оны "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх" арга хэмжээний удирдамжийн дагуу иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр"-ийг 03 дугаар сарын 27-ны өдөр, "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль"-ийг 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Энэ үеэр гамшгаас хамгаалах, хэв журам сахиулах-36, эрүүл мэндийн-98, хүнсээр хангах-12, Мал эмнэлгийн-11, холбоо зарлан мэдээллийн-8, төмөр замын-45, зам тээврийн-8, эрчим хүчний-52, байгалийн аюулыг үнэлэх-10, ус дулаанаар хангах- 35, сургалт сурталчилгаа зохион байгуулах-12, түр орон байраар хангах-6, нийгмийн хамгааллын-19, Сайншанд сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн-128, нийт 12 алба, 14 мэргэжлийн ангийн 465 ажилтан, алба хаагчдад хувцас	100%
9	29		8. "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх.	Монгол улсын Шадар Сайдын 2022 оны 129 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ын 6 дугаар зүйлд заасны дагуу аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёл, үйлчилгээний барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж, 2024 оны орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн. Батлагдсан төсөвт өртөт багтаан эхний ээлжинд паспортжуулах шаардлагатай /сургууль, дотуур байр, спорт заал, цэцэрлэг, эмнэлэг, соёл үйлчилгээ, төрийн захиргааны байгууллага/-ыг сонгон, насжилтын судалгааг шинэчлэн гаргаж, ашиглалтын төлөв байдлаар нь ангилж ерөнхий боловсролын сургуулийн 6 барилга, цэцэрлэгийн 4 барилга, эмнэлгийн 2 барилга, соёл урлагын 5 барилга, төрийн захиргааны-1 нийт 18 барилга байгууламжийг паспортжуулсан.	100%

	30		1.5/ Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдөлгөд тэсвэрлэх байдлыг шалгах, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдөлгөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхлэх хүчэтгэх ажлыг зохион байгуулах;	Монгол улсын Шадар Сайдын 2022 оны 129 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам"-ын 6 дугаар зүйлд заасны дагуу аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, соёл, үйлчилгээний барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж, 2024 оны орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлсэн. Батлагдсан төсөвт өртөт багтаан эхний ээлжинд паспортжуулах шаардлагатай /сургууль, дотуур байр, спорт заал, цэцэрлэг, эмнэлэг, соёл үйлчилгээ, төрийн захиргааны байгууллага/-ыг сонгон, насжилтын судалгааг шинэчлэн гаргаж, ашиглалтын төлөв байдлаар нь ангилж ерөнхий боловсролын сургуулийн 6 барилга, цэцэрлэгийн 4 барилга, эмнэлгийн 2 барилга, соёл урлагын 5 барилга, төрийн захиргааны-1 нийт 18 барилга байгууламжийг паспортжуулсан.	100%
10	31	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52	3.1/ Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/ г үүрэг болгосугай. 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бус нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан нийгмийн салбаруудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаас Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар тус аймагт 44,9 тэрбум төгрөгийн 17, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 65,5 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ батлагдсан. Тухайн тайлант оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, үе шатын ажлын хуваарийн дагуу ажлыг гүйцэтгүүлж захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
11	32	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	хэрэгжилт биелсэн.	100%
	33		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	хэрэгжилт биелсэн.	100%
12	34	ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЕС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-05-04 Дугаар 2023_32	1.3. төрийн албан хаагчийн Ес зүйн дэд хороог байгуулах ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангаж, үйл ажиллагааг жигдрүүлэх.	УИХ-ын Ес зүйн байнгын хороо, ЗГХЭГ, ТАЗ-өөс зохион байгуулсан "ТАХ-ын ёс зүй, манлайлал, гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих, чадавхжуулах сургалт"-д Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс тус хуулийн сургалтыг танхимаар 507 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 1,353 төрийн албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын дэргэдэх 102 ёс зүйн дэд хороог 300 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус хорооны гишүүдийг ёс зүйн хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, арга зүйг хангаж, чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.	100%
13	35	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ 2023-06-30 Дугаар 2023_59	3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар ханган хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т тус тус үүрэг болгосугай.	2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд авлигын үзүүлэлтээр 10 байр урагшлах зорилтын хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт зохион байгуулах, авлигыг үл тэвчих нөлөөллийн контент бүтээх, авлигын эсрэг "Дэвжээ-2024" арга хэмжээ зохион байгуулах гэсэн 5 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Тус арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна. Мөн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд "Бүх нийтээрээ авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг сайжруулах" зорилтын хүрээнд 5 арга хэмжээг төлөвлөн батлаад байна.	100%
	36		1.2. хөдөөд орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрээс бүрдүүлэх замаар олон талын оролцоог хамарсан хамтын санхүүжилтээр шийдвэрлэх;	"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт" зорилтын хүрээнд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шилдэг мэргэжилтнүүдийг орон нутагт урин ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлөөс санаачлан нийслэлээс шилжин ирж буй нарийн мэргэжлийн эмч, багш нарыг орон сууцаар хангах зорилгоор Сайншанд суманд 30 айл, Замын-Үүд суманд 144 айлын орон сууцны төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. 2024 оны 11 сарын байдлаар нийт 291 иргэнд 29,5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосноос хөтөлбөрийн санхүүжилтээр 147 иргэнд 13,6 тэрбум төгрөгийг олгосон.	100%

14	37	МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-11-10 Дугаар 2023_93	1.10. төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;	"Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Дорноговь аймагт хэрэгжүүлэх 17 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжүүлсэн 10 төсөл арга хэмжээний тендерийг цахимаар 100% зарласан. Улсын төсвөөс эрх шилжсэн төсөл арга хэмжээнээс 9 ажлын нийт 21,9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсанаас 4 төсөл арга хэмжээ 100% дууссан. 5 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжихээр төсөв нь батлагдсан. Гүйцэтгэл 10-51 хувьтай явагдаж байна. Үүнд: 1.Замын-Үүд сумын төвийн 2,15 км авто замын шинэчлэл хийх-100% дууссан 2.Сайншанд сумын 7 дугаар багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажил-30% 3.Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж нийлүүлэх-100% дууссан 4.Замын-Үүд суманд ундны усны 3000 м3 багтаамжтай усан сан барих ажил-100% дууссан 5.Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд сумдад ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын автобус худалдан авах ажил-90% 6.Дорноговь аймгийн Сайншанд сумын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамжийн ажил-БАГЦ-1-100% дууссан, БАГЦ-2 гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн. 7.Дэлгэрэх суманд Соёлын төвийн барилга барих ажил-30% 8.Дулааны станцын өргөтгөл барих ажил-10% 9.Шинэ хөдөө төслийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.	100%
15	38	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_05	1.6. төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хургах цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.	Төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэхээр төрийн үйлчилгээний нэгдсэн "ХурДан" төвийг орон нутгийн төсвийн 121,0 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж, 2022 онд байгуулсан нь улсын хэмжээнд анхны орон нутагт "ХурДан" төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн аймаг болсон. ХурДан төв ашиглалтад оруулснаар төрийн цахим үйлчилгээ авах иргэдийн тоо давхардсан тоогоор 41,415 болсон нь өмнөх жилүүдээсээ 2 дахин өсөлттэй байна. Төрийн үйлчилгээний лавлах "call center" үйлчилгээгээр дамжуулан төрийн болон төрийн өмчит 18 байгууллагын 45 төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж нийт 2348 дуудлагад хариу өгч ажилласан. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 200 гаруй төрийн үйлчилгээг өөрөө өөртөө үйлчилж авах боломжтой ухаалаг КИОСК төхөөрөмж суурилуулах 19 байршлын судалгаа мэдээллийг гаргаж Улсын бүртгэл, Авто тээврийн газар, Цагдаагийн газарт байршуулж ажилласан. Мөн 24/7 цагаар ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж КИОСК төхөөрөмжтэй холбоотой гарсан засвар үйлчилгээг Гэрэгэ КИОСК ХХК-д мэдэгдэж нийт 5 удаа уламжилж засварлуулсан. Цаашид 2025 онд дахин судалгааны дагуу 14 сум болон шаардлагатай байршуулахад КИОСК төхөөрөмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөдөг байна. Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн "ХурДан" төвийн үйл ажиллагаа хэвийн явуулж салбар цэгийг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, тохижилт, цахим шилжилтийн сургалтыг зохион байгуулахад орон нутгаас 61 сая төгрөгийн зардал гаргасан. Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор 14 сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоонд	70%
16	39	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2024-01-17 Дугаар 2024_11	1.1. төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамжийн ногдуулалт, түүний зарцуулалтын талаар судалж, дүгнэлт, саналаа 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд ирүүлэх; 1.2. төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний төлбөр, хураамж болон тэдгээрийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, хууль тогтоомж зөрчсөн төлбөр, хураамжийг хүчингүй болгох арга хэмжээ авах.	Хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гараагүй болно.	Х.Б
17	40	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын удирдлагуудад төрийн үйлчилгээний төлбөр, хураамжийг хууль тогтоомжид нийцүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлж иргэдэд хурдан шуурхай үйлчлэх, аливаа хүнд суртал, дарамт шахалтыг халах, зөрчил гаргасан албан тушаалтанд хуулийн хариуцлага хүлээлгэх талаар үүрэг чиглэл өгсөн.	100%
17	41	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27	2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.	УИХ-ын Ёс зүйн байнгын хороо, ЗГХЭГ, ТА3-өөс зохион байгуулсан "ТАХ-ын ёс зүй, манлайлал, гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтэцмжийг дэмжих, чадавхжуулах сургалт"-д Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга хамрагдсан. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын дэргэдэх 102 ёс зүйн дэд хороо 300 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус хорооны гишүүдийг ёс зүйн хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, арга зүйг хангаж, чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөдөг байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс тус хуулийн сургалтыг танхимаар 507 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 1,353 төрийн албан хаагчдыг хамруулсан.	100%

42		2.а. а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;	Аймгийн Засаг даргын 2024 оны А/165 дугаар захирамжаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний элэгдэл, эвдрэл гэмтлийг тодорхойлох, дүгнэлт гаргах ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагын 8, 14 сумын Засаг даргыг тухай бүр оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, Боловсролын газрын даргын баталсан удирдамжаар төрийн өмчийн 21 сургуулийг бүрэн хамруулж, ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS6782:2019 стандартын хэрэгжилтэд 22 шалгуураар эрсдэлийн үнэлгээ хийсэн. Нийт сургуулийн гадаад орчинд тавигдах шаардлага, аюулгүй байдлын хангалт 74.7%, дотоод орчинд тавигдах шаардлага, аюулгүй байдлын хангалт 79.9%-тай үнлэгдсэн ба 21 сургууль, 33 цэцэрлэгийн удирдлага, холбогдох багш, ажилтан нийт 450 хүнд эрсдэлийг бууруулах арга, боломжийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгсөн. Аюулгүй байдлыг хангах зорилгоор орон нутгийн төсвөөр ерөнхий боловсролын 21 сургууль, 9 цэцэрлэгт гадна, дотор нийт 445 ширхэг камер суурилуулах ажлыг 255.8 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн. Замын-Үүд сумын ЕБ-ын 2-р сургуулийн хичээлийн байрны 138,8 сая төгрөгийн гадна фасадын засвар, Замын-Үүд сумын 2-р цэцэрлэгийн 331,8 сая төгрөгийн гадна фасад цонх шалны засварын ажил, Замын-Үүд сумын 4-р цэцэрлэгийн 305,9 сая төгрөгийн дотор засвар, цэвэр бохир ус шугамын засварын ажил, Хөвсгөл сумын цэцэрлэгийн барилгын 162,1 сая төгрөгийн дотор засварын ажил, ЕБ-ын сургуулийн 144,1 сая төгрөгийн ажилчдын байрны 4 айлын орон сууцны барилгын засвар, Сайншанд сумын 65,4 сая төгрөгийн ажилчдын байрны засвар	100%	
18	43	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-05-02 Дугаар 2024_37	2.б. б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;	Аймгийн бүх түвшний боловсрол олгох сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харьяалал харгалзахгүй тэгш хамруулж байгаа бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд цэцэрлэгт 44, сургуульд өдрөөр 100, дүйцсэн хөтөлбөрөөр 20, мэргэжлийн сургалтын байгууллагад 8 суралцагч, нийт 172 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч суралцаж, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх "Эрүүлжин хөгжих төв"-д хүндэтгэр хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 0-16 насны тусгай хэрэгцээт нийт 190 хүүхэд байгаа ба 181 хүүхдийг боловсролын сургалтад бүрэн хамруулж, 9 хүүхэд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүд байна. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 47 багш болон сургуулийн дэмжлэгийн баг, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, хууль тогтоомжийн дагуу 41 багшид урамшууллыг бүрэн олгосон. Тусгай хэрэгцээт суралцагч, хүүхдүүдийг сургуулийн орчинд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх, суралцах явцад мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, багш, хүүхэд, асран хамгаалагч нарт зөвлөн туслах "Дэмжлэгийн баг"-ийг нийт 54 боловсролын байгууллага 100% байгуулан ажиллаж, үйл ажиллагаа тогтмолжсон. Сайншанд сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш болон цэцэрлэг сургуулийн дэмжлэгийн багийн нийт 256 гишүүнийг "Тэгш хамран сургах боловсрол" сургалтад бүрэн хамруулсан.	100%
44		3.в. в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.	Аймгийн хэмжээнд 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй 288, үүнээс 0-16 насны 190 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас аймгийн бүх түвшний боловсрол олгох сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг харьяалал харгалзахгүй тэгш хамруулж байгаа бөгөөд 2024-2025 оны хичээлийн жилд цэцэрлэгт 44, сургуульд өдрөөр 100, дүйцсэн хөтөлбөрөөр 20, мэргэжлийн сургалтын байгууллагад 8 суралцагч, нийт 172 хүүхэд суралцаж, 9 хүүхэд хүнд хэлбэрийн байнгын асаргаа шаардлагатай тул гэртээ байдаг ба аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх "Эрүүлжин хөгжих төв"-д хүндэтгэр хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 9 хүүхдийг хамруулсан. Тус төвд хамрагдаж байгаа хүүхдүүдэд өдөр тутам сэргээн засах, бариа заслын үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд үйлчилгээний үр дүнд тогтмол хамрагддаг 6 хүүхдийн бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт эерэг өөрчлөлт гарч байгаагаас гадна ажил хөдөлмөр эрхлэхгүй байсан 7 асран хамгаалагчаас 5 асран хамгаалагч байнгын ажлын байртай болсон үр дүнтэй байна. Хөдөө сумдаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн асран хамгаалагчдыг мөн адил боломжоор хангаж байна. 2024 онд төвийн үйл ажиллагаа болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 125,0 сая төгрөг батлагдсанаас 92,9 сая төгрөгийг зарцуулсан. Өмнөх онтой харьцуулахад өдрийн үйлчилгээгээр хамрагдсан хүүхдийн тоо 8-аар, зарцуулсан төсөв 38,8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.	100%	
19	45	2.3. 3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлийг баримтлан аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулан, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2024 оны 03/02 дугаар тогтоолоор батлуулсан.	100%	
46		2.4. 4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээс аймагт холбогдох арга хэмжээг хуваарилсан тохиолдолд 2024 оны 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болно.	Х.Б	
УИХ-ын байнгын хорооны тогтоол					

20	47	<p>Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ</p>	<p>3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик ирүүлэх)</p>	<p>Аймгийн хэмжээнд сүрьеэгийн идэвхтэй тандалтын үзлэгийг эрт илрүүлэхийн үзлэгтэй хавсруулан зохион байгуулж, 18-аас дээш насны 3450 хүнийг үзлэгт хамруулан, шинээр 2 сүрьеэг илрүүлж, хяналтад авсан. Мөн Сайншанд, Замын-үүд суманд идэвхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, үзлэгт 326 хүнийг хамруулж, шинээр 2 сүрьеэг илрүүлэн хяналтад авсан. 2024 онд сүрьеэгийн 38 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 5.3 болж, өмнөх оноос 2.6 промилоор буурсан. Балгийн замаар дамжих халдварт өвчний илрүүлэх үзлэг, шинжилгээнд 4365 хүнийг хамруулж, шинээр 294 халдварыг илрүүлснээс 29 жирэмсэн эмэгтэйд хяналтад авч, 100% эрүүлжүүлсэн. Сайн дурын зөвлөгөө өгөх төв нийт 1587 хүнд үйлчилж, тэмбүү, ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд 100%, нян судлалын шинжилгээнд 393 хүнийг хамруулж, 407 хүнийг бэлгийн замаар дамжих халдварын нарийн мэргэжлийн эмчид илгээж, бэлгийн замаар дамжих халдварын 136 өвчлөлийг шинээр илрүүлж, 100% эрүүлжүүлж, 80 хүнд утсаар зөвлөгөө өгч үйлчилсэн. 2024 оны цэрэг татлагаар 1407 залуучууд үзлэгт хамрагдсанаас шинээр бэлгийн замаар дамжих халдварт өвчин илрээгүй. Аймгийн хэмжээнд 10000 хүн амд ногдох бэлгийн замаар дамжих халдвар 40.9 болж, өмнөх оноос 1.4-өөр нэмэгдсэн ба төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй.</p>	100%
	48	<p>Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ</p>	<p>2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах;</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө" батлах тухай А/528 дугаар тушаал, 2023 оны "Журам, заавар батлах тухай" А/133 дугаар тушаалын хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа-2" 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорноговь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /2021-2025/, Дорноговь аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт ХДХВ-ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх 6 заалт, арга хэмжээг тусган, хэрэгжилтийг ханган ажилласан. БЗДХ-ын идэвхтэй илрүүлэг үзлэг шинжилгээнд нийт 7250 хүнийг хамруулж, БЗДХ 294 өвчнийг шинээр илрүүлснээс БЗДХ-тай 21 жирэмсэн эмэгтэйд эрт илрүүлж, эмчилгээнд 100% хамруулсан. "Далхий нийтээр ХДХВ, ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр"-ийг "Хүний эрхийг дээдлэн зөв замаар урагшиль" уриан дор тэмдэглэж, бэлгийн замаар дамжих халдварт өвчин илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж, 969 оюутан болон албан хаагчдыг хамруулан зөвлөгөөг өгсөн. ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх арга, эрүүл зан үйл төлөвшүүлэх, урьдчилан сэргийлэх 36 удаагийн сургалт, мэдээлэлд нийт 1860 хүнийг хамруулан, 23 төрлийн 953 ширхэг зөвлөмж гарын авлага түгээн, 42 төрлийн цахим мэдээллийг хүргэснээр 2200 хүний хандалт авсан байна.</p>	100%
21	49	<p>Бэлгийн замаар дамжих халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ</p>	<p>2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.</p>	<p>Сумдын төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн гүний худаг 13, халдваргүйжүүлэх станц 1, дамжуулах станц 3, усан сан 10, ус түгээх байр 33, нийт 59 цагаас дээж авч, СХЗХ-ийн лабораторийн нян судлалын шинжилгээнд 55, химийн шинжилгээнд 35 дээжийг илгээн хамруулж, шинжилгээний дүнг үндэслэн холбогдох байгууллагуудын удирдлагуудад зөвлөгөө, зөвлөмж өгсөн. Аймгийн хэмжээний үндэс усны чанарыг сайжруулах 2025-2028 оны төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Орчны эрүүл мэндийн чиглэлээр 3 удаагийн нөлөөллийн ажлаар 30,000м2 талбайд нийтийн цэвэрлэгээг хийж, халдваргүйтгэн, 65тн хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт төвлөрүүлж, 17 удаагийн сургалтад 735 хүнийг хамруулан, нийгмийн сүлжээнд постер, видео зэрэг 45 зөвлөмжийг байршуулснаар 10540 хандалт авч, иргэдийг мэдээллээр хангалаа. ЭМС-ын 2021 оны А/349 дугаар тушаалаар батлагдсан "Орчны эрүүл мэнд арга хэмжээ"-г эрүүл мэндийн байгууллагууд 7 зорилтын хүрээнд 26 заалт бүхий төлөвлөгөө гарган, "Хоггүй орчин-Бидний хариуцлага", "Усны мандала" зэрэг аяныг зарлаж, 15000м2 талбайд тархсан 65тн хог хаягдлыг цэвэрлэн зориулалтын хогийн цэгт төвлөрүүлж, эрүүл мэндийн байгууллагын халдвартай хог хаягдал 28012.9 кг, хурц үзүүртэй хог хаягдал 5229.3кг-ыг зохих журмын дагуу халдваргүйжүүлж устгасан. Сайншанд сумын нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай зэрэг нийт 15000м2 талбайд халдваргүйтгэлийг хийсэн. Мөн орчны эрүүл мэндийн мэдлэг олгох нийт 39 удаагийн цахим болон танхимын сургалт, мэдээлэлд 3237 хүнийг хамруулсан. Шугам сүлжээний бүрэн бүтэн байдлын хяналтыг долоо хоног бүр хийж, нийт 25 удаагийн</p>	70%

22	50	"Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтныг орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	Тус цагдаагийн газраас 2024 оны эхний 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлгүй гэр бүл", "Сурагчдын дотуур байр", "Хамтдаа сэргийлье", "Хүүхдийг эсрэг шийтгэхгүй байх өдөр", "Дээрлэл дэлгэрэх ёсгүй", "Зуслан", "Хайр хязгааргүй ялгаагүй", "Хичээл эхэллээ", "Дотуур байр", "Хүүхэд хамгаалал-2024" зэрэг соён гэгээрүүлэх 10 тусгай арга хэмжээг санаачлан зохион байгуулан ажиллан биелэлт, үр дүнг тооцож ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 22 сургуулийн 22 "School police" эргүүлийг тус цагдаагийн газрын тухайн өдрийн жижүүрийн бүрэлдэхүүний томилгоот 40 чиглэлд 132 эцэг, эхчүүдийн хамт сургуулийн орчимд хичээл эхлэх, тарах цагаар өдөр бүр замын хөдөлгөөний ачаалал ихэсдэг 10 цэгүүдэд хуваарилан эргүүлийн үүрэг гүйцэтгэн хяналт тавин ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн орчинд хуваарийн дагуу 2 ээлжээр эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн мэргэжил арга зүйгээр ханган хяналт тавин ажилласан. Ерөнхий боловсролын сургуулиудын өсвөрийн сэргийлэгч нарт 60 ширхэг хантаазны 2.0 сая төгрөгийн төсвийг батлуулан шийдвэрлүүлж хантаазыг сургуулийн захиргаанд хүлээлгэн өгч өсвөрийн сэргийлэгч нарыг мэргэжил арга зүйгээр ханган сургуулийн орчинд эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Мөн "Өсвөрийн сэргийлэгч-2024" тэмцээнийг зохион байгуулж 1.0 сая төгрөгийг	70%
23	51	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2020-08-26 Дугаар 2020.08.26 №01 ИЦББХ	3. Бүх шатны боловсролын байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, бэлэн байдлыг үе шаттай хангуулах	Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын 21 сургуулийн мэдээллийн технологийн дэд бүтэц, сүлжээний талаарх мэдээллийг цуглуулж, нөхцөл байдлын судалгаа, дүгнэлт хийж, 21 сургуульд нийт нөхөн хангалтын 793.3 сая төгрөгөөр утасгүй интернэтийн төхөөрөмж байршуулж, дэд бүтцийг сайжруулсан. Мөн Боловсролын ерөнхий газраас 153.0 сая төгрөгийн 88 хромбүүк, 33 смарт телевизийг 21 сургууль, Насан туршийн боловсролын төв, Боловсролын газар, Сайншанд сумын 6-р сургуульд 84.0 сая төгрөгийн walebook 1, утасгүй интернэтийн төхөөрөмж 1, ухаалаг самбар 1-ийг нийлүүлсэн. "Бадрах энержи" ХХК-аас Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуульд "Мэдээлэл зүйн кабинет"-ыг шинэчлэн, 78.8 сая төгрөгийн 15 суурин компьютер, 35 таблет, 1 ухаалаг самбар болон дагалдах хэрэгслийн хамт хандивлан дэд бүтцийг сайжруулсан. Мөн орон нутгийн төсөв болон төсгөгчдийн нийт 205.0 сая төгрөгийн хөрөнгөөр Мандах, Хатанбулаг Даланжаргалан сум, Зүүнбаянгийн сургуулиудад нийт 28 ухаалаг дэлгэц, 20 зурагт, 15 notebook, 1 видео камерыг хандивласан. Орон нутгийн 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 3-р сургууль, Замын-Үүд сумын 1, 2-р сургуулийн шилэн кабелийн гэмтлийг засварлаж, Алтанширээ сумын хүүхдийн цэцэрлэгийг шинээр сүлжээнд холбож, интернэтийн хэвийн ажиллагааг хангасан. 2024 онд улс, орон нутаг, хандивын нийт 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээний 21 сургуулийн интернэтийн орчин, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөхцөл байдлыг сайжруулалт, шинэчлэлтийг хийсэн.	100%
24	52	Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Аймгийн хэмжээнд 340 тонны багтаамж бүхий мах хадгалах стандартын шаардлага хангасан зориулалтын зорьтой "Хайрхан" малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнүүний зах, "Суман Зурхай" ХХК, мөн мал төхөөрөх 1, мах боловсруулах /хиам/ 1, мал нядалгааны 7 цэг үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр иргэн, аж ахуйн нэгж нь дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлээгүй байна. Тайлант онд Хөвсгөл сум "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас мах нөөцлөх хөргүүртэй агуулах барих 1 иргэнд 120.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож дэмжлэг үзүүлсэн.	100%
53			1.5/. Экспортод гаргаж байгаа мах, махан бүтээгдэхүүнийг тодорхой хувь нь чанар, стандартын шаардлага хангахгүй байгаа тул мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, оновчтой зохион байгуулалт хийж;	Амьд малын экспортыг нэмэгдүүлэн малчдын амьжиргааг дэмжих ажлын хүрээнд Замын-Үүд сумын "Мал эрүүлжүүлэн тусгаарлах бүс"-д нийлүүлэгдсэн 55000 мянган толгой амьд малыг 2 улсын мал эмнэлгийн хорио цээрийн шаардлагыг хангуулан БНХАУ-руу гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулсан. Тайлант оны өмнөх үетэй харьцуулахад борлуулагдсан малын тоо 3,2 дахин буурсан нь цаад талын махны үнэ ханш буурсантай холбоотой.	100%

54		1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрыг стандарт, техникийн зохицуулалтад нийцүүлэн шинээр барих, засварлах, өргөтгөх болон стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардлыг шийдвэрлэх;	Аймгийн хэмжээний боловсролын 12 байгууллага 2024 онд нөхөн хангалтын зардлаас нийт 85.3 сая төгрөгийн 13 төрлийн стандартын шаардлага хангасан зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авсан. Мөн сургуулийн өмнөх боловсролын 28, ерөнхий боловсролын 21 сургуулийн гап тогтоонд шаардлагатай 1, 2 дугаар хоолны тогоо, хөлдөөгч, хөргүүр, махны машин, шарах шүүгээ, жигнүүр зэрэг 32 нэр төрлийн 115 ширхэг, нийт 600.0 төгрөгийн тоног төхөөрөмжийн жагсаалт, судалгааг гарган Боловсролын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 299 тоот, 11 дүгээр сарын 20-ны өдрийн 69 тоот албан бичгээр Боловсролын яам болон Боловсролын ерөнхий газар тус тус хүргүүлж, "Дэээрэт" олон улсын байгууллагад уламжилсан. Мөн орон нутгийн төсвөөс 600.0 сая төгрөгийг 2025 оны төсөвт оруулахаар төлөвлөсөн. Ерөнхий боловсролын 21 сургууль "Хүүхдийн хоолны орон тооны бус хяналтын зөвлөл" байгуулан, хоол үйлдвэрлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан "Шим тэжээлийн боловсрол олгох" сургалтын сарын аяныг зохион байгуулж, нийт 10953 хүнийг хамруулсан. Аяны хүрээнд бага ангид "Тэнцвэртэй хооллолт, шим тэжээл", дунд ангид "Зохистой хооллолтын зарчим гэр зөвлөмж", ахлах ангид "Шим тэжээлийн дутагдал эрүүл мэндэд нөлөөлөх нь" сэдэвт хичээлийг сургуулийн эрүүл мэндийн багш, биеийн тамирын багш нараар дамжуулан суралцагчдад болон эцэг эхчүүдэд хүргэсэн. Аймгийн Засаг даргын 2024 оны А/233 дугаар захирамжийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд сумдын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 объектод "Үдийн хоол",	70%	
25	55	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-05-25 Дугаар 2021 №05 БСШУСБХ	1.9/. ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн хяналтийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, санал дүгнэлтийг улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, цаашид үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Аймгийн Засаг даргын 2024 оны А/233 дугаар захирамжийн хүрээнд Сайншанд, Замын-Үүд сумдын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 объектод "Үдийн хоол", дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний чанар, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, сургууль орчмын хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээний 6 объектод стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, дүгнэлт гарган зөвлөгөө, зөвлөмж өгсөн. Мөн төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, сургуулийн дотуур байр болон Политехник коллежийн дотуур байрнд амьдарч буй суралцагчийн хоол хүнсний чанар, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, сургуулийн буфет болон худалдагчгүй дэлгүүр хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээний 7 объектод стандартын хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хийж, 22 байгууллагад зөвлөгөө, зөвлөмж өгсөн. Зөвлөгөө, зөвлөмжийн дагуу найдвартай хүнсний ногоогоор хангах зорилгоор хүүхдийн 16 цэцэрлэг хүлэмжид ногоо тарьж, хоол үйлдвэрлэлдээ ашигласан. Өдөр тутмын хоол хүнсний технологи картыг хөтөлж, хүүхдийн өдөрт авах илчлэг нормыг эцэг эх, асран хамгаалагчдад анги бүлгийн цахим хаягаараа тогтмол мэдээлж, шинэ нэр төрлийн болон зөв зохистой эрүүл хоолны үзэсгэлэн гаргаж, хоол тэжээлийн талаар сургалтыг "Мэдээллийн цаг-444" үйл ажиллагаагаар дамжуулан 21 сургууль, 33 цэцэрлэгт зохион байгуулсан. Мөн "Хайр хязгааргүй ялгаагүй" хүүхэд хамгааллын нөлөөллийн аяны хүрээнд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сургууль, цэцэрлэгийн орчим худалдаа, үйлчилгээ нийт 44 аж ахуйн нэгж,	70%
56		1.10/. орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, сургуулийн хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулах ажлыг эхлүүлэх;	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/140 тушаалын дагуу хүнсний хангамжийг төрийн өмчийн 33 цэцэрлэг, 21 сургууль тус бүр өөрсдөө тендерийн комисс байгуулан тендер болон шууд гэрээ байгуулах зарчмаар хууль, журмын дагуу ажиллаж, хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээ 24 аж ахуй нэгж байгууллагаас худалдан авалт хийсэн. Орон нутгийн аж ахуй нэгжээс сүү сүүн бүтээгдэхүүнийг "Цагаан сүүний буян ХХК", "Борхой сүү ХХК", махан махан бүтээгдэхүүнийг "Товийн амт ХХК" талх, нарийн боовыг "Бадрал талхан цех", "Зүүн булаг цех"-ээс хүнсний хангамжийг ханган нийлүүлж ажилласан. Мөн 21 сургууль, 17 цэцэрлэг орон нутгийн аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс хүнсний ногоогоо тогтмол авдаг ба 16 цэцэрлэг өөрсдийн хашаандаа хүлэмжид тарьсан ногоогоо хоол үйлдвэрлэлдээ хэрэглэсэн.	100%	
57		1.11/. 2022 оноос эхлэн хуулийн хэрэгжилтэд шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах, аж, ахуйн нэгж, байгууллагын хандив, олон улсын байгууллага, гадаад орнуудын буцалтгүй тусламжийн хүрээнд хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.	Хэрэгжиж дууссан.	100%	

58		1.1/ Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай: 1/ Биеийн тамир спортын тухай хууль, МУЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг МУЗГ, бүх шатны ИТХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, биеийн тамир, спортын Улсын хороо хангаж ажиллах;	Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 тогтоолоор батлагдсан "Дорноговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөр"-т биеийн тамир, спортын чиглэлээр 4 зорилт 14 арга хэмжээг төлөвлөж, арга хэмжээний хэрэгжилтийг 85,7%-тай ханган ажилласан. Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний биелэлт жилийн эцсийн байдлаар 15 арга хэмжээний хүрээнд тайлагнаж 94%-тай хэрэгжсэн. Аймгийн хэмжээнд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр / сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, жоу жицу зэрэг/ 45 сургалт, дугуйлан хичээллүүлж, 670 гаруй өсвөрийн тамирчид хичээллэж байна. 2024 онд өсвөрийн тамирчид тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнд 105 алт, 90 мөнгө, 87 хүрэл медаль нийтдээ 282 медалийн эзэд болсон. Аймаг орон нутгаас хөл бөмбөг, сурын харваа, боксын холбоо, оюуны академи, хийн дасгалын холбоо зэрэг иргэд, аж ахуйн нэгж, спортын холбоодоос ирүүлсэн 18 удаагийн хүсэлтэд 135,9 сая төгрөгийн захирамжийг гарган дэмжлэг үзүүлсэн. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өдөр тутмын дасгал хөдөлгөөн, эрүүл чийрэг бие бялдрын хөгжлийг дэмжсэн спортын тэмцээн, арга хэмжээ, үйл ажиллагаанд 43,484 иргэнийг хамруулсан нь өмнө оноос 22,8%-иар өссөн. Мөн шугаман бүжгээр хичээллэгсдийн 5676 болж өмнө оноос 12,2 хувиар өссөн. Биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний	100%	
59	26	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ	1.5/ бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	2024-2025 оны хичээлийн жилд 21 сургуулийн өдрийн 541 бүлэгт 16160 суралцагч, дүйсэн хөтөлбөрөөр 74, нийт 16234 суралцагч ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд хамрагдаж байгаа нь өмнө оноос 409 суралцагчаар нэмэгдсэн. Ерөнхий боловсролын өдрийн ангид суралцаж буй нийт 16160 суралцагч биеийн тамирын хичээлийг сургалтын хөтөлбөрийн дагуу үзэж байна. 21 сургуульд спортын 54 секц хичээллүүлж, давхардсан тоогоор 2502 суралцагч хамрагдсан. Мөн Биеийн тамир, спортын газар 2024 онд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан спортын 12 төрлөөр аймгийн хэмжээнд 45 секц, дугуйлан хичээллүүлж, 670 гаруй суралцагчид тогтмол хамрагдаж, тив, дэлхий, улсын аварга шалгаруулах тэмцээнд 105 алт, 90 мөнгө, 87 хүрэл медаль, нийт 282 медаль хүртсэн амжилт үзүүлсэн. 2024 онд улс, орон нутгийн 77.3 сая төгрөгийн төсвөөр 5 сумын 12 сургууль, цэцэрлэгийг урлаг, спорт зал, танхимын тохижилт, хэрэглэгдэхүүнээр хангасан. Орон нутгийн төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн спорт залны засвар, биеийн тамирын гадаад талбайн бүрэн тохижилт нийт 587.0 сая, 2-р сургуулийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажил 750.0 сая, Алтанширээ сумын цэцэрлэгт 3.0 сая төгрөгийн биеийн тамирын дасгалын тоног төхөөрөмж, Замын-Үүд сумын 6-р цэцэрлэгт 2.4 сая төгрөгийн тоглоомын хэрэглэгдэхүүн, Сайхандулаан сумын цэцэрлэгт 49.8 сая төгрөгөөр бүрэн хийгдсэн.	100%
60		1.6/ Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Говь-Сүмбэр аймагт зохион байгуулагдсан шинэ спортын төрөл крicketийн спортын анхан шатны мэдлэг олгох сургалтад тус газрын ахлах мэргэжилтэн, нийтийн биеийн тамирын арга зүйч, Төв аймагт зохион байгуулагдсан сорилын жишиг төв байгуулах сургалтад төвийн болон сумдын 9 биеийн тамирын арга зүйч нар, Олон улсын С зэрэглэлийн сургалтад сагсан бөмбөгийн дасгалжуулагч, Монголын Волейболын холбооны анхан шатны шүүгчийн сургалтад нийтийн биеийн тамирын арга зүйч, Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан Бээжин хотын Спортын их сургуульд 10 хоног туршлага судлах хөтөлбөрт чөлөөт бөхийн дасгалжуулагч, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Биеийн тамир спорт тогтвортой хөгжил" Олон улсын эрдэм шинжилгээний хуралд ахлах мэргэжилтэн, чөлөөт бөхийн дасгалжуулагчид, "Спортын анагаах ухаан" эрдэм шинжилгээний хуралд нийтийн биеийн тамирын арга зүйч, усан спорт сургалтын төвийн дасгалжуулагч нар, Монголын мэргэжлийн шүүгчдийн холбоо, Дорноговь аймгийн сагсан бөмбөгийн холбоотой хамтран олон улсын шүүгчийг урин сагсан бөмбөгийн шүүгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 24 дасгалжуулагч, биеийн тамирын багш, арга зүйчдийг хамруулж сертификат олгож, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн. "Багш спорт-2024" спортын наадмыг боловсролын салбарын нийт байгууллагуудыг хамруулан, давхардсан тоогоор 56 боловсролын байгууллагын 52 багийн 770 багш тамирчдыг хамруулан спортын 5 төрлөөр зохион байгуулсан. Мөн "Хөдөөгийн багш нарын спортын наадам" -д 45 хүний бүрэлдэхүүнтэй баг, тамирчид амжилттай оролцсон. Биеийн тамирын багш,	70%	

61		1.12/ Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон нутгаас 70,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын Соёл, спортын төвд бүрэн засвар, Айраг сумын Соёл спортын төвд шал, дээврийн засварын ажлыг байгууллагын албан хаагчид 1,7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. ОНТ-ийн 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Алтанширээ суманд Спорт заал барих ажлыг "Эйбол" ХХК гүйцэтгэж эхэлсэн. Барилгын газар шороо, суурь, гадна ханын өрөг, гадна шугам сулжээний ажил хийгдсэн. Багана, бүс бетоны төмөр бетон хийцийн цутгалтын ажил хийгдэж байна. Ажлын явц 50%-тай. Орон нутгийн төсвийн 449,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Усан спорт сургалтын төвд дээвэр, дотор засал, агаар салгалтийн засвар хийх ажлыг "Цүн түрүү" ХХК ажил гүйцэтгэн ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн. Биеийн тамир спортын салбарын засвар, үйлчилгээ, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зориулж 2,4 тэрбум төгрөг зарцуулсан буюу өмнө оноос 64,9%-иар төсөв нэмэгдсэн. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлснээр 43,484 иргэн биеийн тамирын үйл ажиллагаанд оролцож, өмнө оноос 22,8%-иар иргэдийн идэвхтэй идэвхтэй хөдөлгөөн нэмэгдсэн.	100%
27	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-12-28 Дугаар 2021 №06 ҮББХ	1.4. Өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах гадаргын болон гүний усны төслүүд (Цагаан цав, Загийн ус, Хэрлэн-Тоонот, Орхон-Онгй);	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эдийн засгийг тэлэх 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү ажлын хүрээнд Хэрлэн гол дээр олон зориулалттай усан цогцолбор байгуулах "Хэрлэн-Тооно" төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг "Эрдэнэс Оюу толгой" ХХК-ий зүгээс хариуцан ажиллаж төслийн Техник Эдийн Засгийн Үндэслэл ТЭЗҮ/ боловсруулах байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендер энэ оны 7 дугаар сард зарлагдаж тус тендерт "Монхидроконстракшн" ХХК шалгарсан. 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр "Эрдэнэс Оюу Толгой" ХХК, "Монхидроконстракшн" ХХК нар үйлчилгээ үзүүлэх гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулж, төслийн ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийг "Оюу Толгой" ХХК хариуцах буй бөгөөд гүйцэтгэгч компани 1,7 жилийн хугацаанд ТЭЗҮ-г боловсруулахаар төлөвлөсөн бөгөөд Дорноговь аймгийн 8 сумын газар нутаг хамрагдана. Уг төсөл хэрэгжүүлэгч компанийн төлөөлүүд болон холбогдох төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж, орон нутгаас шаардагдах мэдээ мэдээллийг гарган хамтран ажиллах уулзалтыг зохион байгуулсан.	100%
63		1.5. Хилийн боомтын менежмент, дэд бүтцийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төслүүд (Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Дорноговь аймгийн ханги боомт);	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 376-р тогтоолоор Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших хилийн Ханги боомтод улсын хилийн зурваст 33,5 га газарт Гаалийн хяналтын бус, олон төрөлт чингэлэгт тээврийн терминал бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхээр Боомтын захиргаанд ашиглуулахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу Боомтын захиргаа, "ХАНГИ ЭКО ЛОГИСТИК ХХК-тай 2023 оны 01-р сарын 07, ний өдөр байгуулсан гэрээний дагуу бүтээн байгуулалтын төслийг терминалыг "Ханги Эко Логистик" ХХК 100 хувийн өөрийн хөрөнгөөр барьж байгуулан ашиглалтад оруулахад бэлэн болсон. Орон нутгийн зүгээс уг төслийг эхлүүлэхэд шаардлагатай барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгож аймгийн Засаг даргын 2019 оны А/820-р захирамжаар томилогдсон Зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн 2024оны А3-13/2024 дүгнэлтээр байнгын ашиглалтад оруулсан.	100%
64		1.5/ Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохиистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Тариалангийн тухай хуульд "Агрохими, агрофизикийн шинжилгээг таван жил тутамд тариалангийн газрын эзэмшигч, ашиглагч өөрийн хөрөнгөөр хийлгэнэ" гэж заасны дагуу "Дорнын говийн тариаланчид" төрийн бус байгууллага, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөрс судлалын лабораторитой хамтран аймгийн тариалангийн 97,6 га талбайд хөрсний чанар, төлөв байдалд агрохимийн шинжилгээ хийж, сорилын дүн, зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн. АНУ-ын (USAID)-ийн санхүүжилттэй Best хөтөлбөртэй хамтран 2024 оны 03 сарын 27-нд "Агро ойжуулалтаар ашгаа нэмэгдүүлэх боломж" сэдэвт сургалтыг зохион байгуулж говийн бүс нутагт хамгаалалтын ойн зурвас байгуулах ач холбогдол, тохиромжтой мод бутыг тариалах, арчлах талаар мэдлэг мэдээллийг өгч аймгийн 30 газар тариалан эрхлэгчийг хамруулсан. Хөрс боловсруулалтыг сайжруулах ажлын хүрээнд 15 тариалан эрхлэгчийг "GREEN GORWTH" хөтөлбөрт хамруулж Монгол Улсын гавьяат агрономч Т.Баярхүүгийн удирдлага дор 2 удаагийн дадлага сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж 5 га талбайд төмсний супер эпит үрийг эрчимжсэн технологиор тариалж га-аас авах ургацыг 100 цн-ээр нэмэгдүүлсэн.Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 217,3 га талбайд тариалалт хийж, тариалангийн талбайн хөрснийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, цөлжилт, газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүдлийг сааруулах зорилгоор 15,69 га талбайд 50,921 ш мод бут, доройтсон ой, заган ойг нөхөн сэргээхэд 31,32 га талбайд 47966 ш мод бут тариалж хамгаалалтын зурвас байгуулсан.	100%

28	65	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	1.7/. Хөрсний шим тэжээлийн бодисын алдагдлыг нөхөх, ургацын чанар, хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, улмаар импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлээр Алтан ширээгийн Гарн тос боловсруулах үйлдвэрийн дэргэд азотын бордооны, Эрдэнд үйлдвэрийн зас хайлуулах үйлдвэрийг түшиглэн фосфорын бордооны үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, цаашид хэрэгжилтийг хангаж ажиллах;	Алтан ширээгийн Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд 2028 онд ашиглалтад оруулахаар төслийн баг ажиллаж байна. Уг ажлыг шуурхай гүйцэтгэхэд орон нутгаас шалтгаалах ажлуудад дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллаж байна. Азотын бордооны үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг хийгдэж байгаа тухай Монгол Улсын Засгийн газраас мэдэгдсэн, хамтран ажиллах тухай чиглэл ирээгүй, мэдээлэлгүй байгаа тул орон нутгаас тухайн үйл ажиллагааны хэрэгжилт гаргахгүй болно. Айраг суманд үйл ажиллагаа явуулдаг "Говийн шим хишиг" ХХК нь малын бууцаар компост бордоо үйлдвэрлэн савлаж энэ онд аймгийн газар тариалан эрхлэгчдэд 3 тонныг нийлүүлсэн. Хөрс боловсруулалтыг сайжруулах ажлын хүрээнд аймгийн 15 тариалан эрхлэгчдийг "Green Growth" хөтөлбөрт хамруулан Монгол улсын аварга тариаланч Л.Лувсанпүрэвийг газар дээр авч ирж хөрс боловсруулалтын дадлага сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж тариалангийн талбайг 3 бүлэгт хуваан 3-н ментор агрономчийг томилон тариалалтаас ургац хураалт хүртэл үе шат бүрд заавар зөвлөмж өгч, тандалт судалгааг хийж ажилласан. Хаврын тариалалтын хугацаанд 5 сарын 15, 6 сарын 03-ны өдрүүдэд Сайншанд сумын тариаланчдын талбайгаар 2 удаа явж хөрс боловсруулалт, тариалалтын явцтай танилцаж, мэдээлэл зөвлөмж өгсөн. Мөн 2024 оны 8, 10 дугаар сард Сайншанд Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххат сумдын талбайд өвчин хорсны судалгааг Ургамал, газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран хийж ургамал хамгааллын зохистой байдлын талаар дэлгэрэнгүй зөвлөмжийг тариаланчдад хүргүүлсэн.	Х.Б
	66		1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Аймгийн хэмжээнд газар тариаланд 421 хүлэмж, 74 трактор, төмний комбайн 1, төмс ухагч 3, хүнсний ногоо хураагч 4, хадуур тармуур 22, хаман боогч 2 зэрэг 10 гаруй нэр төрлийн техник ашиглагдаж, техникийн шинэчлэлт урьд оноос 17.2%-иар өссөн. "Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын дагуу хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд газар тариалан, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдаж, 188.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 300 мкв хүлэмж, 2 мотоблок, 9.5 га талбайд дуслын усалтын систем, 85 тонны усны нөөцийн савыг ашиглалтад оруулж техникийн шинэчлэл хийсэн. Дэлхийн зөн ОУБ-ын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төслийн хүрээнд Иххат сумын "Өнгөт" малчдын бүлэгт 79.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг олгоосон. Аймгийн ИТХ-аас тариалан эрхлэгч 21 иргэнд хөрс халаагч, ургамал хамгааллын автомаксыг олгон дэмжлэг үзүүлсэн. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын 7 дугаар багт, орон нутгийн тариаланчдын ногоог хадгалах зориулалт бүхий зоорийг байгуулахаар төлөвлөн, гүйцэтгэгчээр шалгарсан "Хөх оноо" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Сайншанд сумын 3 дугаар багийн 1 иргэн газар тариалангийн гар багаж үйлдвэрлэх, агропаркийн засвар үйлчилгээ үзүүлэх төвийг шинээр байгуулж, тариалан эрхлэгчид, иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	100%
29	67		1.1/. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай: 1/ төслийн 1, 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажлын зургийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулж, ажлын гүйцэтгэлийг хянан, тодорхой арга хэмжээ авч, ажлыг эрчимжүүлэх;	2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан Дорноговь аймагт хэрэгжих 11 төсөл арга хэмжээний ажлын зургийг аймгийн ерөнхий архитектор, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын хяналтын улсын байцаагч нар хянан баталгаажуулан, Барилгын хөгжлийн төвийн магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан.	70%
	68		1.2/. төслийн 3, 4 дугаар ээлжийн барилга угсралтын ажлыг төлөвлөгөөт хугацаанд чанартай гүйцэтгэн дуусгаж, ашиглалтад оруулах ажлыг удирдан зохион байгуулах;	2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймагт хэрэгжсэн 11 төсөл арга хэмжээний 8 төсөл арга хэмжээ бүрэн дуусаж ашиглалтад орсон. Он дамжин хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээний хэрэгжилт 88-90%-тай байна.	70%
	69	"Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 5 дахь дэд заалтын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БСШУСБХ	1.3/. төсөлд нэг маягийн зураг, төсөв ашиглах бол холболтын зураг төсөл, тухайлсан байршилд шинээр зураг төсөв боловсруулан гүйцэтгэхэд ажлын даалгавар, геологи, геодезийн дүгнэлт, байгаль орчны ерөнхий үнэлгээ, техникийн нөхцөлүүдийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгох, мэргэжлийн байгууллагаар хянагдан магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох байгууллагад 2022 оны 02 сарын 15-ны дотор хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн засаг дарга нарт үүрэг болгох;	2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан тус аймгийн Замын-Үүд сумын 640 хүүхдийн сургууль, Хатанбулаг сумын 320 хүүхдийн сургуулийн барилгуудыг Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар "Эм Эс Эл" ХХК, "ТТТ" ХХК-д боловсруулсан нэг маягийн жишиг зураг төсвөөр барьж гүйцэтгүүлсэн.	100%
	70		1.4/. захиалагчаас тогтоосон нөхцөл, техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэгчийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу 2022 оны 4 дүгээр сард багтаан тус тус сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлэн гүйцэтгэлд хяналт тавих;	Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан Дорноговь аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 4-р сард багтаан аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн 11 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан.	100%
	71		1.5/. тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн бүтээн байгуулалтын явцад хяналт тавьж, харууссан чиглэлээр үүрэг, зөвлөмж өгч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгох;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд Дорноговь аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 11 төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явцад аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан.	100%
	72		1.6/. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлд аудит хийлгэн, аудитын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх.	Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд үндэслэн Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын хяналт шалгалтаар гарсан 11 албан шаардлагын биелэлтийг тогтоосон хугацаанд албан шаардлагын биелэлтийг албан бичгээр хүргүүлж, мөн auth.ito.gov.mn системд шивж илгээсэн.	100%

30	73		1.4/ Мал, амьтны гоц халдварт өвчний гаралт, тархалтыг таслан зогсоох зорилгоор отор, нүүдэл, шилжилт хөдөлгөөнд тавигдах мал эмнэлгийн болон бусад мэргэжлийн байгууллагуудын хяналтыг сайжруулах талаар онцгой арга хэмжээ авах, зарим эрсдэлтэй бүс нутгийн мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мал эмнэлгийн хорио цээрийн байнгын болон түр хяналтын цэгийг нэмэгдүүлж, мал эмнэлгийн нэгдсэн бүртгэлийг сайжруулах;	2024 оны жилийн эцсийн байдлаар малын гоц халдварт 2 төрлийн өвчин давхардсан тоогоор 14 суманд оношлогдож, нийт 14975 толгой мал өвчлөн 10 толгой мал хоргодож, 127 толгой малын шинж тэмдэг арилж, 14838 толгой малыг зориудын аргаар устгасан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад өвчилсөн малын тоо 16 дахин өссөн нь шинэ төрлийн өвчин гарч, оношлогдох хугацаа алдсантай холбоотой. Гоц халдварт ямааны готрон өвчнөөр 92 өрхийн 14639 толгой малыг устгаж, материалыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлсэн. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шилжилт хөдөлгөөнийг хяналтад авах ажлыг сумдын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар цахим системээр дамжуулан өдөр тутмын хяналтыг гүйцэтгэж байна. Хөвсгөл, Хатанбулаг суманд хязгаарлалтын дэглэмийг хэрэгжүүлэн голомт, сэжигтэй бүсээс мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний хөдөлгөөнийг зогсоож, хяналт тавьж, өвчлөлийг нэмэгдүүлэхгүй байх	100%
	74	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ	1.5/ Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүрийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох;	Малын гоц халдварт 3 төрлийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 10669 өрхийн 1.5 сая толгой мал, амьтныг хамруулан үйлчилгээний хөлсөнд 776.0 сая төгрөгийг улсын төсвөөс мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон. Дээрх ажлыг гүйцэтгэхэд нийт давхардсан тоогоор 121 ажлын хэсэгт 122 малын их эмч, 163 туслах ажилтан нийт 285 хүн 145 тээврийн хэрэгсэлтэй ажилласан. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын явц, гүйцэтгэлд хяналт тавих, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах ажлын хүрээнд давхардсан тоогоор 14 сумын 26 аж ахуй нэгж, 125 малчин өрхийг хамруулан хяналтыг хийхэд 8 төрлийн алдаа илэрсэнд хариу арга зүйн зөвлөгөөг өгч, дутагдлыг 100 хувь арилгуулсан. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг технологит хугацаанд гүйцэтгэх, үзлэг тандалтыг тогтмол зохион байгуулснаар 2024 оны 04 дүгээр улирлын байдлаар мал, амьтны гоц халдварт өвчний гаралттай тэйвэр байна	100%
	75		1.6/ Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Малын тоо толгойн албан татварыг сумдад тэглэсэн нь 2023-2024 оны өвөл, хаваржилт хүндэрч, малын хоргодол өндөр байсантай холбоотой. Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх 2024 оны төлөвлөгөөний дагуу 7 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 501.7 мянган толгой малыг хамруулахаар төлөвлөснөөс 501.4 мянган толгой малыг хамруулж гүйцэтгэл 99.9 хувьтай. Орон нутгийн төсвөөс үйлчилгээний хөлсөнд 217,8 сая төгрөг, вакцины үндэ 255.8 сая төгрөгийг Биокмбинат төрийн өмчит ХХК-д шилжүүлсэн. 2024 онд 3 суманд 3 төрлийн халдварт өвчин аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторийн шинжилгээгээр оношлогдож, сумын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар хариу арга хэмжээг холбогдох хууль, журам зааврыг баримтлан хэрэгжүүлсэн. Тухайн өрхийн мал сүрэгт үзлэг тандалт хийж, дархлаажуулалтад хамруулснаар өвчний гаралт тархалтыг зогсоосон.	100%
	76		1.7/ Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд вакцин болон халдваргүйтгэлийн бодис, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрэн бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусгах;	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд халдвар хамгааллын хувцас 3200 ширхэг, халдваргүйтгэлийн бодис 3.2 тн, бээлий 560 ширхэг, нөөцлөсөн. Яаралтай дуудлага үйлчилгээний халдваргүйтгэлийн 2 машин, суудлын 1 автомашины бэлэн байдлыг хангаж, ажилласан.	70%
31	77	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/ Улсын хэмжээнд сум бүрийг "Ахмадын өргөө"-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	Тайлант онд ахмадын 14 салбар хороо, мэргэжлийн байгууллагын 37 зөвлөл үйл ажиллагаагаа тогтмол явуулж 7480 ахмад үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 30 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 12937 ахмад настныг хамруулсан. Ахмад настны хөгжил оролцоог дэмжих чиглэлээр сум бүр ахмадын өргөөг барьж ахмад настуудад үйлчилж байгаа бөгөөд урсгал зардал, тоног төхөөрөмжийг тухайн орон нутгийн төсөвт суулган санхүүжүүлж байна. Айраг сумын ахмадын өргөөний өргөтгөл засварын ажлыг гүйцэтгэхээр "Мунара констракшн" ХХК шалгарч 117,6 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн. Хатанбулаг сумын ахмадын өргөөний дотор тохижилтын ажлыг ОНХС-н 7,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.	100%
32	78	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 УББХ	1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	"Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын дагуу хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд газар тариалан, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдаж, нийт 188,0 сая төгрөгийн санхүүжилт авч, тариалан талбайн хэмжээг 40 га-аар нэмэгдсэн. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-гаас хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 аж ахуйн нэгж 556,3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, үйлдвэрлэлийн хүчин чадал, цар хүрээг өргөжүүлсэн. Алтанширээ, Хөвсгөл сумдын "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 2 хоршоонд махны үйлдвэрлэлийн чиглэлээр 160,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд хүнсний үйлдвэрлэл, мах, сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр 67 хоршоонд нийт 7,8 тэрбум төгрөгийн зээл олгож дэмжлэг үзүүлсэн. "Цагаан сүүний буян" ХХК, "Хашаатын говийн заг" ХХК 50,0 сая, "Сүүн дэлгэрэх шанд" ХХК-д нийт 345,0 сая төгрөг, "Түншлэл ба хөгжил" аймгийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд "Өгөөж эрдэнэ дэлгэрэх" ХХК-д 150,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлээ өргөжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлж, сав баглаа боодлоо шинэчлэх, малын хашаагаа засварлахад зарцуулсан байна.	70%

33	79	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №02 БОХХААБХ	1.2/ Импортологч улсын хорио үзэрийн байгууллагаас тавьж байгаа шаардлагын дагуу хяналт шалгалтыг дотооддоо зохион байгуулж, мах махан бүтээгдэхүүн экспортолох эрх бүхий үйлдвэр, бүтээгдэхүүний тоо хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх;	Амьд малын экспортыг нэмэгдүүлэн малчдын амьжиргааг дэмжих ажлын хүрээнд Замын-Үүд сумын "Мал эрүүлжүүлэн тусгаарлах бүс"-д нийлүүлэгдсэн 55,000 мянган толгой амьд малыг 2 улсын мал эмнэлгийн хорио цээрийн шаардлагыг хангуулан БНХАУ-руу гаргаж, эдийн засгийн эргэлтэд оруулсан. Мөн оны өмнөх үетэй харьцуулахад борлуулгдсан малын тоо 3.2 дахин буурсан нь цаад талын махны үнэ ханш буурсантай холбоотой.	70%
34	80	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4/ Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	Тусгай хамгаалалттай газар нутагт газар эзэмших, ашиглах эрх олгогдоогүй болно.	Х.Б
	81		1.1.4/ асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйн, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнгаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;	Сэтгэл зүйн боловсролд анхаарах зорилгоор ХГБХХГ-н сэтгэл зүйн Сайншанд сумын түр хамгаалах байранд байрласан нийт 10 хүүхэд, насанд хүрсэн 1 иргэн, сэтгэл зүйн зөвлөгөө авахаар хандсан 14 иргэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авгагдсан 12 хүүхэдэд тест, асуулга, проектив тест, ярилцлага хийх, темперамент тодорхойлох, зан үйлийн тодролыг тодорхойлох зэрэг хэлбэрээр ажилласан. Алтанширээ сум 38 эцэг эхийг хамруулан "Тэр бүлийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 5 байгууллага хүүхдийн өрөөг шинээр тохижуулсан. ХГБХХГ болон Хамтарсан багийн нийгмийн ажилтнуудын зүгээс насанд хүрээгүй 31, насанд хүрсэн 1, 3 гэр бүлд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх, сэтгэл зүйн анхан шатны үйлчилгээг үзүүлсэн. Сэтгэл зүйчийн зөвлөгөө өгөх өрөөг тохижуулахад шаардагдах 11.2 сая мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий төслийг хүргүүлж шийдвэрлүүлсэн. Шүүхийн байгууллагатай хамтран гэр бүлийн салалтын үе дэх хүүхэд хамгаалал, шинжээчийн дүгнэлт боловсруулах арга зүй, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг хамтран хэрэгжүүлэх чиглэлээр 2 байгууллагын холбогдох албан хаагчдыг оролцуулсан уулзалтыг зохион байгуулсан. Мэргэжлийн сэтгэл зүйчийн сул орон тоог нөхөх зорилгоор Сэтгэл зүйчээр суралцаж буй 1 оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	70%
	82		1.1.9/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүүхдээс мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөө бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа хохирогчтой ижил хүйсийн байцаагч ажиллуулах;	Тайлант онд ахмадын 14 салбар хороо, мэргэжлийн байгууллагын 37 зөвлөл үйл ажиллагаагаа тогтмол явуулж 7480 ахмад үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 30 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 12937 ахмад настныг хамруулсан. Ахмад настны хөгжил оролцоог дэмжих чиглэлээр сум бүр ахмадын өргөөг барьж ахмад настуудад үйлчилж байгаа бөгөөд урсгал зардал, тоног төхөөрөмжийг тухайн орон нутгийн төсөвт суулган санхүүжүүлж байна. Айраг сумын ахмадын өргөөний өргөтгөл засварын ажлыг гүйцэтгэхээр "Мунара констракшн" ХХК шалгарч 117.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээн авсан. Хатанбулаг сумын ахмадын өргөөний дотор тохижилтын ажлыг ОНХС-н 7.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэсэн.	100%
	83		1.1.12/ "Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх.	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, ХНХС-ын "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай" 2022 оны А/110 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд 144 аж ахуйн нэгж байгууллагын "Эцэг эхийн зөвлөл" ажиллаж байгаа бөгөөд 83 байгууллага Хүүхэд хамгааллын бодлогоо баталж хэрэгжилтийг ханган ажилласан. "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан "Гэр бүлдээ бичих захидал" арга хэмжээ, 39 байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчид болон гэр бүлийн гишүүдийг хамруулсан хөгжөөнт тэмцээн уралдаан, "Тэр бүлдээ зарцуулах цаг хугацаа үнэ цэнэ", "Хүүхдийн эрх үүрэг", "Давсаа хасъя", "Манай гэр бүл" зэрэг 89 сургалт, 135 нөлөөллийн арга хэмжээн зохион байгуулж 9100 иргэнийг хамруулсан. Сайншанд сумын 32 төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн 66 гишүүдийг оролцуулан Өсвөр насны охид, хөвгүүдэд тулгарч буй асуудал, цахим орчны зөв зохистой хэрэглээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үүргийн талаарх мэдээллээр хангах, нийгмийн оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор уулзалт арга зохион байгуулсан. "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оролцогч талуудын идэвхийг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2024 оны 03 сарын 28-ны өдөр зохион байгуулж 54 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүн, 6 байгууллагын дарга эрхлэгч нарыг оролцуулсан. Энэхүү ажлын рүн өсвөр насны хүүхдийн онцлог, тулгамдаж буй асуудлын талаар байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл нэгдсэн ойлголттой болсон. Хэлэлцүүлгээс байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулагдах төсөв	100%

	89		б/г. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	НҮБХХ-ийн "Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төсөлтий хамтран "Орон нутгийн төсвийн төслийг үр дүнд суурилсан арга зүйгээр боловсруулах нь" сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд аймаг, сумын санхүүгийн ажилтан нийт 90 гаруй албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Төслийн зөвлөхүүдээс зөвлөгөө, мэргэшил арга зүйн дэмжлэг авч орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулан Сангийн ямаар хянуулсан.	100%
37	90	Засгийн газарт чиглэл өгөх тухай (ЕЗСХБХ) 2023-11-01 Дугаар 2023_10	1.4. Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хүнийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх;	Төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулах ажлыг улирал бүр тогтмол зохион байгуулж ажилладаг. Төрийн албаны шалгалтад бүртгүүлэхэд иргэдээс цагдаагийн тодорхойлолт болон (e-mongolia) гэмт хэргэт холбогдож байсан эсэх талаарх тодорхойлолтыг шаарддаг. Иймээс төрийн байгууллага, албан тушаалд ёс зүйн зөрчил гаргаж байсан албан тушаалтан томилсон тохиолдол гараагүй болно. Тайлант онд удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтыг 3 төрлөөр 9 удаа зохион байгуулан, 39 ажлын байрыг нийтэд зарлан төрийн захиргааны төсвийн шууд захирагч 4, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагч 9, төрийн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд хамаарах бүтцийн нэгжийн удирдах албан тушаал 4 буюу нийт 17 удирдах албан тушаалын сул орон тоог шатлан дэвших зарчмын дагуу нөхсөн	100%
	91		1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.	Х.Б
38	92	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЕЗДБХ	1.3 . төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	УИХ-ын Ёс зүйн байнгын хороо, ЗГХЭГ, ТАЗ-өөс зохион байгуулсан "ТАХ-ын ёс зүй, манлайлал, гүйцэтгэл, үр дүнд, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих, чадавхжуулах сургалт"-д Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс тус хуулийн сургалтыг танхимаар 507 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 1,353 төрийн албан хаагчдыг хамруулсан. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагын дэргэдэх 102 ёс зүйн дэд хороог 300 гаруй албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус хорооны гишүүдийг ёс зүйн хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, арга зүйг хангаж, чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөд байна.	100%
Ерөнхийлөгчийн зарлиг					
39	93	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиулэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Соёлын салбарын бүх байгууллагууд гадна болон дотор хаягаа хос бичгээр бичиж байршуулсан. 2025 оноос бүх нийтээр хос бичигтэн болох зорилгын хүрээнд аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран төрийн албан хаагчдад үндэсний бичгийн цахим бичвэрийн сургалтыг зохион байгуулсан. Соёлын салбарын 8 байгууллага үндэсний бичгийн булан байгуулан хос бичгээр мэдээ мэдээллийг албан хаагчдад хүргэн ажилласан. Эх хэлний өдрийг тохиолдуулан 2 байгууллага үндэсний бичгийн уралдаан зохион байгуулж 36 сурагч, 10 албан хаагчыг оролцуулсан. Төрийн албан хаагчдын дунд "Тунгаамал" - Үсгэлэлийн хаад" тэмцээнийг Насан туршийн суралцахуйн төв, БШУГ-тай хамтран зохион байгуулж Стандарт хэмжил зүйн хэлтэс, ШШГГазар, ЭМГазар, 8-р цэцэрлэг, 12 дугаар цэцэрлэгийн 5 баг оролцлоо. Мөн "Үсгэлэлийн хаад" тэмцээнийг аймгийн төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж 22 байгууллагын 78 албан хаагчийг хамруулан зохион байгуулж бүх нийтээр хос бичигтэн болоход үндэслэж	100%
40	94	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Аймгийн Засаг даргын баталсан Сайншанд сумын зарим аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалтын ажил зохион байгуулах удирдамжийн дагуу 2024 оны 07 сарын 17-ны өдрөөс эхлэн 2024 оны 10 сарын 29-ны хооронд сургуулийн орчмын болон эрсдэл өндөр бүхий газруудыг хамруулан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтад нийт хүнсний худалдааны 34 аж ахуйн нэгж, 17 иргэн, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 2 ААН, 2 иргэн, цахим тоглоомын үйл ажиллагаа явуулдаг 1 иргэн хамрагдсан. Шалгалтаар чанар аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн болон гарал үүсэл тодорхойгүй Хятад хэл дээр бичигдсэн шошготой давхардсан тоогоор 289 нэр төрлийн 3498 ширхэг 6,217,300 төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, зөрчил ихээр илэрсэн болон холбогдох хууль, дүрэм, журам, стандарт мөрдөөгүй 2 ААН-д 4 сая, 2 иргэнд 600.0 мянган төгрөг нийт 4.6 сая төгрөгийн торгууль шийтгэл ноогдуулсан. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 45 заалт бүхий 5 зөвлөмж, 19 заалт бүхий 2 албан шаардлагыг тус тус хүргүүлэн холбогдох мэргэжлийн байгууллагууд хяналт тавин ажиллаж байна.	100%

95			<p>1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах</p> <p>Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах</p>	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 15/08 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар 889.9 сая төгрөгийн төсвийн сумдад хуваарилж "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд 357.9 сая төгрөг, амьтны нөөцийг хамгаалахад 150.0 сая төгрөг, ус рашааны нөөцийн ашиглалт, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд 382.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.</p>	100%
96			<p>1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээх бүх нийтийн үйлс болгох</p>	<p>Даланжаргалан, Мандах, Хөвсгөл, Иххэт сумдад иргэдийн иргэдийн ая тухтай амрах нөхцлийг бүрдүүлж ногоон байгууламж бүхий 5.06 га талбайг байгуулсан. Мод тарьж ургуулсан 6 өрх, 3 аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулж, 25 иргэн, 40 аж ахуйн нэгж байгууллагад модны гэрчилгээ олгож бүртгэлжүүлсэн. Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах зориулалтын усалгааны автомашиныг 52.1 сая төгрөгөөр худалдан авч мод усалгаанд ашиглаж байна. Ахмадын сувиллын орчинд 1,7 сая төгрөгийн үнэ бүхий сухайн 350 ширхэг мод, Хүүхдийн зусланд 37ш хайлаас, Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнд хайлаас, сухай, улиас, агч зэрэг 4 төрлийн 10000ш мод ургаж байгаа бөгөөд 2024 онд 650 ш мод нөхөн тарилтаар тарьж, 80 хувийн ургалттайгаар ургаж, нийгмийн бүхий л салбарт чиглэсэн амрах чөлөөт цагаа зөв боловсон өнгөөрөх ногоон орчинг бүрдүүлээ. Мөн Сайншанд сумын 8-р багт Говь парк цэцэрлэгт хүрээлэнг байгуулах зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, баталгаажуулснаар 2025 оноос зураг, төсвийн дагуу санхүүжилтийг шийдвэрлэх боломж бүрдсэн."Жайка"-гийн түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд аймгийн Байгаль орчны газартай хамтарсан "Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай, хүйтэн газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн хамтын ажиллагааны төсөл"-ийн эрдэмтэд судлаачид төслийн хүрээнд хийгдсэн ажлаа танилцуулж, Дорноговь аймагт хэрхэн амжилттай мод тарьж ургуулах талаар мод үржүүлэг эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд болон иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, Ерөнхий боловсролын 1-р сургуулийн гаднах ногоон байгууламжийн модонд модны тайралт, таналт хийх</p>	100%
41	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58		<p>1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах</p>	<p>Мандах суманд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 17.0 сая төгрөгөөр 5 га газар талбайд дуслын усалгааны систем суурилуулсан. Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг "Чойрын богд ложистик" ХХК-ийн дэргэдэх мод үржүүлгийн талбайд 2 худаг шинээр гаргаж, үржүүлгийн үйл ажиллагааг нэмэгдүүлсэн. Мөн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэх сумын 4-р багийн нутагт байрлах Хонгорын овооны 0.6 га газрыг хамгаалж хашаалан, усан сан болон усалгааны систем суурилуулсан. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон Сайншанд сумын хотын ногоон байгууламжид мод тарих ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газраас 24,0 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн усалгааны систем олгож системийг суурилуулах ажлын зураглалыг гарган ирэх хавар хийхээр хүлээгдэж байна. Эрдэнэ сумын замын зурвас 6 га газрыг ойжуулалт хийхэд зориулан орон нутгийн хөгжлийн сангийн 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр мод усалгааны 5 тонны багтаамжтай 2 усны савыг байршуулан 1,4 км-т шугам татаж, зөөврийн асуудлыг хялбаршуулсан.</p>	100%
98			<p>1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх</p>	<p>Монгол Улсын шинжлэх ухааны академиас манай орон нутгийн уур амьсгал, хөрс, газрын гадаргуу, бүс бүслүүрт тохирсон, дасан зохицсон байдлыг харгалзан тарих мод сөөгийн жагсаалтыг ирүүлсний дагуу байгальд тарих болон сумын төвд тарих боломжтой модны төрлийн жагсаалт бүхий зөвлөмжийг сумдад хүргүүлж мөрдлөг болгон ажилласаар байна. Айраг, Алтанширээ, Замын-Үүд суманд цөлөрхөг хээрийн бүсэд, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Сайншанд суманд хуурай хээр, цөлөрхөг хээрийн бүс, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ суманд цөлөрхөг хээр, цөлийн бүсэд, Мандах, Хөвсгөл, Өргөн суманд хуурай хээр, цөлөрхөг хээр, цөлийн бүс бүслүүрт тус тус хамаарагддаг. Байгаль орчны газрын дэргэдэх мод үржүүлгийн талбайд Япон улсын "Жайка"-гийн түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд Нийгата мужийн Гадаадтай технологийн талаар хамтран ажиллах нийгэмлэг болон Байгаль орчны газрын хамтран хэрэгжүүлж буй "Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай, хүйтэн газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн хамтын ажиллагааны төсөл" 2009 оноос хойш хэрэгжиж, үр дүн 100%-тай II шат амжилттай дууссан. Цаашид III шатны төслийн ажлыг үргэлжлүүлэх зорилгоор тус байгууллагад хүсэлт гаргасан, уг төслийн судалгааны ажлын үр дүнгээс гарсан зөвлөмжийг 2025 онд хэрэгжүүлэх массын тариалалтад нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөсөн. Мөн "Монгол Хятадын цөлжилтийг сааруулах хамтын ажиллагааны төв" байгуулах төслийн хүрээнд, "Тангийн эрдэлээс урьдчилан сэргийлэх, цөлжилтийг сааруулах, бэлчээрийг нөхөн сэргээх" тухай хамтын ажиллагааг эрчимжүүлэх,</p>	100%

42	99	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зорилгоор Сайншанд сумын 1 дүгээр багт тоглоомын талбай байгуулах ажлыг 74,3 сая төгрөгөөр "Айсуй хөгжил" ХХК, Сайншанд сумын 7 дугаар багт тоглоомын талбай байгуулах ажлыг 71,7 сая төгрөгөөр "Эгнэгт өрнөх" ХХК гүйцэтгэж дууссан. Мөн Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх ажлыг 88,6 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлыг Дорнын Очир далай ХХК гүйцэтгэж 50%-тай, 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажлыг 491,0 сая төгрөгөөр Сутай Жинст ХХК гүйцэтгэж 48%-тай явагдаж байна. Улаанбадрах, Айраг сум Соёл, спортын төвдөө 71,7 сая төгрөгөөр их засвар гүйцэтгэсэн. Мөн ОНТ-өөр Алтанширээ суманд Спорт заал барих ажлыг 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж, ажлын явц 50%-тай байна. Аймгийн Усан спорт сургалтын төвд дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засвар хийх ажлыг 449,8 сая төгрөгөөр гүйцэтгэж иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Тайлант онд 2,4 тэрбум төгрөгөөр хөрөнгөөр биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудад дэмжлэг үзүүлсэн.	100%
43	100	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг залах уриалгыг хэрэгжүүлж албан байгууллагуудыг Чингис хааны эш хөргийг залах уриалга гаргаж байгууллагууд Чингис хааны эш хөргийг албан байгууллагадаа залсан. Зохион байгуулагдсан арга хэмжээ дээр олон нийтэд Эзэн Богд Чингис Хааны эш хөргийг залах уриалгыг дэвшүүлэн ажилласан.	70%
	101		4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахих буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Эзэн Богд Чингис хааны суу алдрыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд "МОНГОЛ БАХАРХЛЫН ӨДӨР" арга хэмжээг зохион байгуулж, Дорноговь аймагас төрөн гарсан алдартнуудын таниулан алдаршуулсан. Монгол бахархлын өдрөөр Музей сургалт судалгааны түвд хадгалагдаж буй "Эзэн Чингис хааны хангал эхт цагаан сүлд"-нд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж Сайншандын 300 сурагчид оролцоо. Монголын түүхийн хичээлээр Сайншандын 1-р сургууль AR, VR төхөөрөмж ашиглан цахим кабинетдаа виртуал "Хархорин", "Бурхан Халдун", "Чингисийн товчоон" зэрэг сэдвээр аялуулж 670 сурагчийг хамрууллаа. "Торгон хил-Эх орон" сэдвээр зохион байгуулж 658 сурагч, 110 багш, ажилчид болон эцэг эх, иргэд 56, нийт 824 хүн хамрагдлаа.	100%
УАБЗ-ийн зөвлөмж					
44	102	Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх тухай 2010-03-18 Дугаар 2010_10/09	1. Хот, суурингуудад ашиглахыг хориглосон болон эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилга, байгууламжуудыг дахин төлөвлөж, олон улсын стандартын дагуу шинэчлэх,	Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн өмчийн болон нийтийн орон сууцны барилгуудад тогтмол үзлэг шалгалт хийж, шаардлагатай их засварын үйлчилгээний зардлыг жил бүрийн орон нутгийн төсвөт тусгаж ирсэн. 2024 онд орон нутгийн төсвийн 19.9 тэрбум төгрөгийн өртгөөр 71 барилгад их засварын ажил хийгдсэн. Тус аймаг нь 2023, 2024 онуудад орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 27 барилга байгууламжийг паспортжуулах ажлыг "Бүүвэй цагаан барс" ХХК-аар гүйцэтгүүлсэн. Паспортжуулалтын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй нь тогтоогдсон Замын-Үүд сумын 1-р сургууль, Хөвсгөл сумын 160 суудалтай сургуулийн барилгуудыг буулган ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар шинээр барих ажлыг эхлүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дэлгэрэх суманд Соёлын төв, Даланжаргалан суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг шинээр барьж байна. Нутгийн Удирдлагын ордон, Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургууль, 2-р цэцэрлэгийн барилгуудыг шинээр барихаар зураг төслийн ажил хийгдэж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн салбар зөвлөлөөс барилга байгууламжийн паспортжуулалтын ажлын тайланг Шадар сайдын ажлын албанд хагас, бүтэн жилийн байдлаар хүргүүлэн ажилласан.	100%
	103		3. Газар хөдлөлтийн аюул, гамшигтай тэмцэх мэдлэг чадвар, дадал эзэмшүүлэх иргэний хамгаалалтын сургалт, дадлагыг улсын хэмжээнд байнга, тогтмол давтамжтайгаар зохион байгуулах, үр дүнг нь тооцдог байх,	Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, Монгол улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргын тус тус баталсан "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний удирдамж"-ийн дагуу тус арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Монгол улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын дагуу гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги болон аж ахуй нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, орон нутгийн хэмжээнд ашиглагдаж байгаа зарлан мэдээлэл дамжуулах 13 сирень дохионы техникийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг, шалгалт хийсэн. Аймгийн хэмжээнд 83 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн "Цугларал талбай"-н тэмдэглэгээг тодотгож, орон нутгийн "Дорноговь ТВ", "Доб" телевизтэй хамтран ажиллах гэрээний дагуу газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах, дадлага сургуулийн талаар сурталчлан таниулсан. Мөн Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн бэлэн байдлыг хангуулах зорилгоор хээрийн үүргэвчинд байвал зохих зүйлст үзлэг хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Онцгой байдлын газрын даргын баталсан хуваарийн дагуу тус газрын офицер бүрэлдэхүүн, байгууллага бүрт "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдвээр 117 цагийн хугацаатай танхимын сургалт хийхэд 157 байгууллагын нийт 3205	100%

48	109	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.10.. Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг улс орон даяар зохион байгуулах	Мэргэжлийн байгууллагуудаас гаргасан хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх боршур, шторжийг байгуулсан веб сайт болон орон нутгийн олон нийтийн сүлжээгээр ард иргэдэд сурталчлан таниулан ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-тай хамтран Сайншанд суманд үйл ажиллагаа явуулдаг хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, буудлын үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 40 гаруй аж ахуйн нэгж, иргэний төлөөллийг хамруулан "Зочлох үйлчилгээний стандарт" сэдэвт сургалтыг 2024.04.23-ны өдөр зохион байгуулсан. Аймгийн ЭМГ, Цагдаагийн газар, Татварын газар, Дорноговь аймаг дахь Гаалийн газар, ЕБС-иуд, Эцэг эхийн төлөөлөл, Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл оролцсон "Аюулгүй хэрэглээ-эрүүл мэнд" сэдэвт уулзалтад "Хүнсний аюулгүй байдлыг хангахад хэрэглэгчийн дэмжлэг" сэдвээр илтгэл мэдээлэл тавьж, хүүхдийн аюулгүй, зөв хүнсний хэрэглээг бий болгохын тулд гарал үүсэл тодорхойгүй, шогшын мэдээлэл шаардлага хангахгүй, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй хоол хүнсний хэрэглээнээс татгалзах гэр бүл, сургууль, нийгмийн зүгээс үлгэр дуурайлал үзүүлж олон талаар хамтран ажиллах санал санаачилгыг дэвшүүлж, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл хүргэж ажилласан. "Хүнсний аюулгүй байдал" аяны хүрээнд 14 сумын хүнсний худалдааны 65 объект, хоол үйлдвэрлэл үйлчилгээний 34, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн 41, үйлдвэрийн 14 нийт 154 объектыг төлөвлөгөөт бус шалгалтад хамруулж, 16 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулан 521 иргэн аж, ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан мэдээлэл өгч 8 төрлийн зөвлөмж боршур тараасан.	100%
49	110	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-11-25 Дугаар 2022_03	1.3. Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол Монгол Улсын хөгжлийн бодлогод ницүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр сонгон шалгаруулалтын журмаар /нээлттэй болон хязгаарлагдмал/ зохион байгуулах тусгай зөвшөөрлийн талбаин хэмжээг тухайн сум дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх;	Аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбаин хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлж байна.	100%
3Г-ын тогтоол					
50	111	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс зохион байгуулсан үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд аймгийн төрийн байгууллагын нийт 2952 албан хаагч хамрагдсан ба үндэсний бичгийн мэдлэгийн түвшингээр маш сайн- 2.9%, сайн- 12.7%, дунд зэрэг- 34.3%, бага зэрэг- 31%, мэдлэггүй- 19%-тай дүгнэгдсэн. Иймд 2024 онд монгол бичгийн сургалтыг байгууллагын захиалгаар аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлийн нарийн бичиг, Насан туршийн суралцахуйн төв, ерөнхий боловсролын сургуулийн монгол хэлний багш нар үндэсний бичгийн сургалтыг зохион байгуулж, төрийн 26 байгууллагын 360 гаруй албан хаагч, боловсролын салбарын 54 байгууллагын 1800 гаруй багш, ажилчныг үндэсний бичгийн сургалтад хамруулсан. Ийнхүү монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оноос хойш монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 5000 гаруй албан хаагч, иргэдийг хамруулж, зохион байгуулсан. Аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөлөөс төрийн 11-12 дугаар сард 30 байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудасны монгол бичгийн эх бэлтгэлийг хийсэн ба үүнээс 8 байгууллага хэвлэмэл хуудсаа авч туршин хэрэглэж байна. MNS6395:2022 стандартыг хэрэгжүүлэх зөвлөгөө, цахим бичвэрийн сургалтыг Сайншанд сумын төрийн байгууллагын 25 бичиг, хэргийн ажилтныг хамруулан зохион байгуулсан. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг сорих "Тунгаамал" тэмцээнийг Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран 9 удаа зохион байгуулж, Сайншанд болон Замын-Үүд сумын 43 байгууллагын 225 төрийн албан хаагчийг хамруулаа. Мөн аймгийн төрийн бүх байгууллага MNS 6395:2022	100%
51	112	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, арга хэмжээг батлах тухай 2022-08-24 Дугаар 2022_314	2. "Төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027)"-ийг 1 дүгээр хавсралт, "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын болон олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт, салбарын болон аймаг, нийслэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний холбогдох байгууллагууд болон иргэдийг татан оролцуулж, батлагдсан төсвийн багцын дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл"-ийг сурталчлан таниулах "Монгол гэр" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зэрэг арга хэмжээ улсын хэмжээнд өрнүүлсэн. Аймаг орон нутгаас "Монгол гэр" үзэсгэлэнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг 2 иргэний бүтээлийг "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 3 иргэний бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтэд худалдаалан аймгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин ажиллалаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн арга хэмжээнд орон нутгаа төлөөлөн оролцсон байгууллага, хувь хүний дэмжин 26,0 сая төгрөг зарцуулсан. Монголын аялал жуулчлалын холбооноос жил бүр уламжлал болон зохион байгуулдаг "АйТиЭм" аялал жуулчлалын үзэсгэлэн экспод соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 3 аж ахуй нэгж, 4 иргэний 6 төрлийн бүтээлийг авч явж гадаад дотоодын жуулчин, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдэд сурталчлан танилцуулснаас гадна хамтран ажиллах гэрээ байгуулах, зарж борлуулах нөхцөлөөр ханган дэмжин ажиллалаа. Тус үзэсгэлэнд оролцох зардлын төсөвт аймгийн Засаг даргын А730 захирамжаар ОНТ-с 6,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Дорноговь судлал-2024" эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, илтгэл хэлэлцүүлэгт оюутан залуучууд, ахлах ангийн сурагчдыг оролцуулан, 13 илтгэлээс шилдгүүдээ тодруулсан. Эрдэм шинжилгээний хуралд нийт 3,1 сая төгрөгийг зарцуулсан ба 100 хүн үзэж сонирхсон. Мөн Ноён хутагт Данзанравжаагийн "Өнгөрсөн, одоо, ирээдүй" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлүүдийг 500 ширхэгийг хэвлүүлэн 5,0 сая төгрөг зарцуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг дэмжин ажилласан.	100%

52	113	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай.	Дорноговь аймаг 2024 оныг "Түншлэл - Хөгжил" жил болгон зарласан. Монгол-Хятадын эдийн засгийн түншлэлийн хүрээнд Зүүн Баян багт зохион байгуулсан "Талын түнш" арга хэмжээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн, ААН-ийг хамруулж 5,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Улаанбаатар хотод босон "Шинэ-Хоршоо" хөдөлгөөний нээлтийн арга хэмжээнд "Өмчий урлан", "Мондо урлан", "Chimivie fashion", "Эсгий урлал" зэрэг бичил бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ сурталчлан оролцсон. Орон нутгийн газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор "Цагаан сар" үзэсгэлэн худалдааг 14 сумын хэмжээнд жил бүр зохион байгуулж давхардсан тоогоор 120 иргэн, аж ахуйн нэгж, хоршоо нөхөрлөл, малчид оролцож 80 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. МҮХАҮТ, "Монгол брэнд" ХХК-тай хамтран өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, мэдээллийн нэгдсэн бааз (онлайн платформ)-ыг үүсгэж гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчлах ажлыг эхлүүлсэн. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих ХАА-н үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулахаар Сайншанд сумын 2-р багийн нутаг дэвсгэрт 849 м2 газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/589 дүгээр захирамжаар шийдвэрлэж, ашиглалтад оруулахаар бэлтгэж байна.	100%
53	114	Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-09 Дугаар 2022_402	1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан асуудал үүсээгүй байна.	Х.Б
	115		1.4. орон сууцны хороолол, цогцолбор барилгын 1, 2 дугаар давхарт цэцэрлэг байгуулах зорилгоор түрээслэх, худалдан авах, салбар бүлэг ажиллуулахад норм нормативыг мөрдүүлэх чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг авч, хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Аймгийн хэмжээнд орон сууцны хорооллын 1 дүгээр давхарт цэцэрлэгийн зориулалт төлөвлөлт хийж баригдсан 4 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Сайншанд сумын Мандах наран-2 хороололд 100 хүүхдийн 13-р цэцэрлэг, Замын-Үүд сумын Мандах наран-3 хороололд 100 хүүхдийн 6-р цэцэрлэг, Замын-Үүд суманд 150 хүүхдийн 7-р цэцэрлэг, хувийн хэвшлийн "Гурван билэг" цэцэрлэг тус тус барилгын норм, дүрмийн шаардлагыг ханган ажиллаж байгаа бол цэцэрлэгийн зориулалтаар түрээслэж буй барилга, байгууламж байхгүй аймгийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмж хэвийн байна.	100%
	116		2. Цаашид шинээр баригдах орон сууцны хороолол, цогцолбор барилга байгууламжийн зураг төсөлд цэцэрлэг төлөвлөх, ашиглалтад оруулах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажиллахыг дор дурдсан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай: 2.1. барилга байгууламжийн газар олголт, барилгажилтын төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг төсөлд холбогдох норм, дүрмийн дагуу цэцэрлэгийн барилгыг заавал тусган баталгаажуулж байхад хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 2.2. орон сууцны хороолол, цогцолбор барилгад төлөвлөгдсөн цэцэрлэгийн барилгыг бүрэн ашиглалтад орох хүртэл хугацаанд тухайн бүс нутгийн байршилд "Түр цэцэрлэг" байгуулан ажиллуулж байх талаар хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Сайншанд сумын 7 дугаар багт шинээр баригдсан Мандах наран хороололд 150 хүүхдийн цэцэрлэг барихаар тусгагдсан. Цэцэрлэгийн барилгын газар олголт, архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл батлагдсан ба барилгын ажлын тендер шалгаруулалтад "Унага трейд" ХХК шалгарч гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэж ажлыг хангаж байна. Энэ оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад Сайншанд суманд 150 ортой цэцэрлэгийн барилгыг шинээр барихаар 3321.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан. Замын-Үүд сумын 1-р сургууль өөрийн газар дээрх барилга буулган шинээр барилга баруулах ажил 30 хувьтай явагдаж байна	70%
	117		3. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын норм, дүрмийн шаардлагыг хангасан цэцэрлэгийн барилгыг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	"Аймгийн хэмжээнд орон сууцны хорооллын 1 дүгээр давхарт цэцэрлэгийн зориулалт төлөвлөлт хийж баригдсан 4 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Сайншанд сумын Мандах наран-2 хороололд 100 хүүхдийн хүчин чадалтай 13-р цэцэрлэг, Замын-Үүд сумын Мандах наран-3 хороололд 100 хүүхдийн хүчин чадалтай 6-р цэцэрлэг, Замын-Үүд суманд 150 хүүхдийн хүчин чадалтай 7-р цэцэрлэг, төрийн бус өмчийн Гурван билэг цэцэрлэг тус тус барилгын норм, дүрмийн шаардлагыг ханган ажилласан.Аймгийн хэмжээнд хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй 4 сум байгаа бөгөөд энэ онд 5 сум орон нутгийн төсвөөр хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажиллаж байна. Цаашид аймгийн хэмжээнд бүх сумдыг хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгох ажлыг эрчимжүүлэхээр төлөвлөн сумын Засаг дарга нарт холбогдох чиглэлийг хүргүүлсэн.	70%
118		4. Цэцэрлэгийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгөөр түрээслэх, худалдан авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, шаардагдах зардлыг жил бүрийн улс, нийслэл, орон нутгийн төсвийн төсөлд тусгахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Тайлант онд Сайншанд сумын 7 дугаар багт шинээр цэцэрлэгийн барилга барих ажлыг улсын төсвийн 3,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Унага трейд" ХХК гүйцэтгэж байна. Мөн цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламж худалдан авах, түрээслэх үйл ажиллагаа хийгдээгүй бөгөөд сургууль цэцэрлэгийн хүрэлцээ хэвийн байна.	100%	

54	119	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	<p>3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p> <p>/2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хуралбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./</p>	<p>"Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.07.04-ний өдрийн 12/02 дугаартай тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцад хамруулах журам"-ыг батласан. 2023 онд зарласан Түрээсийн орон сууц худалдан авах Багц-1 ажлын тендер 13.5 тэрбум төгрөгийн өртөгөөр "Гантулга трейд" ХХК шалгарч. Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт Мандах наран-5 хороололд 72 айлын 2 блок, нийт 144 айлын орон сууцны орон нутагт хүлээлгэн өгсөн. Тус ажлын 2-р багцад "Энержи парогон" ХХК шалгарч 30 айлын орон сууцныг 3.3 тэрбум төгрөгийн өртөгөөр нийлүүлэх гэрээ байгуулсан. Сайншанд сумын 3-р багт "Энержи парогон" ХХК нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлж, үйлчилгээтэй 144 айлын 2 блок орон сууц барьж, дээрх орон сууцны 1-р блокноос түрээсийн 30 айлын орон сууцныг гэрээний дагуу нийлүүлсэн. 2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг "Гантулга трейд" ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан. Тус компани нь Замын-Үүд сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 288 айл /72 айл*4 блок-ын орон сууцны төсөл хэрэгжүүлж, угсалтын ажлын явц 70%-тай байна. Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр газартай холбоотой аливаа хүсэлтийг зөвхөн egazar.gov.mn цахим системээр хүлээн авах, өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэхээр хуульчилсан тул шилжин сууршигчдад зориулсан газрыг шийдвэрлэх боломжгүй болсон. Дээрх тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаарх санал хүсэлтийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	100%
120	120		<p>4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.</p>	<p>"2023 онд Сайншанд суманд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар тусгагдсан нийт 43 нэгж талбарыг нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьшсан иргэдэд олгохоор төлөвлөснөөс нийслэлээс хөдөө орон нутагт шилжин суурьшсан 7 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлсэн бол 6 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлсэн. "Нээлттэй аймаг" зорилтот жилийн хүрээнд бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, сургалтыг зохион байгуулж "Бизнес ба хүний эрхийн зарчим", "Үйлчилгээнд анхаарах асуудал" зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж "Үйлчилгээний соёлны бид түгээн" уриалгад 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нэгдлээ. Эдгээр ажлын үр дүнд Улаанбаатар хот болон бусад аймгаас 1220 иргэн, 19 аж ахуй нэгж шилжин ирсэн нь өмнөх оноос 36 хувиар өссөн үзүүлэлттэй байна."</p>	100%
55	121	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	<p>1.12... 1.12 гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p> <p>1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>1.12 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, хотоос орон нутагт шилжин суурьшихыг дэмжих зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 60 хувь олгохоор 7,1 тэрбум төгрөгийг орон нутгийн 2024 оны төсөвт тусгасан.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудад ажиллаж буй төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцон сар бүр олгосон. Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийг 49 иргэнд 4.2 тэрбум төгрөгийг олгосон. Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хооронд орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйн хөгжлийн 2 үе шат MON-1907 төслийн хүрээнд 2006-2008 онд олгосон дамжуулан зээлсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт 1,8 тэрбум төгрөг зарцуулахаар орон нутгийн 2023 оны төсөвт тусган бүрэн төлж барагдуулсан. Аймгийн ОНХС-ийн 25 төсөл, арга хэмжээг төлөвлөж, цахим тендер 100% гүйцэтгэлтэй, гэрээ байгуулсан. 4,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. мөн сумын ОНХС 2024 онд нийт 201 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж тендер зохион байгуулж 10,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. ОНХС-ийн УМС 2024 оны хэрэгжилтийг 14 сум, Аймгийн ОНХС ийн хэрэгжилтийг тус тус гүйцэтгэл гарсан ажлуудыг тухай бүр оруулсан.</p>	100%
56	122	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08	<p>Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;</p>	<p>Орон нутгийн хэмжээнд "Авлигатай тэмцэх" чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэд олон нийт, төрийн албан хаагчдад зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор "Дэвжээ-2024" тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 16-29-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээнд сумдын ИТХ, ЗДТГ, агентлаг, байгууллагын нийт 10 гаруй баг оролцож тэмцээнд өгөгдсөн даалгавруудын хүрээнд 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, авлигыг мэдээлэх тусгай дугаарыг сурталчилсан шторх бүтээх, илтгэл хэлэлцүүлэх агуулгын хүрээнд зохион байгуулагдаж нийт цахим болон танхимын хэлбэрээр давхардсан тоогоор 55 мянга гаруй иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн.Мөн авлигатай тэмцэх шүгэл үлээх үйл ажиллагааг аймгийн Засаг даргын "Тогтвортой бодлого-Тасралтгүй хөгжил" 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган баталсан.</p>	100%

		Дугаар 2023_49	X-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийт 2757 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авснаас Засгийн газрын 11-11 төвд 241 өргөдөл утсаар, цахим хаягаар 4 өргөдөл, судлагдаж байгаа 367, бичгээр 2513 өргөдөл хүлээн авч 90,8 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан нь өмнөх оноос 2.5 хувиар өссөн байна. Аймгийн 15 төрийн байгууллагын 83 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлсэн. "ХурДан" төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг "e-mongolia.mn", "e-halamj.mn", "etax.mn", "e-gazar.gov.mn", "nd-daatgal.mn", "burtgel.gov.mn", "e-job.gov.mn" системээр дамжуулан төрийн үйлчилгээг цахимаар нэвтрүүлж байна.	100%
57	124	Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_63	3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасгай.	2023-2024 оны өвөл, хаврын улиралд мал аж ахуйн салбарт судын хүндэртэй нөхцөл байдал үүсч тус аймгийн 14 сумын 65 багийн 3750 малчин өрхийн 547,463 толгой буюу Дорноговь аймгийн нийт мал сүргийн 23,8 хувь нь зүй бусаар хоргодож, 428 малчин өрх нийт малынхаа 70 буюу түүнээс дээш хувийг, 41 малчин өрх 100 хувь буюу амьжиргааны эх үүсвэрээ бүрэн алдсан гэсэн статистик тоон мэдээ гарсан. Дээрх нөхцөл байдлын улмаас Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Сайншанд сумд малын тоо толгойн албан татварыг тэглэж, Өргөн, Мандах, Хатанбулаг, Эрдэнэ, Замын-Үүд сумд нийт 197,2 сая төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэн ажилласан. Тайлант хугацаанд улсын болон орон нутгийн төсвийн нийт 11,7 сая төгрөгийн санхүүжилтээр Өргөн сумын 24 өрхийн 2,600 толгой үхэрт технологит хугацаанд ангилалт хийж цөм сүрэгт 296, үржлийн сүрэгт 964, хэрэгцээний сүрэгт 1340 толгой үхрийг ангилан бүртгэлжүүлсэн.	100%
58	125	Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан "Цахим аймаг" болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасгай.	Төрийн үйл ажиллагаа болон нээлттэй мэдээллийг олон нийтэд ил байлгах зорилгоор shilen.gov.mn системд 160 байгууллага бүртгэгдэж, шилэн ажиллагааны системийн ашиглалтаар 5 төрлийн заалтын дагуу 98 заалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн мэдээллийг 120 гаруй байгууллага 10 мянга гаруй нээлттэй мэдээллийг байршуулсан байна. "Шилэн ажиллагаа"-г эрчимжүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг аймгийн төрийн цахим үйлчилгээний хэлтэс болон газартай хамтран төрийн бүх шатны 160 гаруй байгууллагын давхардсан тоогоор 640 албан хаагчийг хамруулан зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит нийт 57 байгууллага албан ёсны цахим хуудас ажиллуулж байгаа бөгөөд мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг тогтмол шинэчлэн олон нийтэд мэдээлсэн. Мөн нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй мэдээллийг Засгийн газрын shilen.gov.mn цахим хуудсан тогтмол байршуулж байна.	100%
59	126	Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай 2023-04-05 Дугаар 2023_119	2. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасгай.	Засгийн газрын 2024 оны 95 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн суурь хэмжээг 14,230,000 төгрөг байхаар тогтоосны дагуу 2024 оны аймгийн Засаг даргын А/309 дүгээр захирамжаар 2024 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах хугацаат цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 1997 онд төрсөн 244 иргэнээр төлүүлэх ажлыг зохион байгуулсан. 12 дугаар сарын байдлаар 73 иргэнээр нийт 94,038, 266 төгрөгийг 100060051416 төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан.	100%
	127		2.3. "Хот хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт;	"Нийгэм, эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэсэн төслүүдийг дэмжин Ханги мандлын суурьшлын бусад хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, төрийн үйлчилгээний нэгдсэн төв барих, мөн хүүхдийн цацарлэг, цахилгаан хангамжийн өргөтгөл, ундны усны эх үүсвэр, усан сан зэрэг төсөл, арга хэмжээний саналыг 2025 оны улсын төсөвт тусгуулахаар холбогдох цахим системд шивж сангийн яаманд хүргүүлсэн.	100%

60	128	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасуай.	"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны "Шинэ сэргэлт"-ийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт" хүрээнд боловсролын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шилдэг мэргэжилтнүүдийг аймагтаа урьж ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж буй "Ирээдүйн төлөв" хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын шаардлагыг ханган, 5 жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж 2 өрөө шинэ байр олгох болзолтойгоор баш нарыг сонгон шалгаруулж, шалгуурт нийцсэн англи хэлний 3 багшийг Сайншанд сумын сургуулиудад ажиллуулан 3 багшид тус бүр 2 өрөө байр олгож, амьжиргааны зардал 9,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Мөн Сайншанд сумын 2 дугаар сургуулийн Орос хэлний багшид 2 өрөө шинэ байрыг тусгай зориулалтын гэрээгээр олгосон. Дезерит олон улсын байгууллагатай хамтран 2 гадаад багшийг гэрээгээр ажиллуулж, амьдрах орон сууцаар хангасан. Орон нутагт чадварлаг боловсон хүчнийг татах, багшлах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор "Түрээсийн орон сууц" хөтөлбөрт сургуулийн 16, цэцэрлэгийн 15 багшийг хамруулж, амьдрах орон байраар хангаж нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Монгол Улсын 2025 оны төсөвт тусгуулахаар 217,3 тэрбум төгрөгийн 18 төсөл, арга хэмжээний саналыг pimis.publicinvestment.gov.mn цахим системийн төлөвлөгөөнд шивж илгээсэн.	100%
61	129	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасуай.	Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсвийн байгууллагуудын ажиллагсдын цалин хөлсийг энэхүү тогтоолоор шинэчлэн батлагдсан хэмжээгээр тооцон сум, байгууллагын 2024 оны төсөвт бүрэн тусгасан.	100%
62	130	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-07-05 Дугаар 2023_266	3. Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосуай	"Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд орон нутгийн төсвийн 450,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 9 дүгээр цэцэрлэгийн дотор засвар, гадна фасадын засварын ажил, 430,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар цэцэрлэгийн их засварын ажлын зураг төсвийг "Сант номун" ХХК хийж, Барилга хөгжлийн төвөөр дүгнэлт хийлгэж байна. Орон нутгийн төсвийн 190,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын 10 дугаар цэцэрлэгийн гадна дулаалгын фасад нэмэх, дотор их засвар хийх, сантехникийг бүрэн сольж сайжруулах ажил, ОНТ-ийн 515,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэгийн дотор засал, гадна фасадын засварын ажлын зураг төсвийг "Сант номун" ХХК тус тус гүйцэтгэж Барилга хөгжлийн төвөөр дүгнэлт хийлгэж байна. УТ-ийн 3.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 7 дугаар багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсвийг "Форус арт" ХХК гүйцэтгэсэн. ОНХС-ийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн их засварын ажлын зураг төсвийг "Лайн констракшин" ХХК гүйцэтгэсэн. Сайхандуулан суманд орон нутгийн хөгжлийн сангийн 76.9 сая төгрөгийн хөрөнгөөр нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах ажлын "Эгнэгт Өрнөх" ХХК гүйцэтгэхээр ажлаа эхлүүлсэн. Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар "Мөнхийн үргэлжлэл" ХХК сургууль, цэцэрлэг, дотуур байранд ариун цэврийн байгууламж шинээр хийж гүйцэтгэж байна.	70%
63	131	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланда тус тус үүрэг болгосуай. (1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Дорноговь аймагт хэрэгжүүлэх 17 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжүүлсэн 10 төсөл арга хэмжээний тендерийг цахимаар 100% зарласан байна. Тендер зохион байгуулж үнэлгээ хийж шалгаруулсан 21.9 тэрбум төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх нийт 65.5 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах 64 төсөл арга хэмжээнээс 60 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж 93.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Сумд болон агентлаг байгууллагууд руу 77 төсөл арга хэмжээний захиалагчийн эрхийг шилжүүлснээс 67 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж 98.5 хувийн гүйцэтгэлтэй байна.Гэрээний гүйцэтгэлийн тайланг үндэслэн 91 төсөл арга хэмжээнд 22.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. ОНХС нийт 128 төсөл арга хэмжээний тендер зарлагдаж тендер зохион байгуулалт 99%-ийн гүйцэтгэлтэй, ажил гүйцэтгэх 95 гэрээг байгуулж, гүйцэтгэлийн тайланг үндэслэн 21.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.	100%
64	132	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279	2.. 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорин цэврийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	"Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 279 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 03 дугаар албан даалгавар гарч, аймгийн аюулгүйн нөөцөд 600 тн өвс, 100 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 648,9 тн өвс 268,9 тн тэжээл бэлтгэж өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил 90,7 хувьтай хангасан. Аймгийн хэмжээнд 10 сумын нийт 647 өрхийн 469.0 мянган толгой мал өөрийн аймаг дотроо отроор өвөлжиж байна. Тус аймагт аймаг дундын отрын бус нутаг байхгүй хилийн зурваст 5 сумын 191 өрхийн 152 мянган толгой мал, улсын тусгай хамгаалалттай бус нутагт 5 сумын 110 өрхийн 76 мянган толгой мал, сум дундын отрын бус нутагт 1 сумын 3 өрхийн 2 мянган толгой мал, Өөр аймгийн нутагт 5 сумын 128 өрхийн 131 мянган толгой мал, өөрийн аймгийн бусад сумын нутагт 7 сумын 208 өрхийн 102 мянган толгой мал өвөлжсөн.	100%

65	133	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 2023_294	3. 3-Аймаг, сум, чөлөөт бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй, тусгагдсанаас өөр зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, сумын Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 136, 131, 74, дүгээр тогтоолоор батлагдсан эзэмшүүлж, ашиглуулахаар тусгагдсан байршилд шинээр газар олгох асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Мөн хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн төлөвлөлт хийгээгүй байршуудад газар олгохгүй байх тал дээр онцгой анхаарч ажиллах чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.	100%
66	134	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2023-08-23 Дугаар 2023_304	2. Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-ын 1.6 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 304 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөвлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/713 дугаар захирамжуудыг тус тус үндэслэн 2024-2026 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн "Дүйцүүлэх албаны бэлтгэл" шатны сургалт, 2023-2025 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн "Тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалтыг тус тус зохион байгууллаа. Сургалтыг Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байрлалд 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 27-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Сургалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоолын дагуу 14 сумаас 35 иргэнийг татан авч "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-ын дагуу зохион байгуулсан. Сургалтад хайрагдсан 35 иргэнийг хувцаасаар хангаж цэргийн алба зохион байгуулах зааврын дагуу цэргийн байранд байрлуулсан. Сургалтын төгсгөлд бие бүрэлдэхүүнд батламж гардуулан, иргэдийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгсөн.	100%
67	135	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312	4. Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоог нэмэгдүүлсэнтэй холбогдон гарах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан зохицуулж, цаашид жил бүрийн төсвийн төсөлдөө тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 орон тоо буюу Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн нэмэгдсэнтэй холбогдон цалин хөлстэй холбоотой болон үйл ажиллагааны зардлыг байгууллагын төсөвт бүрэн тусгасан.	100%
	136		5. Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/09, А/10 дугаар захирамжуудаар Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газрын бүтэц орон тоог тус тус шинэчлэн баталж, байгууллагуудад төсөв, өмч хөрөнгийг хуваарилан, удирдлагыг Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу томилон, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна	100%
68	137	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321	2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тогтоож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.	3. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд "Хүүхдийн аюулгүй байдал-Таны хариуцлагаас" 3 сарын аян, "Энэ жилдээ эрүүл жиндээ-2" аянг тус тус зарласан. Аяны хүрээнд иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэх, хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор хүүхдэд түгээмэл тохиолддог осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, амны хөндийн эрүүл мэнд, иргэдийн илүүдэл жин таргалалт, хөдөлгөөний хомсдолыг бууруулах, халдварт өвчнөөс сэргийлэх талаар 36 удаагийн цахим, танхим сургалтыг зохион байгуулж, 41 байгууллагын 1791 хүнийг хамруулсан. Орон нутгийн телевизтэй хамтран 11 удаагийн эмчийн зөвлөгөө, "Охид хөвгүүдийн цаг", "Зочны цаг" нэвтрүүлэг, цаг үеийн мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэж, цахимд 42 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлэг байршуулан, 52103 хандалт авсан. Албан байгууллагын ажилчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Байгууллагын эрүүл мэндийн ажилтан" бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 19 байгууллагын эрүүл мэндийн ажилтан бэлтгэн гэрчилгээ олгосон. Үүний үр дүнд албан байгууллагын хэмжээнд эрүүл мэндийн ажилтан дотоодын сургалтыг зохион байгуулж хэвшсэн. "Эрүүл монгол хүн" арга хэмжээний хүрээнд "Эрүүл орчин-Эрүүл хүүхэд", "Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх", "Орчиндоо мод тарих аян", "Харшилгүй монгол хүн" зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, 532 удаагийн сургалтаар 10234 хүн хамруулж, цахимд 128 төрлийн мэдээллийг байршуулан, олон нийтийг эрүүл амьдралын зөв дадалд уриалсан. "Нийгмийн эрүүл мэндийн-Эрх бүрт" зорилтыг 2024 онд дэвшүүлж, аймгийн хэмжээний хүрээнд 24 эрүүл мэндийн байгууллагын 296	100%

69	138	"Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322	2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	4.МУЗГ-ын санаачилгаар 2022 оны 05 сараас орон даяар эхэлсэн "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоо"-нд аймгийн хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар 5421 хүн, өссөн дүнгээр 34662 иргэн буюу 47.9%-ийг хамруулжээ. Үзлэгт 63.3% (21961)-ийг 0-17 насны хүүхэд, 36.7% (12714)-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна. Үзлэгээс хавдрын нийт 29 тайлант онд 7 тохиолдлыг илрүүлж, дээд шатлалд илгээж, оношийг батлуулан эмчилгээний асуудлыг шийдсэн. Эрт илрүүлгээс 631 өвчлөлийг шинээр илрүүлсний 425 нь хүүхдийн өвчлөл эзэлж, үүнээс 87.3% шүдний өвчлөл бүртгэгдсэн ба 283 хүүхдийг эмчилгээнд хамруулан эрүүлжүүлсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор 2024 онд 2 удаагийн аян зарлаж, үзлэгийн ач холбогдлыг сурталчлан, 67 удаагийн сургалт, сурталчилгаанд 3380 хүнийг хамруулан, 12 төрлийн 3066 ширхэг гарын авлагыг иргэдэд түгээж, 1121 хүнийг үзлэгт хамруулсан. ЭМС-ын 2024 оны А/150 дугаар тушаалын хүрээнд УНТЗ-ийн эмчээр удирдуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй явуулын баг Дорноговь аймагт 15 хоног ажиллаж, 13 сумын 1017 хүнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулснаас хавдрын сэжигтэй 6 тохиолдлыг илрүүлж, дээд шатлалын эмнэлэг рүү илгээсэн. Сүрьеэгийн эрт илрүүлэг, идэвхтэй тандалтыг халдварт ба халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 1376 хүн хамрагдаж, шинэ сүрьеэ бүртгэгдээгүй. Мөн ЭМГ-ын 2024 оны А/41 тушаалын дагуу Сайншанд сумын батлагдсан тохиолдол хавьтал, эрсдэлт бүлгийн 146 иргэнийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, 8 хүнээс цэрний сорьц авч одоогоор шинжилгээний хариу баталгаажиж гараагүй байна. 2024	100%
70	139	Журам батлах тухай 2023-09-13 Дугаар 2023_344	2.. 2. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан ОНТ-ийн 200.0 сая төгрөгөөр махны нөөц бэлтгэх тендэрт "Үзүүрт зараа" ХХК шалгарч үхэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн, нийт 100 тн махыг үйлдвэрийн аргаар бэлтгэн зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгийн хямд үнээр худалдаанд гаргасан. Нөөцийн махны борлуулалт, түгээлтийг өргөжүүлж Замын-Үүд сумын 2, Сайншанд сумын 11, нийт 13 хүнсний дэлгүүрт худалдан борлуулсан. Хүн амын 2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бэлтгэхэд ОНТ-т 200,0 сая төгрөгийг тусгасан ба аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендэрт "Суман зүхэй" ХХК шалгарсан.	100%
71	140	Улсын нөөцөөс бараа материал гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай 2023-12-13 Дугаар 2023_449	3.. 3. Улсын нөөцөөс олгох тэжээлийг оновчтой хуваарилах, зориулалтын бусаар зарцуулах, худалдаалахаас урьдчилан сэргийлж, хяналт тавих, гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт 2024 оны I улиралд багтаан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан цас, зуд гамшигийн нөхцөл байдлыг даван туулахад Монгол улсын Засгийн газрын 2023 оны 449, 479 дүгээр тогтоолоор 130 тонн малын тэжээлийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын 2024 оны А/264 дүгээр захирамжаар баталсан хуваариар Монгол улсын Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоолын дагуу улсын нөөцөөс үнэ төлбөргүй олгох 100тн өвс, 70тн тэжээлийг аймгийн Засаг даргын 2024 оны А/276 захирамжаар баталж хуваарийн дагуу сумдад олгосон. Гүйцэтгэлийн тайланг холбогдох баримтын хамт Онцгой байдлын газрын даргын 2024 оны 25/45 дугаар алан бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.	100%
72	141	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-13 Дугаар 2023_456	1.2.. 1.2. улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр гэрээ нь хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, санхүүжилт бүрэн авах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байошүүлэх.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийгдэж дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 7,1 тэрбум төгрөгийг Засгийн газрын 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 456 тоот тогтоолыг үндэслэн барьцаа хөрөнгийг дансанд байршуулсан.	100%
	142		1.3.. 1.3. төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 7,1 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас Засгийн тогтоолд заасны дагуу гүйцэтгэлийн тайланг үндэслэн санхүүжилтийг олгох тухай гүйцэтгэгч компаниудад үүрэг чиглэл өгсөн. 4 дүгээр сард барьцаа хөрөнгийн данснаас Саранхөхөө театрын барилгын ажлын гүйцэтгэгч "Болор аграмба" ХХК-д гүйцэтгэлийн тайланг үндэслэн 696,6 сая төгрөгийн, Замын-Үүд сумын 640 хүүхдийн сургуулийн барилга барих ажлын гүйцэтгэгч "Билгүүн монгол констракшн" ХХК-ний тайланг үндэслэн 677.8 сая төгрөгийн, Замын - Үүд суманд 500 хүний суудалтай Соёл урлагийн ордоны барилгын гүйцэтгэгч "РСТ" ХХК-д 868.4 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.	100%
73	143	Аргачлал шинэчлэн батлах тухай (Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал) 2023-12-20 Дугаар 2023_457	2. Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2024 оны төсвийн жилээс эхлэн энэ тогтоолын 1-д заасан аргачлалын дагуу тооцон хуваарилж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг 2025 онд тухайн тогтоолын дагуу тооцон ажиллах төлөвлөгөөтэй байна.	70%

74	144	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_458	2. Төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.(Өвлийн аялал жуулчлалын 2024 оны төлөвлөгөө) Төлөвлөгөө батлагдсанаас хойш хэрэгжилтийг тайлагнах	Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдтэй 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдөр уулзалт зохион байгуулан, тус газарт дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангах, хог хаягдлын талаар, татвар төлөгчийг бүртгүүлж, хуулийн дагуу татвар төлөх, "Хамтран ажиллах гэрээ"-ний төслийг танилцуулж, өнөөдрийн байдлаар Энэргийн төвд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа 6 иргэн, Ханбаянзүрх хайрханд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа 6 иргэн, гэр буудлын үйлчилгээ эрхлэгч 11 иргэн, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэгч 2 аж ахуйн нэгж, хоол үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн буюу нийт худалдаа үйлчилгээ эрхлэгч 34 иргэн, 2 аж ахуйн нэгжтэй 1 жилийн хугацаанд "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулсан. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны төлөөлөгчид хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх уулзалт зөвлөгөөнийг 05 дугаар сарын 28-ны өдөр Замын-Үүд суманд аялал жуулчлалын бизнес эрхлэгч, Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбооны гишүүдтэй уулзалт хийж, аялал жуулчлалын мэргэжлийн салбар холбоогүй байгуулах ажлыг зохион байгуулж, хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хоёр улсын жуулчдыг аялуулах хүлээн авах талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. БНХАУ-ын жуулчдыг хүлээн авах талаар 2 тал нэгдсэн шийдвэрт хүрсэн нь Дорноговь аймгийг зорин ирэх гадаадын жуулчдын тоо, түүнийг дагасан эдийн засаг нэмэгдэх боломжтой юм. Тайлант оны байдлаар "Хамарын хийд", "Ханбаян зүрх хайрхан уул"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоод 88400 гадаадын 1661 "Их нарт"-ын тусгай хамгаалалттай газарт 146	100%
75	145	Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461	4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	2024-оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр махны нөөц бэлтгэх төндөрт Сайншанд сумын 5 дугаарт багт үйл ажиллагаа явуулдаг "Үзүүрт зараа" ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд үхэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн, нийт 100 тн махны нөөцийг бүрдүүлэн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ныг хүртлэх хугацаанд зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгийн хямд үнээр худалдаанд гаргаж дууссан. Нөөцийн махны борлуулалт, түгээлтийг өргөжүүлж Замын-Үүд сумын 2, Сайншанд сумын 11, нийт 13 хүнсний дэлгүүрт худалдан борлуулсан. Нөөцийн мах худалдаж эхэлсэн хугацаанаас эхлэн 14 хоног тутам мэдээлэх зарцуулалтын явцын мэдээг гаргаж, махны нийлүүлэлт, худалдалах үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж, арга зүйгээр ханган ажилласан. Орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 тн нөөцийн мах бэлтгэх тухайн үеийн зах зээлийн үнээс 2000-4000 төгрөгийн хямд үнээр 2025 оны хавар, зуны улиралд төв суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх махны төндөрт "Суман зурхай" ХХК шалгарч, гэрээ байгуулсан байна.	100%
76	146	2024 оныг "Бусчилсан хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай 2023-12-27 Дугаар 2023_481	4. Монгол Улсын бусчилсан хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлагад даалгаж, нутгийн өөрөө удирдах байгууллага, улс төрийн нам, эвсэл, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад уриалсугай.	2024 оны 2 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Монголын Эдийн засгийн форум бусчилсан хөгжил" говийн бүсийн урьдчилсан хэлэлцүүлэгт аймгийн төрийн албан хаагч болон хувийн хэвшил, иргэдийн төлөөллийн нийт 60 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Хэлэлцүүлэгт говийн бүсийн аймгийн удирдах албан тушаалтнууд оролцож, хөгжлийн давуу болон сул тал, тулгамдаж буй асуудлууд мөн цаашдын хөгжлийн талаар хэлэлцэж бусчилсан хөгжлийн үзэл баримтлалын төслийг нэгтгэн боловсруулсан. 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган шинэ стандарт" сэдэвт сургалтад Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Сайншанд, Замын-Үүд, Айраг, Хатанбулаг сумдын Засаг дарга, Хилийн боомтын захиргаа, АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, холбогдох албан тушаалтнууд оролцсон. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бусчилсан хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Шинэ хоршоо" хөдөлгөөний говийн бүсийн уулзалт, хэлэлцүүлэг, "Дулаахан" говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулган, "Үсчин гоо сайханчдын говийн болон зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн" зэрэг томоохон арга хэмжээг зохион байгуулж нийт бүсийн аймгуудын 700 гаруй төлөөллийг оролцуулсан.	100%
	147		2.8. Иргэд орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бүс нутгийг тодорхойлж, шаардлагатай газрыг чөлөөлж, олгох арга хэмжээ авч ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймгийн Засаг дарга нарт;	Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшнийг бүтээж нэг дороос мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Орон нутагт шилжин, тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор Түрэсийн орон сууц хөтөлбөрийг Замын-Үүд болон Сайншанд сумдад хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр төсөл арга хэмжээ амжилттай хэрэгжсэнээр 174 айл өрх түрэсийн орон сууцанд хамрагдаж мэргэжилтэй боловсон хүчнийг урьж ажиллуулах боломж бүрдэх юм. "Хот хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд орон нутгийн төсвийн 150.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 1, 2, 3, 4, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт 332 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг "Инженер геодези" ХХК гүйцэтгэсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын газрыг дахин зохион байгуулж, төвлөрсөн инженерийн хангамжид холбогдсон "Тохилог орон сууц" амины орон сууцны хорооллыг төлөвлөсөн.	100%

77	148	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-27 Дугаар 2023_483	2.9.. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдийг амьдрах тав тухтай орчныг бий болгох зорилгоор цаашид хот суурин болж хөгжих боломжтой сумдад орон сууц барих талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Аймгийн хэмжээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлогын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих орон сууцны төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байна. Энэ онд Сайншанд сумын 7 дугаар багт УБТЗ ХНН-тэй хамтран "Говийн төмөр замчин" орон сууцны төсөл, Сайншанд, Замын-Үүд сумдад "Түрээсийн орон сууц хөтөлбөр" зэрэг олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. УБТЗ ХНН-ээс тус төслийг хэрэгжүүлэхээр барилгын зурга төслийг орон нутагтай зөвшилцөж боловсруулалтын ажил дуусах шаттай авж байгаа бөгөөд энэ онд багтаан эмнэлгийн хуучин барилгыг буулгах ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100%
	149		2.10.. Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн болон аймгийн Засаг дарга нарт, шаардагдах санхүүжилтийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан судлан шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд;	Нийгмийн суурь үйлчилгээ болох эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 5 жилийн гэрээгээр 10 багш, 10 эмч, нийт 20 нарийн мэргэжлийн боловсон хүчнийг ажиллуулахаар төлөвлөснөөс боловсролын салбарт 5 багш, удирдах ажилтан, эрүүл мэндийн салбарт 8 эмч, тоног төхөөрөмжийн инженер нийт 13 боловсон хүчнийг урилгаар ажиллуулж, үнэ төлбөргүй орон сууцдаар хангасан. Мөн түрээсийн орон сууц хөтөлбөрийн 1 дүгээр ээлжинд 105 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд, журмын дагуу олгосноос ХБИ-7, ахмад-11, Өрх толгойлсон эх, эцэг-2, Олон хүүхэдтэй гэр бүл-6, Залуу гэр бүл-10, эмч, сувилагч, асрагч-14, сургуулийн багш-16, цэцэрлэгийн багш-15, малчин-17 байна. Үүнээс 45 төрийн албан хаагч түрээсийн орон сууцанд хамрагдаж, аятай тухтай ажиллаж, амьдрах боломжтой болсон. Мөн аймгийн ИТХ-ын 2023 оны 12/02 дугаар тогтоолоор баталсан "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцанд хамруулах журам"-ын дагуу төрийн албан хаагч, ахмад настан, залуу гэр бүлийн 32 айл, өрхөд түрээслээд өмчлөх орон сууцны батламжийг гардуулсан.	100%
78	150	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасгай.(1."Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	"Нээлттэй Дорноговь аймаг", "Түншлэл-хөгжил 2024" зорилтот жилийн хүрээнд "Bridge to Dornogobi" олон улсын боловсролын үзэсгэлэн, Говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтийг орон нутагтаа зохион байгууллаа. "Bridge to Dornogobi" олон улсын боловсролын үзэсгэлэнд 2400 гаруй суралцагч, оюутан, залуучууд, эцэг эхчүүд, төрийн албан хаагчдыг хамруулан, дэлхийн 11 улс, орны 17 их дээд, сургуулиудын сургалтын хөтөлбөр, оюутан элсүүлэх журам, тэтгэлэгт хөтөлбөрүүд, боловсролын өнөөгийн тогтолцоо, цаашдын хөгжил, суралцах боломж зэрэг сонирхсон бүхий л чиглэлийн мэдээ, мэдээллийг хүргэсэн.Орон нутагт эмэгтэйчүүдийн оролцоог бэхжүүлэх, түүнчлэн эмэгтэйчүүдийн манлайлал болон гэр бүлд чиглэсэн соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг хүргэх зорилгоор, Говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулж Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн 600 гаруй эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцууллаа. Үндэсний өв соёлоо дээдлэн уламжилж, үр хойчдоо өвлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, "GO MONGOLIA" аяны хүрээнд "Монгол гэр" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд орон нутгаа төлөөлөн оролцож гадаад, дотоодын 5000 гаруй иргэд, зочдод говь нутгийн онцлог, халх угсаатны соёл, уламжлалыг таниулан, сурталчилж ажилласан. Фестивальд 23,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн өвлөн уламжлагчдын урамшуулал, тээврийн хэрэгсэл, шатахууны зардалд зарцуулсан. Тайлант хугацаанд 4 фестиваль, арга хэмжээг зохион байгуулж, 7000 гаруй иргэд, олон нийтийг хамруулан 223,0 сая төгрөг зарцуулсан.	100%
79	151	Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59	6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасгай. (5."Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ"-г хавсралт ёсоор баталсугай.)	"Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны "Морин хуурыг эрхэмлэн дээдлэх, түгээн дэлгэрүүлэх" тухай зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Сайншанд сумын Ерөнхий боловсролын V дугаар сургуулийн "Болор эшиглэн" хамтлагийн 10 жилийн ойн тоглолтод орон нутгаас 6,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Болор эшиглэн" хамтлаг нь 10 жилийн хугацаанд үндэсний хөгжмөөр 60 сурачийг сурган, үндэсний урлагийг хөгжүүлж, түгээн дэлгэрүүлсэн. Ойн тоглолтыг 4 удаа зохион байгуулж, 1400 гаруй үзэгчдийн хүртээл болгосон. Мөн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Өмнөговь аймгийн "Эгшиглэн хуур" морин хуурчдын улсын уралдаанд "Болор эшиглэн" хамтлаг оролцож тэргүүн байр эзэлсэн. Орон нутгаас тэмцээнд оролцоход 2,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Саран хөхөө театр хүүхэд багачууд, өсвөр үеийнхэнд монгол үндэсний хөгжмийг таниулан сурталчлах, театрын хүний нөөцийг бүрдүүлэх, авьяаслаг хөгжимчдийг тодруулах зорилгоор "Авьаслаг хөгжимчид" үндэсний хөгжийн анхдугаар уралдааныг 6 сумын 150 гаруй суралцагчдыг оролцуулан зохион байгуулж 350 гаруй хүн үзсэн. Уг уралдаанд 4,0 сая төгрөг зарцуулсан. "Соёлын өдөр" аяны хүрээнд "Монголын үндэсний язгуур урлагаас суралцагч" сургалт, бий биелгээ язгуур урлагийн төрлөөр нийт 60 гаруй суралцагчдад хүргэснээс гадна аймгийн хэмжээнд морин хуурын 10 дугуйланд нийт 145 хүүхэд хамрагдлаа. Дэлгэрэх сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан 100 морин хуурчид сурган, баяр наадмын хүндэтгэлийн тоглолт зохион байгуулсан. Тайлант онд морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 2 тэмцээнд дэмжлэг үзүүлэн, 145 хүүхэд морин	100%

152		<p>2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.</p> <p>(1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндэргийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.)</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг"-т шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны "Шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/278 дугаар захирамжаар Штабын бүрэлдэхүүнийг томилж, 24 цагийн ажлын горимд шилжүүлсэн. Аймгийн хэмжээнд үүссэн нөхцөл байдлын мэдээллийг Улсын Онцгой комиссын Шуурхай штабт дамжуулах, зудын гамшгийг хохирол багатай даван туулах, үүсч болохгүй шар усны үерийн үед мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Шуурхай штабын жижүүрээр нийт 613 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн тайлант хугацаанд аймгийн Онцгой комиссын хуралдааныг 7, Шуурхай штабын хуралдааныг 9, сумдтай цахимаар 6 удаа, УОК-ын хуралд цахимаар 5 удаа оролцсон. Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллаж, шаардлагатай тусламж дэмжлэгийг 23670 айл өрхөд нийт 895.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ажил, арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Төрийн тусгай чиг үүргийн байгууллагын 102 алба хаагч, 32 нэгж техник хэрэгсэл /Онцгой байдлын 30 алба хаагч, 15 техник, Зэвсэгт хүчний 336-р ангиас 44 албан хаагч, 7 техник, Хил хамгаалах 0168, 0129 ангиас 16 алба хаагч, 6 техник, Цагдаагийн газраас 10 алба хаагч, 3 техник/-тэйгээр, төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 865 алба хаагч, 128 нэгж техниктэй дайчлагдсан ажилласан. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж, үүрэг гүйцэтгэх цагийг 04 дүгээр сараас өдрийн 8 цаг болгон хуваарьт</p>	100%
153	80	<p>Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_62</p>	<p>3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:</p> <p>3.1.Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндэргийг хохирол багатай даван туулах зорилгоор "Малчдадаа тусалъя аян"-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	100%
154		<p>3.3. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болохгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт;</p>	<p>Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Төрийн тусгай чиг үүргийн байгууллагын 102 алба хаагч, 32 нэгж техник хэрэгсэлтэйгээр, төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 865 алба хаагч, 128 нэгж техниктэй өвөлжилт, хаваржилт хүндэрсэн 4 сумын 350 өрхийн 10063км зам харгүй мөн сумын Онцгой комиссоос 3 сумын 92 өрхийн 1728 км зам харгүй гаргаж өвс тэжээл, хүнсний болон эмийн багц хүргэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн Онцгой байдлын байгууллагаас 32 алба хаагч, 16 техник хэрэгсэлтэйгээр, Зэвсэгт хүчний анги байгууллагаас 44 алба хаагч, 7 техник хэрэгсэлтэйгээр, Цагдаагийн байгууллагаас 10 алба хаагч, 3 нэгж техниктэйгээр, Хилийн цэргийн анги, байгууллагаас 16 алба хаагч, 6 нэгж техниктэйгээр ажиллаж 669 өрх айлд 76 тн өвс, 2 тн тэжээл, 3 тн нүүрс хүргэх ажлыг зохион байгуулж, цасан шуурганы улмаас төөрсөн сураггүй болсон, орон нутгийн замд тээврийн хэрэгсэлтэй зорчих цасанд суусан 68 иргэний амь насыг аварна хамгаалсан.</p>	100%
155		<p>3.8. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт.</p>	<p>Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд өвөлжилт хүндэрсэн сумдад ажиллаж шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлэн удирдлага зохион байгуулалт, арга зүйгээр ханган ажилласан. Зохион байгуулалтын хүрээнд нийт 6 сумын 13 багийн 354 өрхөд хүрэх 11841 км зам гаргаж, бүх сумын 23917 өрхөд дэмжлэг үзүүлсэн. Дэмжлэгийг нарийвчлан авч үзвэл. Үүнд: 1. Түлээ, нүүрс - 1532 өрхөд 4437 шуудай; 2. Тэжээл - 8022 өрхөд 17998 шуудай; 3. Өвс - 10674 өрхөд 78291 боодол; 4. Шатахуун - 1267 өрхөд 34023 литр; 5. Хүнсний багц - 2422 өрхөд 3019 ширхэг 6. Эмийн багц - 919 ширхэг болно. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр хаваржилт хүндэрсэн сумдад 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 2725 шуудай хорголжин тэжээл, 73539 боодол өвс худалдан авахад нийт 1,3 тэрбум төгрөгийг гамшгаас хамгаалах зардлаас шийдвэрлэсэн, 7000 шуудай улаан буудайнаас Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдад 3500 шуудайг өнөөдрийн байдлаар хүргүүлээд байна. Сумын онцгой комиссоос зам гарц гаргах, тэжээл, өвс, шатахууны зардалд нийт 927,7 сая төгрөг зарцуулаад байна. Аймаг, сумдад иргэд, аж ахуйн нэгжүүдээс мөнгөн хандив 460.9 сая төгрөг, тэжээл 7581 шуудай, өвс 3226 боодол, 34.0 сая төгрөгийн хүнсний материал, 25.5 сая төгрөгийн шатахууны тусламжийг үзүүлсэн байна.</p>	100%

81	156	Өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2024-02-28 Дугаар 2024_76	2.. Тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авах тэжээлийн буудай болон малын тэжээлийн үнэ, татан авах зардлын тооцоо, аймгуудад олгох хуваарийг гаргаж, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Хөдөө аж ахуйн тариалан эрхлэгч корпораци"-аас 350 тн улаан буудай, 100 тн овьёосыг татан авчрах зардалд 76.230.000 төгрөг, мөн 350 тн улаан буудайг татан авчрах зардалд 64.709.400 төгрөг, "Баялаг фийт" ХХК-аас 120 тн, 92 сая төгрөгөөр бүрэн найрлагат тэжээлийг тус тус татан авч малчдад хуваарилан олгосон.	100%
82	157	Журам батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	3. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам)	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийг 93,7%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын ХШУ системд сар бүр тайлагнаж баталгаажуулсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн болон боловсруулж буй хуулийн төслийн мэдээллийг бэлтгэж төрийн албан хаагч, иргэд, олон нийтэд танхим болон цахим хэлбэрээр сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2024 оны байдлаар 8 удаагийн арга хэмжээгээр 20 гаруй хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 89,000 гаруй иргэд болон төрийн албан хаагчдыг хамруулсан байна. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд иргэдийн эрх зүйн боловсрол дээшилж, өөрт хэрэгцээ шаардлагатай хууль тогтоомжийг судлах, эрхээ хамгаалуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.	100%
83	158	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1."Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн ИТХ-ын "Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 15/08 дугаар тогтоолын дагуу орон нутгийн төсвийн байгууллагуудын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 60 хувиар олгосон. Мөн аймгийн Засаг даргын 2024 оны А/380 захирамжаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 20 хувиар олгох шийдвэр гарган 2024 оны 04 дүгээр 01-нээс олгосон.	100%
84	159	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1."Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.)	Төрийн захиргааны албан тушаалд 5 жил тасралтгүй ажилласан төрийн захиргааны албан хаагчид 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгох зардлыг 2024 оны төсөвт 657,3 сая төгрөг тусгасан."Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын шаардлага, болзолыг хангаж буй албан хаагчдын судалгааг гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 19 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн төсөвт тодотгол хийж нийт 139 төрийн захиргааны албан хаагчид 572,0 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг аймгийн Засаг даргын 2024 оны Б/39 лүгээр захирамжаар олгосон.	100%
85	160	Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай 2024-03-06 Дугаар 2024_89	2. Тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааг тухайн жилд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарт багтаан, холбогдох хуульд нийцүүлэн зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	Иргэний хууль, Амьтны тухай хууль, Аялал жуулчлалын тухай хуулийг үндэслэн аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн "Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох хаалттай дуудлага худалдаа зохион байгуулах тухай" А/517 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 07 дугаар сарын 09-ний өдөр хаалттай дуудлага худалдааг цахимаар амжилттай зохион байгуулж аймгийн Засаг даргын 2024 оны "Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах гэрээ байгуулах, эрх олгох тухай" А/565 дугаар захирамжийн дагуу Эрдэнэ суманд 2, Өргөн суманд 2, Хатанбулаг суманд 2, Мандах суманд 1 нийт 7 агууламж тусгай зориулалтаар агнах эрхийг дуудлага худалдааны ялагч "Монгол сафарит" ХХК, "Монгол тур" ХХК, "Маунтэйн хантинг" ХХК-уудад зөвшөөрөл олгосон. Дээрх компаниуд нь тусгай зориулалтын агнуурын ажлыг зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2024 оны 350 дугаар тогтоол, Соёлын зориулалтаар идлэг шонхор шувуу бариулах" гэрээг үндэслэн аймгийн 20 ширхэг зөвшөөрлийг Катар улс, Арабын нэгдсэн эмират улс, Саудын араб улсын төлөөлөгч нарт олгож гадаадын иргэд тус аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрээс 19 бодгаль шонхор шувуу барих ажлыг зохион байгуулснаар 417.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.	100%
86	161	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136	2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. (“Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 2 дугаар хавсралт, “Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг 3 дугаар хавсралт)	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд нийт 486 нэгж талбар буюу 967.32 га газрыг иргэн, хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахаар тусгагдсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар тухайн шатны Засаг даргын шийдвэрээр аймгийн хэмжээнд 43 нэгж талбарын 523.7 га газрыг иргэн, хуулийн этгээдэд олгож, шийдвэрийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэсэн. Мөн Газрын биржийн цахим системээр 12 байршилд газрыг дуудлага худалдааны журмаар олгохоор зарыг олон нийтэд мэдээлсэн.	100%
87	162	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих зориулалтаар улсын хилийн зурваст газар ашиглуулах тухай 2024-04-10 Дугаар 2024_150	4.. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулахын төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын зурваст нэвтрэх, газар ашиглах болон холбогдох бусад зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасуран), Сүхбаатар, Дорноговь аймгийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулахын төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын зурваст нэвтрэх, газар ашиглах талаар зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж байхгүй болно.	100%

88	163	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалт байхгүй. Ерөнхий гэрээгээр бараа ажил үйлчилгээ нийлүүлэх болон худалдан авах аж ахуйн нэгжийн хүсэлт ирээгүй байна.	100%
89	164	"Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166	3.. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий ан холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.	"Шинэ хоршоо" хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/404 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын орлогч даргаар ахлуулсан 20 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, 14 сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан "Дэд ажлын хэсэг"-ийг сум тус бүрд байгуулж, шаардлагатай техник хэрэгслээр хангаж, мэдээллийн цэгийг байгуулан ажиллуулсан. Дээрх мэдээллийн цэг болон зөвлөн туслах багийн гишүүд малчид, иргэдэд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангах боломжийн талаарх зөвлөгөө, мэдээлэл өгч, нийт малчин өрхийн 70.3 хувь буюу 3248 өрх, нийт малчдын 83.09 хувь буюу 5881 малчин, бусад 2576 иргэнийг хамруулсан. Дорноговь аймагт шинээр байгуулагдсан 185 хоршооны 83 хувь нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах, бизнес төсөл, төлөвлөгөө хэрэгжүүлэхээр болсон байна.	100%
90	165	Журам шинэчлэн батлах тухай 2024-04-24 Дугаар 2024_168	1.. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай	Дорноговь аймаг үнэт цаас гаргаагүй болно.	100%
91	166	Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-04-24 Дугаар 2024_173	1.. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай	Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулан булшлах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамж, 1 төлөвлөгөө, Мал эмнэлгийн газрын даргын 1 тушаал, 6 удаагийн албан бичгийг сумдад хүргүүлж, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаасан. Сэг зэмийн устгалын ажлыг 2024 оны 03 дугаар сарын байдлаар 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл 2 сарын аяныг өрнүүлэн зохион байгуулж, нийт 580004 толгой мал хорогдсоноос 501796 толгой малын сэг зэмийг цуглуулж устгаж гүйцэтгэл 86.5 хувьтай байгаа нь өөр аймаг, сум руу уруудсан, отрын бэлчээрт хорогдсон малтай холбоотой. Дээрх ажлыг устгалын 119 цэгт 510 хүн 208 тээврийн хэрэгсэлтэй дайчлагдан ажиллаж нийт 175.3 мянган м2 талбайд халдваргүйтгэлийг хийсэн. Устгалын 119 цэгт 510 хүн, 208 тээврийн хэрэгслийг дайчлан ажиллуулсан. Хатанбулаг, Хөвсгөл сумдад гарсан малын гоц халдварт ямааны годрон өвчний хорио цээрийн даглэмийн хугацаанд 93 малчин өрхийн 14639 толгой ямааг зориудаар нядалж устган голомтын бүсийн 39 малчин өрхийн малын хашаа хороо, хэвтэр бууц, устгалын цэг бүхий 30250 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн. Устгалын 3 цэгт 207 хүн 45 тээврийн хэрэгслийг дайчлан ажиллуулсан. Нийт дээрх арга хэмжээнд 192.6 сая төгрөг зарцуулсан.	100%
	167		2.. Малын сэг зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний зардлыг орон нутгийн төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, иргэд, малчидтай орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээр дамжуулан байгуулах гэрээт ажлын хэсгийг Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас зохих журмын дагуу гаргахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад тус тус даалгасугай	2024 онд халдваргүйтгэлийн арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 59.5 сая төгрөг зарцуулан 350.0 м2 талбайг хамруулахаар төлөвлөсөн. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор гоц халдварт өвчин гарсан 14 сумын голомт, сэжигтэй бүсийн давхардсан тоогоор өрхийн 190 хашаа хороо, худаг уст цэгийн нийт нийт 220.0 мянган м2 талбайг хамруулж, өвчний гаралт тархалтыг таслан зогсоосон. Аймгийн хэмжээнд малын хашаа, хороо, хэвтэр бууц, малын тоног хэрэгсэл, худаг уст цэг бүхий 130765 м2 талбай, зүй бусаар хорогдсон мал, амьтны устгалын цэг орчмын 175301 м2 талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Сайншанд сумын 6 дугаар багтай хамтран орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, орон сууц, сургууль цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбай, асфальтан хучилттай авто зам, нийтийн эзэмшлийн талбай зэрэг нийт 139,7 м2 талбайд халдваргүйтгэлийг Дук автомашинаар гүйцэтгэсэн. Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Эрүүл мэндийн газартай хамтран борооны усанд автсан Сайншанд сумын 60, 70 айлын орон сууцны подвол, ойр орчмын хүүхдийн талбай, байрны ойр орчмын хүүхдийн талбай бүхий 2000 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн. Нийт 667,7 м2 талбайд халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад 169.8 сая төгрөгийн шатахуун, 12.1 сая төгрөгийн халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгаалалын хэрэгсэл, нийт 181.9 сая төгрөгийг зарцуулж, хөрсний бохирдлоос сэргийлсэн.	100%
92	168	Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187	4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд шинээр 185 хоршоо байгуулагдаж, Алтанширээ, Замын-Үүд, Өргөн, Хатанбулаг зэрэг сумд нийт 10 хоршоонд 45 га газрыг олгосон.	100%
93	169	Ариун цэврийн байгуулам бүхий түр буудаллах цаг, үйлчилгээний үйлдвэрлэл барьж байгуулах тухай	2.. Энэ тогтоолын хавсралтад заасан байршилд эзэмшүүлэх газрыг аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу эзэмшүүлэх ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), аймаг, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн олон улсын чанартай авто зам дагуу байрлах нийтийн цэгт хуримтлагдсан хог хаягдлыг харьяа сум, Дорноговь "А33А" ТӨХК ХХК, давхардсан тоогоор 6 газрыг сард 22 удаа цэвэрлэх ажлыг зохион байгуулж байгаль орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авсан. Эрдэнэ сумын 100 зогсоолд 1 иргэн гэрээгээр иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд орчны хог цэвэрлэгээ болон ариун цэврийн байгууламжийг цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мөн зам дагуу ажиллаж буй шатахуун түгээх газрууд иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.	100%

	170	2024-05-01 Дугаар 2024_189	4.. Олон улс, улсын чанартай авто зам дагуу ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэгийн цэвэрлэгээ, арчлалт, хог хаягдлын асуудлыг зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн олон улсын чанартай авто зам дагуу байрлах нийтийн цэгт хуримтлагдсан хог хаягдлыг харьяа сум, Дорноговь АЗЗА ТӨХК ХХК, давхардсан тоогоор 6 газрыг сард 22 удаа цэвэрлэх ажлыг зохион байгуулж байгаль орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авсан. Эрдэнэ сумын 100 зогсоолд 1 иргэн гэрээгээр иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд орчны хог цэвэрлэгээ болон ариун цэврийн байгууламжийг цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мөн зам дагуу ажиллаж буй шатахуун түгээх газрууд иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.	100%
94	171	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	"Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг улсын хэмжээнд нэвтрүүлж байгатай холбогдуулан сумдын болон агентлаг байгууллагын 25 хүний нөөц хариуцсан албан хаагчдыг чадавжуулах цахим сургалтад хамруулсан бөгөөд тус систем нь 2024 оны 05 дугаар сард нээлтээ хийсэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн албаны ил тод, хүртээмжтэй байдал, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хөгжүүлж буй "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийн нээлттэй 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус системийн хэрэглээ, ач холбогдлыг таниулах, санал авах цахим сургалтад сумдын болон агентлаг, байгууллагын хүний нөөц хариуцсан албан хаагчдыг хамруулсан.	100%
95	172	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 177 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэсэн нь 98 хувьд нэвтрүүлсэн байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 540 албан хаагчийг хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн дагуу албан бичиг солилцооны дундын систем "DOCX"-ийг ашиглан цахим хэлбэрээр баримт бичиг солилцож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллах чиглэлийн дагуу ERP систем нэвтэрсэн бүх байгууллагуудыг тус системд холбож ажилласан.	100%
96	173	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай 2024-07-24 Дугаар 2024_10	2.. Энэ тогтоолоор баталсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Аймгийн 2025 оны орон нутгийн төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга зүйг ашиглан өмнө оны төсвийн гүйцэтгэл, сум, байгууллагаас ирүүлсэн төсвийн санал, 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бологын зорилтуудад тулгуурлан Төсвийн ерөнхийлөн захирагчид хуваарилсан төсвийн хязгаарыг харгалзан Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд Сангийн яаманд хүргүүлэн хянуулсан.	100%
	174		3.1.. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	"Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын дагуу хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн үйлтэй, хөнгөлөлттэй зээлд газар тариалан, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдаж, нийт 188,0 сая төгрөгийн санхүүжилт авч, тариалсан талбайн хэмжээг 40 га-аар нэмэгдсэн. "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан"-гаас хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 аж ахуйн нэгж 556,3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, үйлдвэрлэлийн хүчин чадал, цар хүрээг өргөжүүлсэн. Алтанширээ, Хөвсгөл сумдын "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас 2 хоршоонд махны үйлдвэрлэлийн чиглэлээр 160,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд хүнсний үйлдвэрлэл, мах, сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр 67 хоршоонд нийт 7,8 тэрбум төгрөгийн зээл олгож дэмжлэг үзүүлсэн. "Цагаан сүүний буян" ХХК, "Хашаатын говийн заг" ХХК 50,0 сая, "Сүүн дэлгэрэх шанд" ХХК-д нийт 345,0 сая төгрөг, "Түншлэл ба хөгжил" аймгийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд "Өгөөж эрдэнэ дэлгэрэх" ХХК-д 150,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлээ өргөжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлж, сав баглаа боодлоо шинэчлэх, малын хашаагаа засварлахад зарцуулсан байна.	100%
	175		3.2.. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорю цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 03 дугаар албан даалгавар гарч, аймгийн аюулгүйн нөөцөд 420 тн өвс, 344 тн тэжээл, сумдын аюулгүйн нөөцөд 682,8 тн өвс, 374,4 тн үйлдвэрийн тэжээл, бэлтгэж хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг 90.5 хувьтай хангасан.	100%

97	176	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28	3.3.. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;	Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу бэлчээрийн төлөв байдлын, ургаа тодорхойлох ажлыг Дорноговь аймгийн 14 сумын 54 багийн 72 бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын цэгүүдэд хийж аймгийн хэмжээнд 2024-2025 онд 1.592.070 мянган толгой мал өвөлжих төлөвтэй байгаа бөгөөд бэлчээрийн ургаа 0.4 – 11.6 ц/га байгаа бөгөөд нийт нутгийн 85 хувь нь зуншлага сайн, 15 орчим хувьд зуншлага хэвийн байна. Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нутгийн: 84.5% - Бэлчээрийн нөөцтэй 14.2% - Бэлчээр хүрэлцээтэй 1.2% - Даац 1-3 дахин хэтэрсэн 0.1% - Даац 3-5 дахин хэтэрсэн өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 98.7 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 1.3 орчим хувьд хэтэрч гарсан. Сумдын 2024-2025 оны өвөл, хаврын отор нүүдэл хийх саналыг авч холбогдох газрууд нь хүргүүлж, отор нүүдлийн зуралгал гаргасан. Хилийн зурваст 5 сумын 164 өрхийн 76 мянган толгой мал, улсын тусгай хамгаалалттай бус нутагт 3 сумын 119 өрхийн 61 мянган толгой мал нийт 6 сумын 283 өрхийн 137 мянган толгой мал өвөлжиж хаваржуулахаар сумдын засаг дарга, хилийн цэргийн удирдлагуудад албан хүсэлт хүргүүлсэн.	100%
	177		3.4.. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	Аймгийн хэмжээнд нийт 185 хоршоо шинээр байгуулагдаж, 15.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Шинээр байгуулагдсан хоршоодын 98 хоршоо нь мал аж ахуйн салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Дээрх хоршоодоос малын тэжээлийн ургамал тариалах, мах бэлтгэн төв суурин газарт нийлүүлэх, бэлчээр хамгаалах чиглэлээр байгуулагдсан 48 хоршоотой хамтран ажиллах, төрийн худалдан авалтаар дэмжин ажиллах санал, төрийн худалдан авалтаар дэмжин ажиллах санал, зөвлөмжийг хүргүүлсэн.	100%
	178		4.. Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 08-00-04/28 дугаартай "Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх" тухай удирдамжийг 14 сумын Засаг даргад аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 225 тоот албан бичгээр хүргүүлж, бэлтгэл ажлыг хангуулж, 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны хооронд Айраг, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-үүд, Хөвсгөл, Хатанбулаг сумдыг хамруулж, ЗДТГазар, Хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг батлагдсан удирдамж болон аймгийн Засаг даргын 03 албан даалгаврын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар дээрх сумдын Засаг даргад улсын байцаагчийн 16 заалт бүхий 2 албан шаардлага /Хатанбулаг, Хөвсгөл сумдад/, 49 заалттай 6 зөвлөмжийг /Айраг, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Эрдэнэ, Замын-үүд сумда/ тус тус хүргүүлж хэрэгжилтийг хангуулахаар хяналт тавин ажилласан. Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, чанар аюулгүй байдал, отор нүүдэл, цаг агаарын аюултай үзэгдлийн үед гамшиг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар шалгалтад хамрагдсан сумдын удирдлагууд болон мэргэжилтэн нийт 40 албан хаагчид мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан. Улсын байцаагчаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 90.2%-ийн гүйцэтгэлтэй байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын танилцуулгыг нэгтгэж, ХХААХҮЯамны Салбарын хяналтын газрын хяналтын бичигтэйг 2024 оны 08-00-04/28 дугаартай	100%
98	179	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2024-08-28 Дугаар 2024_52_1	2.. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-ын 1.6 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай" 304 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/713 дугаар захирамжуудыг тус тус үндэслэн 2024-2026 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийн "Дүйцүүлэх албаны бэлтгэл" шатны сургалт, 2023-2025 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийн "Тусгай үүргийн бэлтгэл" шатны сургалтыг тус тус зохион байгууллаа. Сургалтыг Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байрлалд 2024 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 27-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Сургалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 19/03 дугаар тогтоолын дагуу 14 сумаас 35 иргэний татан авч "Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам"-ын дагуу зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 35 иргэнийг хувиасаар хангаж цэргийн алба зохион байгуулах зааврын дагуу цэргийн байранд байрлуулсан. Сургалтын төгсгөлд бие бүрэлдэхүүнд батламж гардуулан, иргэдийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгсөн.	100%
			180	1.1.. Тухайн нутаг дэвсгэрийнхээ нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг нэгдсэн сүлжээнд холбох, хяналт тавих чиг үүрэг бүхий "Tele камерын хяналтын дэд төв"-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт;	Сайншанд сумын нийтийн эзэмшлийн зам талбайн камерын хяналтын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэн чиглэлийн 153 ширхэг, хөдөлгөөнт 10 ширхэг камерыг суурилуулан теле хяналтын нэгдсэн төвөөс хянах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг орон нутгийн 1,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэхээр хийгдэж байна. Мөн Сайншанд суманд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хуучин хяналтын 96 ширхэг камеруудыг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 129.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэж байна.

99	181		1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дэд бүтцийг ашиглан "Теле камерын хяналтын дэд төв"-д холбоо боломжийг судалж, шийдвэрлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт;	Сайншанд сумын нийтийн эзэмшлийн зам талбайн камерын хяналтын удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэн чиглэлийн 153 ширхэг, хөдөлгөөнт 10 ширхэг камерыг суурилуулан теле хяналтын нэгдсэн төвөөс хянах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг орон нутгийн 1,5 сая төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэхээр хийгдэж байна. Мөн Сайншанд суманд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хуучин хяналтын 96 ширхэг камеруудыг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 129.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэж байна.	100%
	182	Гэмт хэргэ, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_86-1	2.. Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаа болон энэ тогтоолын 1.3-т заасан ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байхыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/02 тоот тогтоолоор Сайншанд, Замын-Үүд сумдад камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийг 101 байршилд 278 камер шинээр нэвтрүүлэхээр 2.1 тэрбум төгрөгийг төсөвт тусган шийдвэрлэсэн. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд нийт 140 цагт 366 чиглэлийн камер байршуулж, "Камерын хяналтын дэд төв"-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 19,5 сая төгрөгөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулан нэгдсэн сүлжээнд холбосон. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд MNS6423:2019 стандартад нийцсэн камерын системээр тоноглогдож, барилга байгууламжийн гадна гэрэлтүүлэг нь ойр орчимд байгаа эд зүйл харагдах, камерын бичлэг орж байхаар гадаад орчны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд аймгийн Цагдаагийн газраас 1184 аж ахуйн нэгжийг бүртгэл судалгаанд авч Цагдаагийн ерөнхий газрын камерын мэдээллийн цахим санд бүртгэлжүүлэн ажилласан.	100%
	183		4. Теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, Мэдээлэл технологийн үндэсний парк УТҮГ-тай хамтран "Кибер аюулгүй байдлын тухай хууль", "Хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль" хэрэгжилтийг хангах, цахим ур чадвар, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр танхим болон цахимаар дамжуулан 10 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт давхардсан тоогоор 1100 албан хаагчийг хамруулсан. Сум, орон нутгийн телевизүүдтэй хамтран нөлөөллийн аяны хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 5 төрлийн тоон контент үйлдвэрлэж цахим орчинд түгээж хүүхдийн эрхийн сайн дурын ажилтан, идэвхтэн багш, "Монголын аюулгүй байдлын академи НҮТББ"-тай хамтран 14 сумд, Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 сургуулиудад 113 удаагийн сургалтаар 13,234 сурагч, эцэг, эхийг хамруулж, сурагч багш балтгах, мэдээ мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Мөн "Сурагчийн аюулгүй байдал" цахим номыг 1500 ширхгийг тарааж ажилласан. Төрийн болон төрийн өмчит 96 байгууллага кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дотооддоо дагаж мөрдөх байгууллагын кибер аюулгүй байдлын журмыг батлан мөрдөн ажиллаж байна.	100%
100	184	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс тус хуулийн сургалтыг танхимаар 580 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 620 төрийн албан хаагчдыг хамруулсан. Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ёс зүйн дэд хорооноос төрийн болон захиргааны байгууллагуудын 102 ёс зүйн дэд хорооны 300 гаруй албан хаагчдыг хамруулан нэгдсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	100%
101	185	Журам батлах тухай "Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам" 2024-10-09 Дугаар 2024_120_1	2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай.)	Төрийн нууцад хамаарах 2.7 тэрбум төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг 2024-2025 онд хэрэгжүүлэхээр удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.	100%
102	186	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-10-23 Дугаар 2024_131_1	2. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримталж, Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, Засгийн газрын 2024 оны 136 дугаар, 74 дүгээр тогтоолууд болон энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд 7 нэгж талбарын 10.18 га газрыг мод үржүүлэг нийтийн ногоон байгууламжийн зориулалтаар иргэн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахаар баталсан 5 нэгж талбарын 4.69 га газрыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр олгож мэдээллийн санд бүртгэсэн.	100%
103	187	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	2. Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Төрийн байгууллагуудын кибер аюулгүй байдлын эрдслийн үнэлгээг аймгийн тагнуулын хэлтэстэй хамтран зохион байгуулахаар төрийн болон төрийн өмчит 100 байгууллагыг хамруулан ашиглаж буй систем, хүний нөөц, лог бүртгэл, мэдээллийн аюулгүй байдлын журмыг мөрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж ажилласан. Төрийн үйлчилгээг өөрөө өөртөө үйлчилж авах боломжтой ухаалаг КИОСК төхөөрөмж, суурилуулах 19 байршлын судалгаа мэдээллийг гаргаж ажилласан. 14 сум, 20 сургууль, 65 багийн Засаг дарга нарт ажиллах нөхцөлийг хангаж цахимжуулалттай холбоотой судалгааны дагуу компьютер, техник хэрэгслийн шинэчлэлтийг орон нутгийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж нийт 50 төрийн байгууллагад 2.3 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авч шинэчлэлт хийсэн. Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран системийн суурь судалгаа, серверийн хамгаалалтын талаарх судалгаануудыг авах ажлыг хамтран зохион байгуулж нийт 46 байгууллагыг хамруулж нэгтгэсэн.	100%

104	188	2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34	ҮИИ.5.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, барилга байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, хүртээмжтэй болгох, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт аймгийн аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Эрүүлжин хөгжих төв" тус тус өдөр тутмын үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орон сууцны жишиг хороолол Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт баригдсан "Мандах наран-5" орон сууцны хорооллын 502В, 502Д блок 144 айлын орон сууц нь "Түрээсийн орон сууц"-ны ангиллаар төлөвлөгдөж орон нутгийн хөгжлийн сангийн 13,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр "Антулга трейд" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан бөгөөд тус хороолол үйлчилгээний төвтэй 6 блок 384 айлын орон сууцанд харааны бэрхшээлтэй иргэний товруутай зам, тэргэнцэртэй иргэдийн налуу зам, хүүхдийн тоглоомын талбай, машины зогсоол зэргийг хийж гүйцэтгэсэн. 2024 онд шинээр ашиглалтад орсон 8 блок 528 айлын орон сууц, төрийн 1 байгууллага, 1 үйлчилгээний төв, нийт 10 объектын гадна дотор тохижилтыг стандартын дагуу хараагүй иргэний товруутай зам, цахилгаан шат, тэргэнцэртэй иргэдийн налуу зам, хүүхдийн тоглоомын талбай, машины зогсоол зэргийг иж бүрэн хийж гүйцэтгэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн амьдралд тэгш оролцох орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Орон нутгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй 75 барилга байгууламж байна.	100%
105	189	2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 1 дүгээр тэмдэглэл 2022-01-05 Дугаар 2022_1	ХХ.12.2. Шинжлэх ухааны академийн дүгнэлт, зөвлөмжийн холбогдох мэдээллийг нийтэд мэдээлэх арга хэмжээг эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулан зохион байгуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ендон, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал нарт даалгав.	Багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжих, эрчимжүүлэх зорилгоор АШУҮИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан "Эрдэмтдийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүн ажиллаж байгаа бөгөөд докторантэд суралцаж буй багш нарын судалгааны ажлыг хэлэлцэх, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцуулах, бүтээл хэвлүүлэхэд анхааран ажиллаж байна. Олон улсын Эрдэм шинжилгээний хуралд 6 илтгэл хэлэлцүүлэн хэвлүүлсэн, IF өндөртэй сэтгүүлд 2 өгүүлэл хэвлүүлсэн. Мөн Тайландын Чанг Май их сургуулиас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд 1 илтгэл хэлэлцүүлсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар 3,3 мян төгрөгийн дэмжлэг үзүүлж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хүүхэд, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг судлах, эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, судлаач, багш 9 илтгэгч оролцсон.	70%
106	190	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТУГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 19 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор нийт 2400 албан хаагчийг хамруулсан. Төрийн 46 байгууллага албан хэрэгцээндээ лавлагаа мэдээлэл гаргах, албан бичиг цахимаар боловсруулах, төрийн сангийн нэгдсэн системд тайлан мэдээ хүргүүлэхээр 450 албан хаагч ашиглаж байна. Шинээр 41 байгууллага, 300 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж эхэлсэн нь өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн байна. Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт 15167 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон. Тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр "И-Монгол академи"-ийн УТУГ, Улсын бүртгэлийн газартай хамтран "Цахим гарын үсгийн тухай хууль"-ийг сурталчлах ажлыг төрийн 1600 албан хаагч, 52 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 13331 иргэнийг хамруулан зохион байгуулсан.	100%
107	191	2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54	Х.12.2. "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж төрийн өмчийн бүх шатны боловсролын сургалтын байгууллагын болон шинжлэх ухааны байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч, дүнг танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Сургуулийн өмнөх боловсролын 33 байгууллага, ерөнхий боловсролын 21 сургуулийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийж барилга байгууламж, эзэмшил газрын гэрчилгээ бүртгэлийг шалган үзэхэд 20 сургууль, 33 цэцэрлэгийн хэмжээнд эзэмшил газарт зориулалтын бус барилга байгууламж байхгүй. Сайншанд сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн газрыг байгууллагын нэр дээр бүртгүүлэхээр холбогдох байгууллагуудад хүсэлт хүргүүлсэн бөгөөд одоогоор шийдвэр нь гараагүй байна.	100%

108	192	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 177 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэсэн нь 98 хувьд нэвтрүүлсэн байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-MonGo" академи УТУГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 540 албан хаагчийг хамруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн дагуу албан бичиг солилцооны дундын систем 2024 оны 07 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлийн дагуу албан бичиг солилцооны дундын систем "DOCX"-ийг ашиглан цахим хэлбэрээр баримт бичиг солилцож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллах чиглэлийн дагуу ERP систем нэвтрэсэн бүх байгууллагуудыг тус системд нэвтрүүлсэн байна.	100%
109	193	2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4	VIII.2.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, ахлах ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах 2019 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит байгууллагаас татан төвлөрүүлсэн автомашиныг цаашид зайлшгүй шаардлагатай байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх, худалдах, ажлыг зохион байгуулж 7 орон нутгийн өмчит байгууллагын 12 ширхэг ашиглах боломжгүй болсон авто машиныг татан төвлөрүүлж Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн 2023 оны 12 дугаар 05-ны 15/11 дугаартай тогтоолын дагуу 02 дугаар сарын 05-ны өдөр дуудлага худалдааг зохион байгуулж, 6 байгууллагын 8 авто машиныг худалдан борлуулж 27.9 сая төгрөгийг, хөрөнгө худалдсаны орлого дансанд төвлөрүүлээд байна. Цагдаагийн газрын 2 авто машин, Эм эргэлтийн сангийн 2 авто машины дуудлага худалдаанд оролцож бүртгүүлээгүй тул дуудлага худалдаа цуцлагдаж, олон нийтэд дахин дуудлага худалдаа зарлахаар бэлтгэж байна.	100%
110	194	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	XIV.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	"Цахим үндэстэн" баримтлах чиглэл 2022-2027, "Дорноговь аймгийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөө", "Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Дорноговь аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтадаа - II" 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын 2023 оны А/53 дугаар тушаалын хүрээнд "Цахим Дорноговь" хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр цахим аймаг болох суурь дэд бүтэц, программ хангамжуудыг бий болгохоор аймгийн хэмжээний судалгааг "ICT group", "Монголын програм хангамжийн холбоо"-той хамтран 11 нэр төрлийн суурь дэд бүтцийн систем болон хяналтын нэгдсэн удирдлагын системүүдийг бүтээхэд анхаарах асуудал, зөвлөгөө мэдээлэл, техникийн тодорхойлолт гаргах чиглэлээр ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
111	195	2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10	XVI.4.2. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мянзан өвчний дэгдэлтийг таслан зогсоох мал эмнэлгийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	2024 оны жилийн эцсийн байдлаар малын гоц халдварт 2 төрлийн өвчин давхардсан тоогоор 14 суманд оношлогдож, нийт 14975 толгой мал өвчлөн 10 толгой мал хорогдож, 127 толгой малын шинж тэмдэг арилж, 14838 толгой малыг зориудын аргаар устгасан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад өвчлөсөн малын тоо 16 дахин өссөн нь шинэ төрлийн өвчин гарч, оношлогдох хугацаа алдсантай холбоотой. Гоц халдварт ямааны гогдрон өвчнөөр 92 өрхийн 14639 толгой малыг устгаж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 63 дугаар тогтоолын хүрээнд нөхөн төлбөрт шаардагдах 3.2 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс шийдвэрлэн олгож байна.	100%
112	196	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.	Аймгийн Жендэрийн салбар хороог аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. "Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр 2024 онд 4 зорилт, 18 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг жигд хүргэх бодлого барин ажиллаж байна. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор "Дээрээт" ОУ-ын байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт "Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг ЭМС-ын 2022 оны А/449 дүгээр тушаалаар батлагдсан "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам"-ын дагуу 2024 оны 2-р сард шинээр нээж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэв. Тус кабинет нээснээр Урологийн эмчийн үзлэгт 22 хүн хамрагдаж, үүнээс мээ засал шаардлагатай 8 хүнд хагалгаа хийж, тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлжээ. Мөн нийгэмд тулгамдаж буй асуудал, оролцоо оролцоо, хандлага төлөвшилийг сайжруулах чиглэлээр "Дулаахан" говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулганыг 600 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж зохион байгуулсан. МУЗГ, ЖҮХ, Монгол Улсын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар батлагдсан "Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г үндэсний хэмжээнд танилцуулах ажлыг зохион байгуулж тус цахим сургалтад 150 гаруй төрийн алба хаагчид хамрагдсан. Жендэрийн	100%

	197		<p>XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,</p>	<p>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоонд аймгийн хэмжээнд 2024 онд 5294 хүн, өссөн дүнгээр 34622 иргэн хамрагдсан нь хамрагдавал зохих хүн амын 48.3%-ийг эзэлж байна. Мөн 0-17 насны хүүхдийн үзлэг 84%-д хүрч улсын дүнгээр 1-рт эрэмбэлэгдэж, 18-аас дээш насны иргэдийн үзлэг 27.7%-д хүрч, улсын хэмжээнд нийт дүнгээр 5-р байранд, улсын дүнгээс 2.3%-иар, аймгуудын дүнгээс 4.6%-иар тус тус өндөр байна. Аймгийн хэмжээнд 2 нэгдсэн эмнэлгүүдэд тус бүр 1, 1 ходоодны дурангийн аппараттай ба Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэг нь дурангийн эмчгүйгээс Улаанбаатар хотын дурангийн эмчтэй гэрээ байгуулснаар сар бүрийн сүүлийн 10 хоногт орон нутагт тогтмол ажилласнаар оношилгооны хүртээмжээ нэмэгдүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нэмэлтээр дүрс оношилгооны 1 эмчийг дурангаар мэргэшүүлэн сурган 2 дурангийн эмчтэй үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.</p>	100%
113	198	<p>2023 оны 3 дугаар сарын 22-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-03-22 Дугаар 2023_13</p>	<p>IV.2. Нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төв, бусад суурин газрын хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөлт хийгдээгүй байршилд болон иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа газар нь улс, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдаагүй газарт газар өмчлүүлэх, улсын тусгай хэрэгцээний болон бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцалтай газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, хэрэгжилтэд газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136, 137 дугаар тогтоолоор тус тус батлагдсан байршлуудад шинээр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Цаашид хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдад газар олгохгүй байх талаар холбогдох чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.</p>	70%
114	199	<p>2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17</p>	<p>XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов</p>	<p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, ажлын албанаас орон нутагт албан томилолтоор ажиллахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, Комиссын гишүүний 2 Шаардлага, 1 Зөвлөмжийн хэрэгжилтийг хуульд заасан хугацаанд ханган ажилласан. Зөвлөмж, шаардлагын хүрээнд хурдан морины унаач хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр ирүүлсэн шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч хариуг цаг тухайд нь хүргүүлэн ажилласан. Энэ хүрээнд хяналт тавих, сумдын Засаг дарга холбогдох чиг үүргийн байгууллагуудыг үүрэгжүүлэн ажилласан болно. 2024 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн 03/09 дугаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлагын дагуу Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын үйлчлүүлэгчдийн эрхийн хэрэгжилтийн хүрээнд орчин үеийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган 30 ахмадыг хүлээн авах хүчин чадалтай "Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, эмэгтэйчүүдийн хөгжлийн нэгдсэн төв"-ийг ашиглалтад оруулсан.</p>	100%
115	200	<p>2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18</p>	<p>XIV.7.3. Ой, хээрийн түймэр, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, анхааруулгыг олон нийтэд тогтмол хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.</p>	<p>Монгол Улсын Шадар Сайдтай аймгийн Засаг даргын 2024 онд байгуулсан төлөвлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар захирамж, Онцгой байдлын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Дэлгэрэх, Улаанбадрах, Замын-Үүд сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хээрийн гал түймрийн үед хил залгаа Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймаг, хилийн цэргийн 0129, 0168 болон Зэвсэгт хүчний 336-р анги, салбаруудтай харилцан ажиллах гэрээ байгуулан бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажилласан. Хавар намрын хуурайшилтын улиралд хээрийн түймэр гарч болзошгүй ургамлын гарц ихтэй Алтанширээ, Дэлгэрэх, Айраг, Даланжаргалан, Иххэт, Өргөн, Эрдэнэ сум болон хилийн бүс нутагт галын аюулаас урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлийг Цагдаагийн байгууллага, малчин иргэдийн оролцоотойгоор ажиллуулах Сумдын Засаг даргын Тамгын газартай зохион байгуулан ажиллах чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p>	100%
	201	<p>2023 оны 5 дугаар сарын 17-ний өдөр 19 дугаар тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_19</p>	<p>XVIII.2.3. Монгол Улсын хөгжлийн бодлого, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хүний хөгжил, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөөтэй байхад чиглүүлэн бодитой, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.</p>	<p>Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг олон нийтэд түгээх ажлыг тогтмол сурталчлан ажиллаж байна. Энэ хүрээнд 2024 оны 01 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн болон боловсруулж буй хуулийн төслийн мэдээллийг бэлтгэж төрийн албан хаагч, иргэд, олон нийтэд танхим болон цахим хэлбэрээр сурталчлах ажлыг зохион байгуулж хэвшсэн. Түүнчлэн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд шинээр нэмэгдсэн талаарх мэдээллийг товч байдлаар бэлтгэн тухай бүр аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, холбогдох агентлаг байгууллагад мэдээлэл хүргэн ажиллаж байна.</p>	70%

116	202	2023 оны 5 дугаар сарын 21-ний өдөр 21 дүгээр тэмдэглэл 2023-05-17 Дугаар 2023_21	XVIII.3.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах асуудлын хүрээнд газрын тосны хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж, шинээр нөөцийг тогтоох үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллах, газар ашиглуулах шийдвэр гаргаж, гэрээг байгуулж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идарбат, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт.	Мандах сумын Алхантагз багийн нутагт Бүтээгдэхүүн хуваах гэрээт XII талбайд "Смарт ойл" ХХК нь 550 орчим км2 талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлыг 2023 онд хийгдэж үйл ажиллагааг явуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлж ажилласан. 2024 онд Хатанбулаг сумын нутагт суурин кемпээ нүүлгэж, БНХАУ-аас хайгуулын өрөмдлөг хийх тоног төхөөрөмжөө татан авах ажлууд хийгдэж байна. Мөн засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 165 дугаар тогтоолоор "Гурванблан-ХХК" талбайд газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон "Баян петролиум" ХХК-ийн хооронд Бүтээгдэхүүн хуваах гэрээг 12 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан.	100%
117	203	2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2023-05-24 Дугаар 2023_22	XXI.5.3. Гамшгийн улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч, зудын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд 580,0 гаруй мянган толгой мал, амьтан зүй бусаар хорогдсон. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулан устгах тухай аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамж гарч мэргэжлийн байгууллага, сумдын 510 иргэн, албан хаагчид устгалын 119 цэгт 208 тээврийн хэрэгсэлтэйгээр ажиллаж, нийт 501,9 мянган сэг зэмийг цуглуулан холбогдох хууль, журмын дагуу булшлан устгаж, 175,3 мянган м2 талбайд халдваргүйтэлийг хийсэн.	100%
118	204	2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23	XXII.2.. "Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор shilen.gov.mn сайтad 98 заалтын дагуу Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байхаар заасан мэдээллийг байршуулж, Улсын хэмжээнд нэгдсэн системийн ашиглалтын үнэлгээгээр 80,8 хувиар үнэлэгдсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд, 14 сумдын ЗДТГ-уудад shilen.gov.mn-д мэдээлээ байршуулах админ эрх үүсгэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг гүйцэтгэж, аймгийн хэмжээнд 157 байгууллага сайтад нэвтрэх эрх авч, 122 байгууллага нээлттэй мэдээлээ байршуулсан.	100%
	205		XIII.5.2.2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт,	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Дорноговь аймгийн Засаг даргын 2023 оны А/01 дүгээр захирамжаар 2023-2024 оныг "Нээлттэй Дорноговь" зорилтот жил болгон зарлаж, төр, хувийн хэвшлийн 300 гаруй байгууллагуудтай хамтран зорилтот жилийн нээлт, "Нээлттэй Дорноговь-Барилга, орон сууц" үзэсгэлэн, "ХурДан" төвийн нээлт, Дорноговь аймгийн "Уул уурхайн зөвлөгөөн", Хөрөнгө оруулагчдын зөвлөгөөн, "Fuckup nights Dornogovi" эвент арга хэмжээ зэрэг 15 арга хэмжээг зохион байгуулж, 4500 гаруй иргэдийг хамруулж, 86,956 иргэнд мэдээ, мэдээлэл түгээж, 200,0 сая төгрөг зарцуулан ажилласан. Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнесийн хөгжүүлэх зорилгоор "Старт апп" төслийн уралдааныг зохион байгуулж нийт 38 төсөл ирснээс "Gennusis game" кафе, "Baby care" өрхөд хүрч үйлчлэх эрүүл мэндийн үйлчилгээ, Комик номоор дамжуулж өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох гэсэн 4 төслийг шалгаруулан тус бүр 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Уралдаанд шалгарсан төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд 10 ажлын байр шинээр бий болж 16,0 сая төгрөгийн орлого олсон. Мөн "Нээлттэй аймаг" зорилтод жилийн хүрээнд бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, сургалтыг зохион байгуулж "Бизнес ба хүний эрхийн зарчим", "Үйлчилгээнд анхаарах асуудал" зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж "Үйлчилгээний соёлыг бид түгээнэ" уриалгад 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нэгдлээ. Эдгээр ажлын үр дүнд Улаанбаатар хот болон бусад аймагаас 2024 онд	100%
119	206	2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25	XIII.5.3. Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын манлайлаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сурталчлан таниулах, санал авах хурлыг баг, хороо бүрд зохион байгуулж, хурлуудаас гарсан бүтээлч санал, санаачилгыг нэгтгэн шалгаруулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, орон нутгийн шийдвэр бодлогын талаарх мэдээ мэдээллийг нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн дагуу dornogovi.gov.mn, нээлттэй Дорноговь гар утасны аппликейшн, huduu.mn, shilen.gov.mn, сумд болон агентлаг байгууллагуудын мэдээллийг нийтэд мэдээлж ажилласан. Аймгийн Засаг даргын А/349 захирамжаар "Хот айлд" ажлын хэсгийг байгуулан 14 сумын малчин өрхөөр орж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, орон нутгийн шийдвэр бодлогын талаарх мэдээ мэдээлэл, өвөлжилт, хаваржилтыг хэрхэн хохирол даван туулахад улс, аймгийн онцгой комиссын хийж хэрэгжүүлсэн ажлыг тайлагнах, малчдын санал хүсэлтийг сонсож, сум, аймаг, улсын түвшинд эрэмбэлж, шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах ажлыг зохион байгуулсан. уг ажлын хүрээнд аймгийн 10,333 малчин өрх буюу нийт малчин өрхийн 59,3%-тай уулзаж, санал, хүсэлтийг авч, мэдээ мэдээлэл өгч, ажилласан.	100%

207		XIII.10.. "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг аймаг, нийслэл, сум, дүүрагт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав.	"Аймгуудын цахим шилжилтийн тайлан 2023"-т туссан бууралттай үзүүлэлтийг эрчимжүүлэхтэй холбоотой мэдээллийн технологийн чиглэлийн хүний нөөцийг бүрдүүлэхээр сумдаас мэдээллийн технологийн салбарын чиглэлээр суралцаж байгаа орон нутгийн харьяалалтай 32 оюутны 31 хувь нь сургалтын төлбөрт орон нутгийн төсвийн болон хандив, тусламжийн ах үүсвэрээс санхүүжүүлэн дэмжлэг үзүүлж орон нутагтаа ажиллуулах гэрээ байгуулсан. "Цахим Дорноговь 2023-2026" хөтөлбөрийг "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн бодлогын баримт бичиг, "Дорноговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", аймгийн Засаг даргын "2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 1 зорилт, 6 арга хэмжээг тусгаж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмжийг баримтлан төлөвлөлт гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	
	208	XVIII.1.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав: 1.2024 онд шилжэн хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;	Аймгийн хэмжээнд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 4 төсөл арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжиж байна. Үүнд: Замын-Үүд сумын 500 хүний суудалтай соёлын ордон-90%, Замын-Үүд сумын 640 хүүхдийн сургуулийн барилга-90%, Сайншанд суманд баригдаж буй 700 хүний суудалтай Саранхөхөө театрын барилга 79%, Сайншанд суманд баригдаж буй Говийн бүсийн ахмадын асрамжийн газрын барилгын ажлын гүйцэтгэл 100%-тай тус тус хэрэгжсэн.	100%	
	209	2023 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2023-09-26 Дугаар 2023_39	XVIII.1.4. Зураг төсөл зохиогч, гүйцэтгэчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт	Аймгийн хэмжээнд Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх нийт 18 төсөл, арга хэмжээний 224 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.	Х.Б
210	XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;	Аймгийн хэмжээнд Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх нийт 18 төсөл, арга хэмжээний 224.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг Сангийн яаманд хүргүүлээд байна.	70%		
211	1.6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тухайн орон нутгийн 2024 оны төсөвт тусган хэрэгжүүлэх доор дурдсан төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвөөс 2024 онд хэрэгжүүлэхийг холбогдох аймгийн Засаг дарга нарт; 1.6.1.Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засвар (Баянхонгор сум), Хүүхдийн зуслангийн их засвар; 1.6.2.Дархан-Уул аймгийн Цэцэрлэгийн засвар; 1.6.3.Дорноговь аймгийн 1 дүгээр сургуулийн барилгын засвар; 1.6.4.Орхон аймгийн Сургуулийн барилгын их засвар (Орхон, Баян-Өндөр сум, 14 дүгээр сургууль); 1.6.5.Өвөрхангай аймгийн Багшийн хөгжлийн ордны барилгын санхүүжилтийн 50 хувь (Өвөрхангай, Арвайхээр сум), Халамж үйлчилгээний барилга (Арвайхээр сум); 1.6.6.Өмнөговь аймгийн Ахмадын сувиллын барилга, 44 ор (Өмнөговь, Даланзадгад сум); 1.6.7.Увс аймгийн Улаангом сумын арын 4 замын уулзвараас тойрог цагаан хаалга хүртэлх авто замын шинэчлэл, гэрэлтүүлэг; 1.6.8.Ховд аймгийн Цэцэрлэгийн барилгын их засвар (Ховд, Жаргалант сум, 2, 3, 4 дүгээр цэцэрлэг).	Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн их засварын ажлыг нийт 4 багцад хуваан нээлттэй тендер зарласан ба Багц-1 ажлын гүйцэтгэгчээр "Дэнжин хүү" ХХК шалгарч, 318,9 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, үе шатны ажлын хуваарийн дагуу ажлыг гүйцэтгэж дуусаж улсын комисс ажиллаж холбогдох үүрэг даалгаврыг өгч ашиглалтад хүлээн авсан. Тус засварын багц-4 ажлын гүйцэтгэгчээр "Цүн түрүү" ХХК шалгарч орон нутгийн төсвийн 674.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн гүйцэтгэж дуусаж ашиглалтад хүлээн авсан. Их засварын багц-2 ажлыг орон нутгийн төсвийн 348.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэхээр "Дэнжийн хүү" ХХК шалгарч гэрээ байгуулсан ажлын явц 100%, багц-3 ажлыг орон нутгийн төсвийн 519.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр "Дэнжийн цамхаг" ХХК шалгарч гэр байгуулсан ажлын явц 75% тай тус тус үргэлжилж байна.	70%		
	212	2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40	2.6. Ипотекний зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт;	МУ-ын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын "Хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах, шийдэг мэргэжилтнүүдийг орон нутагт урин ажиллуулах, мэдлэг, чадвар, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх бодлого чиглэлийн хүрээнд аймгийн ЗДТГ, Дорноговь аймгийн Нутгийн зөвлөлөөс санаачлан бусад орон нутаг, нийслэлээс шилжин ирж буй нарийн мэргэжлийн ажилтнуудыг орон сууцаар хангах зорилгоор нарийн мэргэжлийн 10 эмч, англи хэлний 10 багшийг урьж орон сууцаар ханган ажиллуулсан. "Мандах наран" орон сууцны хорооллын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж төр хувийн хэвшлийн санхүүжилтээр 1006 айлын 33 орон сууц ашиглалтад орсноос гадна орон нутгуудад анх удаа "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн батлан хэрэгжүүлж 144 өрхийг түрээслээд өмчлөх орон сууцаар хангаж 2024 оны 11 сарын байдлаар нийт 291 иргэнд 29,5 тэрбум төгрөгийн ипотекний зээл олгосон.	100%
	213	2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхланд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 зүйл дүгээр заалт, 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/116, А/148 тоот Сангийн сайд, ХХАХУСайдын хамтарсан тушаалаар Мал эмнэлгийн үйлчилгээний зарим зардлын нормативыг шинэчлэн улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинэчлэн баталсан. Улсын төсвөөс санхүүжих 3 төрлийн вакцинжуулалтын арга хэмжээний үйлчилгээний хөлсний 50 хувь, орон нутгийн 7 төрлийн вакцинжуулалтад 320.0 сая төгрөгийн үйлчилгээний хөлсний санхүүжилтийг олгосон.	70%	
214	2.28. Аймаг, сумын баяр наадам тэмдэглэх зардлыг нэмэгдүүлэх боломжийг судлан, саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад танилцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Сумын баяр наадам тэмдэглэх зардлыг сум тус бүрд 10.0 сая төгрөгөөр, аймгийн баяр наадмын зардлыг 30.0 сая төгрөгөөр тооцон орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусган Сангийн яаманд хүргүүлсэн.	100%		

	215		2.41. Дорноговь аймгийн иргэн Х.Данзанравжаагийн өвөг эцгийн хэлмэгдсэн талаарх хүсэлтийг шалгаж, шийдвэрлэхийг Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргалд;	Иргэн Х.Данзанравжаагийн эзэгнэж болох С.Дэлгэрмаад эцгийнх нь хэлмэгдсэнийг цагаатгаж нөхөж олговор болох 40.0 сая төгрөгийг 2024 оны 02 дугаар сард гардуулан өгсөн.	100%
	216		2.94. Энэ тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж)-т, хэрэгжилтийн явц, тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим системд оруулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт " гэжээ.	Тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварыг тухай бүр гарган ажиллаж байна.	100%
122	217	2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41	XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Тайлант онд Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд сумууд хувийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 87.2 га талбайд хуримтлагдсан хог хаягдлыг түрж цэвэрлэн орчны бохирдлыг бууруулж 110 га талбай болгосон. Эрдэнэ сум хог хаягдлын салхин доод талд 150метр урттай 4 метр өндөртэй торон хашаа байгуулж, камержуулах ажлыг орон нутгийн төсвийн 11.0 сая төгрөгийн хөрөнгөөр барих ажил үргэлжилж байна. Замын-Үүд сум хог ангилан ялгах үйлдвэр, хог хаягдлыг ландшафтийн аргаар устгах 3 шатлал бүхий талбай, хашаажуулах зорилгоор "Сэвхүүлийн тойромд байрлах сумын нэгдсэн хөгийг цэгийг цэгцлэх ажил"-ыг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 4.0 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр "Элемент" ХХК-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд сум орон нутгийн төсвийн 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 72 га талбайд тархсан хог хаягдлыг 10 га талбайд шахах, цэвэрлэсэн газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх, хогийн цэг рүү чиглэсэн 2 км автозамыг сайжруулж хаших ажлууд хийгдсэн. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилах чиглэлээр 22 удаагийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 10596 иргэн 32 аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл өгч 120 гаруй өрх, 45 ААНБ, 8 сургууль цацарлаг хогоо ялган ангилан хэвшиж 11 тн хуванцар сав, 3 тн шил, 25 тн хаягдал цаас, 29 тн гялгар уутны хаягдлыг цуглуулан түүхий эдийн нөөц бүрдүүлж, үүнээс 8 тн гялгар уутыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан. Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 52.0 сая төгрөг хөрөнгө оруулалтаар 10 га талбайд шахах, цэвэрлэсэн газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх, хогийн цэг рүү чиглэсэн 2 км автозамыг сайжруулж хаших ажлууд хийгдсэн. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ялган ангилах чиглэлээр 22 удаагийн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 10596 иргэн 32 аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл өгч 120 гаруй өрх, 45 ААНБ, 8 сургууль цацарлаг хогоо ялган ангилан хэвшиж 11 тн хуванцар сав, 3 тн шил, 25 тн хаягдал цаас, 29 тн гялгар уутны хаягдлыг цуглуулан түүхий эдийн нөөц бүрдүүлж, үүнээс 8 тн гялгар уутыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан. Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 52.0 сая төгрөг хөрөнгө оруулалтаар 10 га талбайд шахах, цэвэрлэсэн газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх, хогийн цэг рүү чиглэсэн 2 км автозамыг сайжруулж хаших ажлууд хийгдсэн.	100%
123	218	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнтэй тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр эрчимжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээ байхгүй болно.	100%
124	219	2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 48 дугаар тэмдэглэл 2023-11-29 Дугаар 2023_48	XIX.2. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлангийн дүгнэлтийн хүрээнд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэрүүдийг хүчингүй болгох арга хэмжээ авч Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүрүүлэх, хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй 81 шийдвэрийг зохиж журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээг тус тус 2024 оны 1 дүгээр улиралд багтаан авахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав;	Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэлтэй 2 шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн бөгөөд ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн шийдвэр байхгүй болно.	100%
	220		XIII.2. Зарим аймагт өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан гамшаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов."	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн. УОК-оос аймгийн Засаг дарга нартай цахимаар 5 удаа, Аймгийн Онцгой комиссын хуралдааныг 7 удаа, шуурхай штабын хуралдааныг 9 удаа зохион байгуулав. Аймгийн Засаг даргын 2024 оны А/278 дугаар захирамжаар "Шуурхай штаб" байгуулж 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн ажилласан. Аймгийн Шуурхай штабын жижүүрийн бүрэлдэхүүн өдөр бүр 12:00 цагт аймгийн шатахууны нөөцийн мэдээ, 17:00 цагт авч хэрэгжүүлж буй нөхцөл байдлын мэдээг улсын Онцгой комиссын Шуурхай штабын "uok.nema.shtab.mn" цахим хаягаар өдөр бүр, цаг үеийн нөхцөл байдлын мэдээг тухай бүр Улсын Онцгой комисст хүргүүлэн ажиллав. Мөн Аймгийн Шуурхай штабт 24 цагаар Онцгой байдлын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар болон аймгийн Онцгой комиссын гишүүн байгууллагуудын 135 алба хаагч, 14 сумын Шуурхай штабт 378 алба хаагч судалгаа, мэдээ, тайланг нэгтгэх үүргийг гүйцэтгэн ажилласан. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Төрийн тусгай чиг үүргийн байгууллагын 102 алба хаагч, 32 нэгж техник хэрэгсэлтэйгээр, төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний 865 алба хаагч, 128 нэгж техниктэй өвөлжилт, хаваржилт хүндэрсэн 4 сумын 350 өрхийн 10063 км зам харуу мөн сумын Онцгой комиссоос 3 сумын 92 өрхийн 1728 км зам харуу гаргаж өвс тээжээл, хүнсний болон эмийн багц хүргэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулсан.	100%
125		Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 49 дүгээр тэмдэглэл 2023-12-06 Дугаар 2023_49			

221		<p>XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав</p>	<p>2024-оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр махны нөөц бэлтгэх тендэрт Сайншанд сумын 5 дугаарт багт үйл ажиллагаа явуулдаг "Үзүүрт зараа" ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд үхэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн, нийт 100 тн махны нөөцийг бүрдүүлэн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ныг хүртлэх хугацаанд зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгийн хямд үнээр худалдаанд гаргаж дууссан. Нөөцийн махны борлуулалт, түгээлтийг өргөжүүлж Замын-Үүд сумын 2, Сайншанд сумын 11, нийт 13 хүнсний дэлгүүрт худалдан борлуулсан. Нөөцийн мах худалдаж эхэлсэн хугацаанаас эхлэн 14 хоног тутам мэдээллэх зарцуулалтын явцын мэдээг гаргаж, махны нийлүүлэлт, худалдаалах үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж, арга зүйгээр ханган ажилласан. Орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 тн нөөцийн мах бэлтгэх тухайн үеийн зах зээлийн үнээс 2000-4000 төгрөгийн хямд үнээр 2025 оны хавар, зуны улиралд төв суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх махны тендэрт "Суман зурхай" ХХК шалгарч, гэрээ байгуулах шатандаа байна.</p>	100%
222		<p>XXV.4.3. Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав</p>	<p>МУЗГ-ын санаачилгаар 2022 оны 05 сараас орон даяар эхэлсэн "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоо"-нд аймгийн хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар 5421 хүн, өссөн дүнгээр 34662 иргэн буюу 47.9%-ийг хамруулжээ. Үзлэгт 63.3% (21961)-ийг 0-17 насны хүүхэд, 36.7% (12714)-ийг 18-аас дээш насны хүн ам эзэлж байна. Үзлэгээс хавдрын нийт 29, тайлант онд 7 тохиолдлыг илрүүлж, дээд шатлалд илгээж, оношийг батлуулан эмчилгээний асуудлыг шийдсэн. Эрт илрүүлгээс 631 өвчлөлийг шинээр илрүүлсний 425 нь хүүхдийн өвчлөл эзэлж, үүнээс 87.3% шүдний өвчлөл бүртгэгдсэн ба 283 хүүхдийг эмчилгээнд хамруулан эрүүлжүүлсэн. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор 2024 онд 2 удаагийн аян зарлаж, үзлэгийн ач холбогдлыг сурталчлан, 67 удаагийн сургалт, сурталчилгаанд 3380 хүнийг хамруулан, 12 төрлийн 3066 ширхэг гарын авлагыг иргэдэд түгээж, 1121 хүнийг үзлэгт хамруулсан. ЭМС-ын 2024 оны А/150 дугаар тушаалын хүрээнд УНТЭ-ийн амчээр удирдуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй явуулын баг Дорноговь аймагт 15 хоног ажиллаж, 13 сумын 1017 хүнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулснаас хавдрын сэжигтэй 6 тохиолдлыг илрүүлж, дээд шатлалын эмнэлэг рүү илгээсэн. Сурьвэгийн эрт илрүүлэг, идэвхтэй тандалтыг халдварт ба халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт 1376 хүн хамрагдаж, шинэ сурьвэ бүртгэгдээгүй. Мөн ЭМГ-ын 2024 оны А/41 тушаалын дагуу Сайншанд сумын батлагдсан тохиолдол хавьтал, эрсдэлт бүлгийн 146 иргэнийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, 8 хүнээс цэрний сорьц авч одоогоор шинжилгээний хариу баталгаажиж гараагүй байна. 2024</p>	100%
223		<p>XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав</p>	<p>Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс аймгийн 2024-2025 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн: 98.7% нь хувь хүрэлцээтэй бусуу өвчтэй, 1.3% нь даац 1-5 дахин хэтэри гарсан. Бэлчээрийн даацын мэдээнд үндэслэн өвөлжилт хаваржилт, отор нүүдлийн зураглалыг гарган холбогдох газруудыг мэдээллээр хангаж ажилласан. 2024-2025 онд аймгийн хэмжээнд нийт 14 сумын 288,9 мянган толгой мал, хонин толгойд шилжүүлснээр нийт 433,9 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэх болон зах зээлд борлуулах судалгаа гарсан ба зах зээлд болон хүнсэнд 242630 тн махыг хэрэглэж, зүй бус хорогдлоор 613.9 мянган толгой мал хорогдсон. Дээрх дүнгүүдээр малын тоог тооцоход өмнөх оноос 31 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	100%
126	<p>2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51</p>	<p>XXV.3.2.5. Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол, доройтол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаагаар холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Хог хаягдал болон дахивар ангиллын тухай ойлголт мэдээллийг ЕБС-уудын сурагчдад өгөх, сурагчдыг хогоо ангилах дадалд уриалах, хэвшүүлэх, сургууль бүрийг хогоо ангилдаг, дахивраа тушаадаг эко сургууль болоход чиглүүлэн "Говийн эко сургууль" төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Сайншанд сумын 6-н сургууль, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Даланжаргалан, Эрдэнэ сумдын сургууль цэцэрлэгүүд дахивар цуглуулж хэвшсэн бөгөөд Эко говь үйлдвэрт 11 тн хуванцарыг нийлүүлсэн байна. Тайлант онд лааз 3тн, шил 4.5тн, 11 тн хуванцар хаягдал, 29 тн гялгар уутны хаягдал цуглуулж, 8 тн гялгар уутыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Мөн Улаанбаатар хот дах "Нью метод ХХК"-ны электрон хаягдал дахин боловсруулах үйлдвэрт "Аюулыг авдаръя" аяны хүрээнд ЕБС-иудаас цуглуулсан 600кг хаягдал батарей, цахилгааны хог хаягдлыг тээвэрлэн тушаасан.</p>	100%

127	225		XXV.3.2.11.. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүтцийг тогтоох, шинэчлэн боловсруулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлын гүйцэтгэгчээр "Ланланд эко" ХХК гүйцэтгэхээр шалгарч орон нутгийн төсвийн 329 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж шаардагдах суурь мэдээ, мэдээллийг цуглуулж бэлтгэл ажлыг хангасан. Хэргийн судалгааны ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрөөс эхлэн Алтанширээ, Мандах, Сайншанд, Дэлгэрэх сумдын малчдын нэгдсэн өдөрлөг, Иххэт, Сайхандулаан, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах, сумдын Сумдын удирдах албан тушаалтнууд болон ЗДТГ-ын албан хаагчдад аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг танилцуулга, сургалт хийж санал асуулга авч, сумдын нийгэм, эдийн засгийн суурь нөхцөлийн судалгаа, хэргийн хэмжилт судалгааг хийж төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай байршлыг солбицол тодорхойлж, холбогдох албан тушаалтнуудтай хамтран сумын нутаг дэвсгэрт тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тусгах шаардлагатай асуудлыг сумын хил бүхий 1:100000-ны масштабтай байрзүйн зурагт тэмдэглэх ажлыг гүйцэтгэсэн. Дээрх ажлыг чанартай гүйцэтгэснээр нийтийн болон амины орон сууцны бүсийг шинэчлэн тогтоох боломж бүрдэх юм.	70%
	226		XVII.2.4.. Орон нутагт мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкуудтай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	"Мал төхөөрөх, боловсруулах, худалдаалах, нөөцлөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Суман зурхай" ХХК, "Боржигон туяа" хоршоо, "Үзүүрт зараа" ХХК, "Буман-Ашигт" хоршоо, иргэн А.Шижирбаатар нарын мэдээллийг арилжааны банкинд хүргүүлж Монгол Улсын Засгийн газар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас олгох хөнгөлөлттэй зээлд хамруулах тухай албан бичгийг ХХААХҮЯ-д хүргүүлсэн. Уг албан бичгийн хүрээнд арилжааны банкинд ХХААХҮЯ-аас дээрх компаниудыг судлах албан бичиг хүргэгдсэн боловч банкны зүгээс тавьсан шаардлага хангаагүйн улмаас азал олгоогорой болно.	100%
128	227	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52	XL.3.3. Батлагдсан төсөвт эх үзвэрийнхээ хүрээнд мал, махны борлуулалт, худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	"Орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр 2024-оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бэлтгэх төндөрт Сайншанд сумын 5 дугаарт багт үйл ажиллагаа явуулдаг "Үзүүрт зараа" ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд үхэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн, нийт 100 тн махны нөөцийг бүрдүүлэн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ныг хүртлэх хугацаанд зах зээлийн үнээс кг тутмыг 2000-3000 төгрөгөөр хямд үнээр худалдаанд гаргаж дууссан. Нөөцийн махны борлуулалт, түгээлтийг өргөжүүлж Замын-Үүд сумын 2, Сайншанд сумын 11, нийт 13 хүнсний дэлгүүрт худалдан борлуулсан. Нөөцийн мах худалдаж эхэлсэн хугацаанаас эхлэн 14 хоног тутам мэдээлэх зарцуулалтын явцын мэдээг гаргаж, махны нийлүүлэлт, худалдаалах үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж, арга зүйгээр ханган ажилласан. Орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 тн нөөцийн мах бэлтгэх тухайн үеийн зах зээлийн үнээс 2000-4000 төгрөгийн хямд үнээр 2025 оны хавар, зуны улиралд төв суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх махны төндөрт "Суман зурхай" ХХК шалгарч, гэрээ байгуулан хүнсний хэрэгцээ хангагдаж байна.	100%
	228		XXXX.11.4. Монгол Улсад 2024 онд зохион байгуулах олон улсын арга хэмжээний цаглабрыг гадаадад сурталчлах арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Соёлын сайд Ч.Номин нарт, цаглабарт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ болон Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав."	Монгол Улс, Бүгд найрамдах Хятад ард улстай дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэн 2 орны соёлын харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, хамтарсан урлагийн тоглолт зохион байгуулж, 2 улсын 80 албан хаагч, уран бүтээлчид оролцож 350 иргэнд 2 улсын соёлыг сурталчлан, таниулсан. Уг арга хэмжээнд 18,0 сая төгрөг зарцуулсан. Үндэсний өв соёлоо дээдлэн уламжилж, үр хойчдоо өвлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, "GO MONGOLIA" аяны хүрээнд "Монгол гэр" үзэсгэлэнд оролцож, гадаад, дотоодын 12000 гаруй иргэд, хүүхэд багачуудыг сурталчлан ажиллалаа. Үзэсгэлэнгийн арга хэмжээнд Соёлын яамнаас 30,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Жил бүр Улаанбаатар хотноо уламжлал болон зохион байгуулагддаг "Ай Ти Эм" аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгийн бүтээлүүдийг оролцуулан, гадаад дотоодын жуулчид, аялал жуулчлал сонирхогчдод танилцуулсан. Тайлант онд 3 арга хэмжээнд оролцож 28,0 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлсэн байна.	100%
128	229	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэл 2024-01-31 Дугаар 2024_5	12.9.2. Орон нутагт мал, мах худалдаалах зориулалтын цэг байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Аймгийн хэмжээнд 9 суманд /Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Сайншанд, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ/ мах худалдан авдаг хувь хүн, мөн мах худалдан борлуулдаг 2 зах, 12 махны дэлгүүрээр иргэдэд мах, махан бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, үйл ажиллагаа явуулж байна. Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулдаг малын хорио цээрийн тусгаарлагдсан бусад амьд мал хөлөөр нь экспортлох зөвшөөрөлтэй "БИИТ МОНГОЛ ХХК" нь нийт 140,000 гаруй толгой малыг экспортлосон. гаруй мянган толгой малыг тус аймагсад худалдан авч, экспортод гаргасан. Сайншанд сумын хэмжээнд мах худалдан борлуулдаг 2 зах, 4 үйлчилгээний газар, нийт 6 цэг тогтмол үйл ажиллагаа явуулж, малчдад зориулан мах худалдах стандартын шаардлага хангасан 1 цэгийг шинээр байгуулан ажиллуулж байна.	100%
	230		22.6.2. Зудын улмаас хорогдсон малын сэг, зэм булшлах, устгах ажлыг өргөн хүрээтэй, шуурхай зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч, зудын нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд 580,0 гаруй мянган толгой мал, амьтан зүй бусаар хорогдсон. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулан устгах тухай аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамж гарч мэргэжлийн байгууллага, сумдын 510 иргэн, албан хаагчид устгалын 119 цэгт 208 тэврийн хэрэгсэлтэйгээр ажиллаж, нийт 501,9 мянган сэг зэмийг цуглуулан холбогдох хууль, журмын дагуу булшлан устгаж, 175,3 мянган м2 талбайд халдваргүйтгэлийг хийсэн.	100%

129	231	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 8 дугаар тэмдэглэл 2024-02-28 Дугаар 2024_8	22.10.3. Орон нутгийн хэмжээнд бэлтгэсэн махны чанар, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх, стандартын шаардлага хангасан махыг төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Дорноговь аймгийн төв суурин газрын 2024 оны хавар, зуны улирлын хүнсний хэрэгцээнд зориулан орон нутгийн төсвийн 200.0 сая төгрөгөөр махны нөөц бэлтгэх тендэрт Сайншанд сумын 5 дугаарт багт үйл ажиллагаа явуулдаг "Үзүүрт зараа" ХХК шалгарч дотоодын хэрэгцээнд нийт 100тн мах /хүэр-30тн, хонь-50тн, ямаа-20тн/-ыг бэлтгэж, нөөцлөсөн. Тус компани нь бэлтгэсэн 3 төрлийн махаа аймгийн Мал эмнэлгийн газрын итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээнд хамруулсан. Лабораторийн 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар шинжилгээний дүнгээр MNS 4373:1996 стандартыг хангаж байсан. Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2 удаа /2024.03.11, 04.17-ны өдөр/ ажиллаж, тус компаний хөргөлттэй агуулахад байршуулж, хадгалсан 100 тонн махны гарал үүсэл, нэр төрөл, тоо хэмжээ, махны чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг газар дээр нь шалгаж, хадгалалт, жижиглэн хөрөөдөж савлах үйл ажиллагаатай танилцахад агуулахын бүртгэлээр нийт үхрийн мах 30тн, хонины мах 50тн, ямааны мах 20тн, нийт 100тн махыг яс, мах тэнцүү жижиглэн хөрөөдөж багцалж савласан байв. Тус компани нь нөөцийн махаа Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Иххэт сумд болон Сүхбаатар, Хэнтий аймгийн сумдаас мал, мах бэлтгэлийг хийж бүртгэлжүүлсэн байсан.	100%
130	232	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл 2024-03-27 Дугаар 2024_12	14.8. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 06 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын захирал, дарга нарт, үр дүнг нэгтгэж 2024 оны 06 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд тус тус даалгав. (Үндэсний судалгааны нэгдсэн платформын ажлын явцын талаар)	"Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй Бодлогын "аймгийн стратеги төлөвлөгөө", "аймгийн хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл", "аймгийн Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр", "аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний баримт бичгүүдийн судалгаа, төлөвлөгөө, тайлан мэдээг dornogovi.gov.mn цахим хуудасны бодлогын баримт бичиг цэсэд байршуулсан. Мөн sudalгаа.gov.mn цахим хуудсанд аймгийн хэмжээнд хийгдсэн судалгааны тайлан мэдээллийг байршуулж ажиллаж байна.	100%
131	233	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжих байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.(Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан нийгмийн салбаруудад хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудаас Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулиар тус аймагт 44.9 тэрбум төгрөгийн 17, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 65.5 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ батлагдаж 8 дугаар сарын байдлаар улсын төсвийн 11.7 тэрбум төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, Орон нутгийн төсвийн 18.0 тэрбум төгрөгийн 28 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, үе шатны ажлын хуваарийн дагуу ажлыг гүйцэтгүүлж захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг сар бүр Шилэн дансны мэдээлэлд шивж олон нийтэд сар бүр мэдээлэлэн ажиллаж байна. Хонины мах 400 кг нийт 42,340 кг махны нөөцтэй 51 ширхэг гарал үүслийн гэрчилгээ олгон ажилласан.	100%
	234		14.17.1.1. Газрын нэгдмэл сангийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх болон газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгохтой холбогдсон үйл ажиллагааг Газрын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.(Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн талаар)	"Аймгийн хэмжээнд 2023 оны Газрын нэгдмэл сангийн тайланг эцэслэн гаргаж 2024 оны 93 дугаар албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн Хот суурин газарт шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж нэгдмэл санд хяналт тавин ажиллаж байна.	100%
132	235	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэл 2024-04-10 Дугаар 2024_14	14.17.1.2. Бэлчээрийн газар ашиглалт, түүний даацыг тохируулах, өнжөөн сэлгэх, хүчтэй эзлэгдэл, эвдрэлд өртсөн тариалангийн газрыг нөхөн сэргээх, хот суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжилтийг зохион байгуулан ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	"Тус аймгийн 14 сумын нутаг дэвсгэрт 2024 онд 8915222.3 га бэлчээрийн газарт 228 мониторингийн цэгт хэзэрийн судалгааг гүйцэтгэж суурин боловсруулалтын ажил бүрэн хийгдсэн. Тайлант оны мэдээг 2023 онтой харьцуулахад байгалийн унаган төрхөө алдаагүй буюу нэгдүгээр ангиллын бэлчээр нийт бэлчээрийн 9.6 хувь буюу өмнө онтой адил, бага зэрэг доройтсон бэлчээр 41.6 хувь буюу 2023 оноос 16.8 хувиар буурсан төлөвтэй, дунд зэрэг доройтсон бэлчээр 14.1 хувьтай, өмнө онтой харьцуулахад 1 хувиар буурсан, хүчтэй доройтсон бэлчээр 10.5 хувь, 2023 оноос 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй, маш хүчтэй доройтсон бэлчээр 0.4 хувийг эзэлж байна. Газрын мониторингийн цахим системд 14 сумын 228 цэгийн судалгааны үр дүнг оруулаад байна. Судалгааны үр дүнгээс харахад Эрдэнэ, Хөвсгөл, дэлгэрэх, Хөвсгөл, Сайхандулаан сумдад бэлчээрийн даац тодорхой хэмжээгээр хэтэрсэн тул холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	70%
133	236	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15	20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгах аар заасан мэдээллийг "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;(Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаар)	Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны 98 төрлийн нээлттэй мэдээллийг байршуулан 2024 оны жилийн эцсийн байдлаар Төрийн цахим үйлчилгээний газрын үнэлгээгээр 80,8 хувиар үнэлэгдсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 157 төрийн байгууллагад нэгдсэн системд нэвтрэх эрх үүсгэн, мэдээлэл байршуулах техникийн зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч 122 байгууллага "Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)"-д тогтмол мэдээллээ байршуулан хуулийн хэрэгжилтийг ханган ашиглаж байна.	100%
	237	Монгол Улсын Засгийн газрын	26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчих газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт;	Шинээр газар олгох байршуулыг төлөвлөхөд хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж шатахуун түгээх станц, галын аюулгүйн нормд нийцүүлэн төлөвлөж байгаа бөгөөд шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчсөн газар олголт хийгдээгүй байна.	100%

134	238	2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16	26.3.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцад орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг байршуулж, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр болон бүх шатны Засаг дарга нарт;	Аймгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 42 аж ахуйн нэгж байна. Тус аж ахуйн нэгжүүд нь орчны дүрс бичлэгийн техник, хэрэгслийг бүрэн байрлуулсан, дүрс бичлэгийг 30 хоногоос 3 сарын хооронд хадгалах хугацаатай, цагдаагийн байгууллагаас эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нар шаардлагатай тохиолдол бичлэгийг хянаж, явцын шалгалтыг хийж ажиллаж байна.	70%
135	239	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл 2024-05-01 Дугаар 2024_17.1	28.3.1. "Нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж аймаг, нийслэл, салбарын түвшинд ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагатай хэлэлцээ хийж хамтын хэлэлцээр байгуулан, ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	2024-2026 онд хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хамтын хэлэлцээрийг байгуулах саналыг ажил олгогч, үйлдвэрчний эвлэлд хүргүүлэн саналыг нэгтгэн салбар хорооны хурлаар хэлэлцэж 12 сард батлуулахаар ажиллаж байна. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах гурван талт хороонд нийт 13 өргөдөл ирж, хариуцах төлөөлүүдтэй уулзаж эвлэрүүлэх арга хэмжээг авч ажилласан.	70%
136	240	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэл 2024-05-08 Дугаар 2024_18.1	19.3.2. Уг төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулах, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөө, гадаадын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгав.	Цахим "Цахимд хэвшье" уриан дор Digital first-D1 EXPO өдөрлөгийг аж ахуйн нэгж байгууллагуудад цахимжуулалтын талаар мэдлэг мэдээлэл өгч, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан, залуучуудад сургалтын дэмжлэг үзүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор, программ, техник хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 15 байгууллагыг хамруулан өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчлан танилцуулах зорилгоор Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Мэдээлэл технологийн газар, МОСА-тай хамтран 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдөр зохион байгуулж ажилласан. Тус өдөрлөгт нийт Төрийн байгууллагын 166 албан хаагч, ЖДУ бизнес эрхлэгчид 43, ЕБС-ийн ахлах ангийн 285 сурагч, 10 багш нарыг хамруулж нийт 504 иргэн оролцсон байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia", "E-business" системийг ашиглах, цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах сургалтыг 25 удаа зохион байгуулж нийт 1102 иргэн, 12 байгууллагын 181 албан хаагч хамруулсан. Нийт 458 төрлийн лавлагаа, мэдээллийг 51000 удаа гаргаж үйлчилсэн. "E-Mongolia" системээр 1 дүгээр ангид элсэх 1415 хүүхдийг бүртгэж, анги хуваарилалтыг эцэг эхэд цахимаар хүргэн, esis.edu.mn-д бүртгэлийг баталгаажуулсан. "ХурДан" төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг "e-mongolia.mn", "e-halamj.mn", "etax.mn", "e-gazag.gov.mn", "nd-даатгал.mn", "e-halamj.mn" системээр хийж байна.	100%
137	241	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1	22.5.2. Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Энэ онд Замын-Үүд, Хөвсгөл сумдын ерөнхий боловсролын сургуулийн өндөр насжилттай хуучин барилгыг буулгаж шинээр барихаар төлөвлөсөн. Замын-Үүд сумын ерөнхий боловсролын сургуулийг шинээр барих ажлыг "Билгүүн монгол" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 45% тай явагдаж байна. Орон нутгийн төсвийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Хөвсгөл сумын ЕБС-ийн өргөтгөл барих, хуучин сургуулийн гадна фасад засварын ажлын гүйцэтгэгчээр "Хөх оноо" ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар хуучин сургуулийн метал пасадны ажил хийгдэж байна. Шинэ сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 15%-тай байна.	70%
138	242	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэл 2024-05-22 Дугаар 2024_20.1	19.1. Үүнтэй холбогдуулан зудын улмаас мал нь хорогдоон малчин өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, тэднийг малжуулах хөтөлбөрт хамруулах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаан бүрд танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд, малчныг малжуулах хөтөлбөрт хамруулах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, аймгийн Засаг дарга нарт даалгав.(Зудын улмаас мал нь хорогдоон малчин өрхүүдийн талаар)	Малчин өрхийн амьжиргааг дэмжих, ажилтай орлоготой болгох ажлын хэсэг"-ийг аймгийн Засаг даргын 2024 оны А/275 дугаар захирамжаар байгуулан ажлын хэсэг хуралдаж зохион байгуулах ажлын төлөвлөлтөө хэлэлцсэн. Малжуулах төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын хэсгээс хүн ам зүйн судалгаа мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөхөд анхаарч айл өрхийн байршил, ам бүлийн тоо, хөдөлмөрийн чадвар, өндөр настан, СӨБ, ЕБС, хөгжлийн бэршээлтэй, өрх толгойлсон, өрхийн орлого, малын тоо, малын хоргодол зэрэг 41 асуумжаар гаргасан. Малжуулах төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийт малын 70%-аас дээш хоргодолтой 14 сумын 547 малчин өрхийн судалгааг гаргасан. Үүнээс огт малгүй болсон Дэлгэрэх-25, Иххэт-16, Айраг-5, Сайншанд-4, Алтанширээ-2, Даланжаргалан-1, Мандах-1, Сайхандулаан-1, нийт 55 малчин өрх байна 3Г-аас хэрэгжүүлж байгаа малжуулах хөтөлбөр нь Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын ямаар дамжуулан орон нутагт ХХҮГ хэрэгжүүлэн ажиллаж байна. Манай аймагас 121 малчин өрх малжуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/680 дугаар захирамжийн дагуу "Малчдын амьжиргааг дэмжих төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх хурал"-ын хэрэгжилтийг ханган Сайншанд, Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Иххэт сумдын 50 малчин өрхийг нийт 300 сая төгрөгийн санхүүжилтаар 1829 толгой бог малаар малжуулсан.	100%
139	243	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл 2024-06-06 Дугаар 2024_22	37.1.1. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирагч) нарт	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөдөлгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн тус аймагт зохион байгуулсан. Малчид, иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх "Зөвлөн туслах баг"-т нийт 42 албан хаагч ажиллаж аймгийн нийт малчин өрхийн 70.3 хувь буюу 3248 өрх, нийт малчдын 83.09 хувь буюу 5881 малчин, бусад 2576 иргэнд хүрч ажилласан. Дорноговь аймагт 185 хоршоо шинээр байгуулагдаж, 792 иргэд, малчин хоршоонд бүртгүүлж, 108 хоршооны гишүүн 404 малчин 15.5тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн.	100%

140	244	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	31.9.6. 2/ Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Төрийн үйл ажиллагаа болон нээлттэй мэдээллийг олон нийтэд ил байлгах зорилгоор shilen.gov.mn системд 160 байгууллага бүртгэгдэж, шилэн ажиллагааны системн ашиглалтаар 5 төрлийн заалтын дагуу 98 заалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн мэдээллийг 120 гаруй байгууллага 10 мянга гаруй нээлттэй мэдээллийг байршуулсан байна. "Шилэн ажиллагаа"-г эрчимжүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг аймгийн төрийн цахим үйлчилгээний хэлтэс болон газартай хамтран төрийн бүх шатны 160 гаруй байгууллагын давхардсан тоогоор 640 албан хаагчийг хамруулан зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.	100%
141	245	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 32 дугаар тэмдэглэл 2024-09-11 Дугаар 2024_32	32.6.2. 2.1.Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр өгсөн даалгаврыг хэрэгжүүлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сумдын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэхийг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт, төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд()	Аймгийн хэмжээнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй 4, төлөвлөгөөгүй 10 сум байгаагаас 2024 онд Хатанбулаг, Иххэт, Хөвсгөл, Улаанбадрах, Сайншанд зэрэг 5 сумд төлөвлөгөөг хийлгэхэд шаардагдах зардлын асуудлыг орон нутгийн төсөвт тусган шийдвэрлэсний дагуу сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраар хянуулж, холбогдох саналыг авч, баталгаажуулан холбогдох сумдад хүргүүлсэн. Хөвсгөл сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг ОНТ-ийн 35 сая, Хатанбулаг сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг ОНХС-ийн 153 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус тус "Голден мэг" ХХК гүйцэтгэж байна. Улаанбадрах сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг ОНХС-ийн 105 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Ланд Овнер" ХХК, Иххэт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг ОНТ-ийн 51.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Инженергеодези" ХХК гүйцэтгэж байна.	100%
142	246	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэл 2024-10-02 Дугаар 2024_35	14.7.2. Газрын эрхийн давхцалтай 6206 зөрчлийг арилгах, тусгай хамгаалалттай газар нутагт олгогдсон 4953 нэгж талбар газрын эрх болон уул уурхай, ашигт малтмалын зориулалтаар олгогдсон 447 нэгж талбар газрын эрхийг баталгаажуулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгав;	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас хяналт шалгалтын ажлын хэсгийн мэдээллийг 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1/3253 дугаар албан бичгээр ирүүлсэн. Хяналт шалгалтын дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	70%
143	247	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.11.3. Энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэгт зааснаас гадна захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа өөрийн салбарын бусад шийдвэрийг дараах чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хариу мэдэгдэхийг бүх шатны захиргааны байгууллагын удирдлагад даалгав: (Үүнд :3.1.хүчингүй тоот тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.2.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.3.нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийгдээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.4.хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.5.хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.6.захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэлгүй даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх; 3.7.энэ тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.) заалт бүрээр биелэлт ирүүлэх.	Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захиргааны хэм хэмжээний актын судалгааг гаргаж хүчингүй болсон, ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй байгаа, нэмэлт өөрчлөлт орсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, хуулиар тусгайлан эрх олгосон боловч батлаагүй, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлээгүй дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 2024 оны 01/682 тоот албан бичгээр Х сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 1 дүгээр улиралд батлан гаргасан А, Б тушаалыг татаж хянаад ЗДТГ-ын даргын 2024.04.12-ны өдрийн 03/220 албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн. ЭМТ нь тушаал гаргах бүрдээ төслөөр тогтмол хянуулж байна. Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалыг төслөөр тойрох бүрт хянаж санал зөвлөмж өгч ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар захирамж 130, тушаал 137 нийт 267 шийдвэрийн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Худалдаа үйлчилгээний түр зөвшөөрөл олгох тухай журмын төслийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж хууль зүйн яаманд хянуулж дугаар авахаар хүргүүлсэн. Аймгийн засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох" тухай А/774 дүгээр захирамж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 6985 бүртгэлийн дугаартай бүртгэгдэн хэрэгжиж эхэлсэн. Сумын хэмжээнд нийтэд зар мэдээллийг ЗДТГ болон бусад сайтаар нийтэлсэн. Сумын хэмжээний согтууруулах ундааны худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 8 ААНБ-д хувилан өгч гарын үсэг зуруулж	100%
143	248	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэл 2024-11-13 Дугаар 2024_39	39.29.12.3. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг тодорхой албан тушаалтанд хариуцуулж, үйл ажиллагааны болон кибер аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсвийн төсөлд тусгаж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт	Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, Мэдээлэл технологийн үндэсний парк УТҮГ-тай хамтран "Кибер аюулгүй байдлын тухай хууль", "Хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль" хэрэгжилтийг хангах, цахим ур чадвар, төрийн бүтэцмжийг нэмэгдүүлэх чиглэлээр танхим болон цахимаар дамжуулан 10 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт давхардсан тоогоор 1100 албан хаагчийг хамруулсан. Сум, орон нутгийн телевизүүдтэй хамтран нөлөөллийн аяны хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 5 төрлийн тоон контент үйлдвэрлэж цахим орчинд түгээж хүүхдийн эрхийн сайн дурын ажилтан, идэвхтэн багш, "Монголын аюулгүй байдлын академи НҮТББ"-тай хамтран 14 сумд, Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 сургуулиудад 113 удаагийн сургалтаар 13,234 сурагч, эцэг, эхийг хамруулж, сурагч багш балтгах, мэдээ мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Мөн "Сурагчийн аюулгүй байдал" цахим номыг 1500 ширхгийг тарааж ажилласан. Төрийн болон төрийн өмчтэй 96 байгууллага кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дотооддоо дагаж мөрдөх байгууллагын кибер аюулгүй байдлын журмыг батлан мөрдөн ажиллаж байна.	70%

	249		40.19.5.3. "Өвлийн идэш" арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт." гэжээ.	Махны хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, орон нутгийн малчид, хоршоолчдын малын махыг дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдэд шууд хүргэх зорилгоор "ӨВЛИЙН ИДЭШ" арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 12-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын томоохон зах, худалдааны төвүүдийг түшиглэн 8 байршилд зохион байгуулахаар төвлөдөг байна. Уг арга хэмжээнд Айраг сумын "Буман ашигт" хоршоо нь 30 тн, бусад 4 сумын 16 малчин 25 тн махыг нийлүүлэхээр урьдчилсан судалгаа гарсан. "Өвлийн идэш-2024" арга хэмжээний талаарх мэдээллийг орон нутгийн малчид, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 175 хоршооны 5533 гишүүнд "Масс мессеж" үйлчилгээгээр хүргэсэн.	100%
144	250	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40	40.19.7.2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийг тогтоосон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолыг сахин мөрдөж, тэдгээрээс зөрүүтэй газар зүйн нэр, зургийг үндэслэн аливаа хилийн цэстэй холбоотой маргаан үүсэхгүй байх талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	БХБСайдын 2023 оны 24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой үүссэн маргааныг судалж тогтоох, түүнийг шийдвэрлэх талаар холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг"-ээс Иххэт, Даланжаргалан сумдын удирдлага, холбогдох албан хаагчдын хамруулан цахим уулзалтыг зохион байгуулж, хуралд оролцогчдын санал хүсэлтийн дагуу ажлын хэсгийн гишүүдтэй хамтарч Дорноговь аймгийн Иххэт сум, Хэнтий аймгийн Дархан сумын хилийн зааг болох "Балцангийн хар өндөр толгой" Дорноговь аймгийн Даланжаргалан сум Хэнтий аймгийн Дархан сумын хилийн зааг "Идэр майхан", "Дэвтээрийн овоон шанд", "Хүүхдийн хөшөөтэй толгой", "Хараат", "Цайдамьн улаан нуур", Дорноговь аймгийн Сайншанд, Сайхандулаан сумдын хилийн зааг "Цагаан дух" зэрэг газруудад очиж малчид, тухайн орчинд амьдарч буй иргэдтэй уулзаж, маргааныг судалж тогтоон холбогдох саналыг боловсруулж ажилласан.	100%
145	251	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 43 дугаар тэмдэглэл 2024-12-04 Дугаар 2024_43	43.6.2. Төсвийн жилд багтаан барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлөх боломжгүй, хэрэгжилт удаашралтай, зогссон төслүүдийн гэрээг дүгнэж, эцсийн тооцоог баталгаажуулан барьцаа хөрөнгийн данс дахь санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй 4 төсөл арга хэмжээний 7,1 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас Засгийн тогтоолд заасны дагуу гүйцэтгэлийн тайланг үндэслэн санхүүжилтийг олгох тухай гүйцэтгэгч компаниудад үүрэг чиглэл өгсөн. 4 дүгээр сард барьцаа хөрөнгийн данснаас Саранхөвөө театрын барилгын ажлын гүйцэтгэгч "Болор аргамба" ХХК-д гүйцэтгэлийн тайланг үндэслэн 696,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100%
ЗГ-ын албан даалгавар					
146	252	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	5. Алслагдсан сум, суурин газар, олон улсын авто замын дагуу болон аялал жуулчлалын бус нутагт харилцаа холбооны дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	"Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын дагуу "Төрийн үйлчилгээ-мэдээллийн төв"-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, төрийн үйлчилгээгээр 2 албан хаагчдыг Цахим хөгжил, харилцаа холбооны чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 12 сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн захирамжаар Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалыг "Иргэд олон нийттэй харилцах ажилтан" гэж албан тушаалын ангиллыг ТЗ-3 байсныг ТУ-7 болгон өөрчлөлт оруулж, албан тушаалын тодорхойлолтыг баталж өгсөн. Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит 145 байгууллагыг төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн системд бүртгэсэн нь 96 хувьд нэвтрүүлсэн байна. Системийн ашиглалтыг нэмэгдүүлэхээр төрийн болон төрийн өмчит байгууллагуудын бичиг хэргийн ажилтан, мэдээлэл технологийн ажилтан, хүний нөөцийн ажилтнуудад Цахим хөгжил харилцаа холбооны яам, "И-Монгол" академи УТҮГ-тай хамтран "ERP" системийн ашиглалтыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 540 албан хаагчийг хамруулсан. Цахим шилжилт, цахим засаглалыг эрчимжүүлэхээр 14 сумд, 20 сургууль, 65 багийн Засаг дарга нарт компьютер, техник хэрэгслийн шинэчлэлт хийж орон нутгийн төсвийн 1,200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн "Цахим аймаг" бий болох ажлын хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12/01 тогтоолоор "Цахим	100%
147	253	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1.Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2.Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3.Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих төлөвлөгөө, шийдлийг танилцуулах	Нийтийн эзэмшлийн талбайд цахим хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор утасгүй "free wifi" байгуулахаар мобикомтой хамтран судалгаа тооцоо хийж байна.	70%
148	254	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	1.14. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын реформыг хэрэгжүүлэхийг Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар"-ийг бэхжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг бус орон нутгийн хөгжлийн болон аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай уялдуулахад бүх талуудын оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгагч хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор "Орон нутаг дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын удирдах бүрэлдэхүүний зөвлөгөөн" -д оролцсон. Бус, орон нутгийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, аргачлал"-ын дагуу өөрийн аймгийн онцлогт нийцүүлэн илтгэл бэлтгэж танилцуулсан.	100%